



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-52

1.Хуулийн төслийг эцэслэн батлах	7
2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	7-37
3.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсох	41-52

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 27-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ё.Баатарбилэг, Э.Батиугар, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Дамдинням;

Хоцорсон: С.Батболд- 1цаг 35 минут, Б.Баттөмөр- 01 минут, Х.Булгантуяа- 01 минут, Д.Ганбат- 17 минут, Ц.Даваасүрэн- 01 минут, Т.Доржжанд- 07 минут, Б.Жавхлан- 12 минут, Г.Мөнхцэцэг- 04 минут, С.Одонтуяа- 01 минут, М.Оюунчимэг- 05 минут, Д.Өнөрболор- 23 минут, Ж.Сүхбаатар- 11 минут, Ц.Сэргэлэн- 21 минут, Д.Цогтбаатар- 24 минут, Б.Энх-Амгалан- 13 минут, Л.Энх-Амгалан- 01 минут, Б.Энхбаяр- 02 минут;

Тасалсан: Э.Бат-Амгалан, Н.Наранбаатар, Ш.Раднаасэд, Ч.Ундрам.

Нэг.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Г.Занданшатар: 1.Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 5

Бүгд: 47

89.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч М.Цолмон, Улсын дээд шүүхийн шүүгч Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Баасанжав, Б.Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 10 цаг 43 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Х.Ганхуяг, Л.Мөнхбаатар, Ц.Сандаг-Очир, М.Оюунчимэг, Ш.Адъяа нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, Улсын дээд шүүхийн шүүгч Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Баасанжав, Б.Ундрах нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 26 минут үргэлжилж, 12 цаг 32 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 13 цаг 59 минутаас эхлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар D-parliament platform-ийн D-Petition system-д 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар ирүүлсэн санал, хүсэлт, өргөдлийн талаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу мэдээлэл хийв./14:18/

Гурав. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсох

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга О.Ичинноров, Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнгөнсүх, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Д.Даваасамбуу нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Асуулгын хариуг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Н.Ганибал, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Асуулга асуусан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар” тавьсан асуулгын хариуг сонслоо.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн урилгаар Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 33 дугаар сургуулийн 8^ж ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар Олон улсын соц интерний залуучуудын байгууллагын Ази номхон далайн бүсийн чуулганы төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн Богд сумын 2 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Д.Өнөрболор, Ж.Эрдэнэбат нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 10^а ангийн багш, сурагчид, мөн Сэлэнгэ аймгийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн урилгаар Завхан аймгийн Яруу сумын ерөнхий боловсролын сургуулийн 1997 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн Дархан сумын Монгол Ардын намын хорооны дэргэдэх Ахмадын хорооны гишүүдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн харилцаа холбооны салбарын ахмад ажилчид, Социал демократ Монголын залуучуудын холбооны төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Налайх дүүргийн иргэдийн төлөөлөл, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын үндэсний зөвлөгөөнд оролцож буй цаг уурчдын төлөөлөл, Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуулийн 8^д ангийн багш, сурагчдын төлөөлөл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхцоож нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 30 минут үргэлжилж, 72 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 79.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 06 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Хуулийн төслүүдийг эцэслэн батална. Энэ бол Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл байгаа.

2 дугаарт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Монгол улсын ерөнхий сайдад хандаж “Ирээдүй өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн энэ хуульд заасан хэлэлцэхээр тогтсон асуудлын тов, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад үндэслэл бүхий саналаа чуулган эхлэхээс өмнөх өдрийн 17 цагаас өмнө ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Жамбын

Батсуурь нараас албан бичиг ирүүлсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үгээ татсан, тийм ээ. Үүнийг протоколд тэмдэглэхгүй бол болохгүй ээ. Пүрэвдорж гишүүн үгээ татсан.

Ингээд Жамбын Батсуурь гишүүн бичиг ирүүлсэн байна. Миний бие Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх хүсэлтэй тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгож өгнө үү гэсэн байна.

Ингээд Жамбын Батсуурь гишүүн үг хэлнэ.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Төсөв өргөн баригдаад ойролцоогоор сар орчим хэлэлцэгдээд явж байна. Дараа 7 хоногоос бас нэлээд жигдэрчих байх гэж ингээж бодож байна. Биднийг төсөв хэлэлцэх явцад бараг баталж амжаагүй байхад юмны үнэ гүйцэгдэхээ байлаа. Жишээлбэл, бензин шатахуун, түүн дотроо түлш үндсэндээ улсын хэмжээ орон нутагт бүгдэд нь тасарчихлаа. Тэгээд өвөл цас ороход бараг сар хүрэхгүй хугацаа үлдчихсэн. Бүх бүтээн байгуулалтууд түлшнээс болж зогсох хэмжээнд ингээд хүрчхээд байна. Кран, ковш гээд юу гэдэг юм портер, бонго гээд. Хөдөөгийн малчид яг намаржаанаасаа өвөлжөө рүүгээ нүүдэг. Хөдөөд явж байгаа портер, бонго-ны гол ажилладаг зүйл нь түлш байдаг. Тэгээд ингээд орон нутагт түлш 4 мянга даваад явчихлаа. Ганхуяг аа, би юм ярьж байна шүү дээ. Орон нутагт түлш 4 мянга даваад явчихлаа. Бүр ингээд ченж гарчихсан байна. Би та бүхэнд нэг зүйл харуулъя. Түлшийг газар дээр нь хүргэлтээр үйлчилнэ, хүргэлтээр үйлчилнэ. Ингээд нөгөө хуучин 90-ээд оны эхээр архи шагаар зарна гэдэг шиг түлш орон даяар тасарчихсан. Бүх бүтээн байгуулалтын ажил, нүүдэл суудал зогсчихсон байхад түлшийг хүргэнэ гээд ингээд утсаа тавьчихсан. Тэгээд энэ дээр манай Засгин газрын гишүүд, УУЯ, ЭХЯ

арга хэмжээ авахгүй юм уу? Яг энэ бүтээн байгуулалтыг юунд нь ашиглалтад өгөхгүй, хугацаанд, үхрийн сүүлэн дээр хутга гэж цас орохоосоо өмнө ингээд орон даяар түшиггүй болчихлоо. Тэгээд энэ түшиг шатахууныхаа үнийг цэгцлээч ээ. Энэ төсөв ярилцахад хэлэлцэхэд дагасан хууль гэж маш олон хууль орж ирдгээ болих хэрэгтэй байна.

Өмнөх 7 хоногийн чуулганы хуралдаан дээр АН дагасан хууль дээр Газрын тухай хуулиар завсарлага авсан. Тэрийгээ нэг бас нэг тийш нь шийдэл хийж байх шиг байна. Өнөөдөр дагасан хууль дээр энэ Төрийн албаны тухай хуулийн нэмэлт оруулалт тухай хууль гэж ингээж орж ирж байна. Тэгээд энэ дээр би та бүхэнд нэг заалт уншиж өгье. Төрийн албаны тухай хуулийн 23.9 дээр Улаанбаатар хотоос тухайн орон нутагт иргэнийг шилжилт хөдөлгөөнийг бүртгэл хийлгэж, төрийн захиргааны албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан иргэнийг 23.2-т заасан томилогдох хугацааг аймгийн төвийн сумд 1 жил хугацааг ажилласан жилийг 1 жил 3 сараар, аймгийн төвөөс бусад сумд жил ажилласан хугацааг жил 6 сараар ажилласан дээр дүйцүүлэн тооцно гэж. Энэ чинь тэгээд нөгөө Үндсэн хуульд байх тэгш эрхийн зарчим орон нутагт ажиллаж байгаа хүмүүсийг илт үгүйсгэсэн ийм заалт болж байгаа юм биш үү. Ер нь ингээд хууль дагуулж, хуулийн хулгай хийдгээ боливол яасан юм бэ гэсэн ийм санааг илэрхийлж байгаа юм. Яагаад вэ гэхээр орон нутагт ажиллаж байгаа хүмүүс 5 жил ажиллавал 5 жилээ л тооцогдоно. Улаанбаатар хотоос нэг хүн очоод тэнд ажиллахад адилхан 5 жил ажилласан мөртөө 7 юм уу, 8 жилийн тийм эрх авч байдаг. Ийм харьцангуй зүйлийг энэ хуулиар оруулж ирдэг нь бол болохгүй юм.

Дээр нь ингээд жилээ нэмүүлэх гээд Улаанбаатар хотоос захын сумдад ганц бие уугуул суугуул хүмүүс очоод, тэнд төрийн албыг бэхжүүлнэ гэхээсээ илүүтэй бараг бужигнаан, түжигнээн

тариад ийм зүйл Төрийн албаны хуульд бас төсвийг дагаж ингээж орж ирж байна. Тэгээд бодит нөхцөлүүд дээр нэр нь Төсвийн тухай хууль. Төсөв ирэх жилийн он жилүүдийн ажил амьдралыг шийдэх хууль гэххээд төсөв дагуулж орж ирж, орон тоо, нэмдэг агентлаг байгуулдаг. Бүр сайд үйлдвэрлэдэг. Мөн хотод байгаа ажилгүй хүмүүсийг орон нутагт ажлын байраар хангах нэрээр ийм дабл стандарт бий болгодог энэ нөхцөл байдлуудыг болиоч ээ гэсэн ийм санааг илэрхийлэх гэж байгаа юм.

Дээр нь Төсвийн тухай хууль дээр эмч нарын цалинг нэмнэ гэж сумын Эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг нэмнэ гэж заагдсан байгаа. Гэхдээ өрхийн эмнэлгийг ерөөсөө оруулаагүй. Гэтэл хүн амын чинь эрүүл мэндийг хангаж байгаа, анхан шатанд үзлэг хийж байгаа гол хүмүүс бол өрхийн эмч нар байгаа юм. Тэгээд энэ өрхийн эмч нарыг цаашид яаж явах юм бэ, Чинзориг сайд аа, та энэ дээр нэг жоохон анхаарч төсөв дээр анхаарахгүй бол өрхийн эмнэлэг гэж нэг орон байр ч байхгүй, бага чонор машин унаа, бензин тос ч байхгүй, дээр нь цалин цагаа нь хүрэлцэхгүй, санхүүжилт нь хүрэхгүй ийм зүйл байгаа юм. Тийм учраас энэ цалингийн нэмэгдлүүдэд өрхийн эмнэлгийн эмч нар үлдсэн байна гэдгийг бас ... /минут дуусав/

Г.Занданшатар: Одоо хэлэлцэх асуудалдаа орно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 5 дахь өдрийн өглөө 10 цагаас хууль эцэслэн батлах санал хураалт явуулна гэж заасан байдаг. Тэгээд гишүүд санал хураалт бэлтгэе. Дараа нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д зааснаар 7 хоногийн Баасан гарагийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Гишүүд бүгд идэвхтэй оролцох үүрэгтэй. Хуралдааны ирц хуулийн төсөл

эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулна гэж заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг эцэслэн батлах хувилбарыг бэлтгэж, гишүүдэд тараасан байгаа, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нийт гишүүдийн олонхоор хуулийн төслийг эцэслэн батлахаар заасан. Энэ заалтын дагуу нийт гишүүдийн буюу 39-өөс дээш гишүүний дэмжлэгээр хууль эцэслэн батлагдана.

Ингээд Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Дархлаажуулалтын тухай хуулийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Ингээд эхний санал хураалт. Өглөөний анхны санал хураалт учраас бүртгэлийн санал хураалт явуулчихъя. Би бас хатгалагт хамаагүй ордог хүн бас биш ээ.

Санал хураалт явуулъя.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Бат-Эрдэнэ гишүүн ээ, санал хураалт явуулах гэж байна. Суудалдаа сууя. Санал хураалтад бэлтгээрэй. Эцэслэн батлах санал хураалт. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталлаа.

10.17 цаг

Дараагийн асуудалд орно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ, Монгол Улсын ШЕЗ-өөс гаргасан 2022 оны мэдээнд Дүүргийн иргэний хэргийн анхан шатын шүүхийн хэмжээнд хэргийг хэлэлцэх нийт 39691 шүүх хуралдаан зарласнаас 21619 буюу 54,4 хувь нь хойшлогдсон байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэж байгаа дундаж хугацаа 30-120 хоног, зарим хэрэг 1-3 жилийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж байна. Энэхүү иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны удаашралтай байдалд хэргийн оролцогчийн хаяг тодорхой бус, шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг буюу нэг шүүгч туслахад ноогдох хэргийн тоо хэт их, үүнээс шалтгаалан 1 хэрэг шийдвэрлэх зардлаар 3 хэргийг шийдвэрлэдэг зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг боловч нөгөө талаас бага үнийн дүнтэй хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд тохирсон хянан шийдвэрлэх ажиллагаа 1 хэргийн удирдлагын эрх зүйн орчин бий болоогүйгээс үүдэлтэй байна.

Түүнчлэн 2022 онд Нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдсэн нийт 34083 хэрэг маргааны 8200 хэрэг буюу 24 хувь нь 11 сая төгрөгөөс бага үнийн дүнтэй хэргүүд байна. Эдгээр хэргийг шийдвэрлэсэн дундаж хугацаа 109 хоног байх бөгөөд нийт шийдвэрлэсэн бага үнийн дүнтэй хэргийн 3,6 хувь нь давж заалдах журмаар гомдол гаргасан бол 1,2 хувь нь хяналтын шатын шүүхэд хандсан байна. Иймд хүний зөрчигдсөн эрхийг хялбар, хурдан шуурхай, үр дүнтэй байдлаар шийдвэрлэх бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэх тусгайлсан

журмын эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх зорилгоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Энэхүү өөрчлөлтөөр:

1. Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн шаардлагад тохирсон хэрэг хянан шийдвэрлэх үр дүнтэй, хялбар тусгайлсан журмыг тогтоох бөгөөд энэ нь зөвхөн мөнгөн дүнд хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө гаргуулах нэхэмжлэлийн шаардлагад үйлчлэхээр тусгагдсан,

2 дугаарт, Мөнгөн хөрөнгийн дүнг 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тогтоож 6 төрлийн нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойллоо.

3 дугаарт, Хэрэг хянан шийдвэрлэх тусгайлсан зарчмыг тодорхойлж, нэхэмжлэл, шүүхийн мэдэгдэх хуудас гардуулах, хурдан шуурхай, цахим технологийн дэвшилийг ашиглаж болох зохицуулалтыг тусгалаа.

4 дүгээрт, Бага үнийн дүнтэй хэргийг 1 шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх зарчмыг тодорхойлж, цаасан болон цахим нотлох баримтыг шүүхээс үнэлэх зохицуулалтыг тусгасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хэргийн онцлогт тохирсон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны уян хатан зохицуулалт бий болж, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны удааширал багасаж, иргэдэд хурдан шуурхай, хялбар байдлаар үр дүнтэй үйлчлэх шүүхийн үйлчилгээний хүртээмж дээшлэх болно.

Эрхэм гишүүд ээ, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа танилцуулна. Индэрт урьж байна.

Ш.Адьшаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч бага үнийн дүнтэй, нэхэмжлэлийн шаардлага тохирсон хэрэг хянан шийдвэрлэх хялбар журмыг тусгах, тус ажиллагааг аль болох богино хугацаанд, хэргийн оролцогчийг чирэгдүүлэлгүй, хүндрэл багатай явуулахын зэрэгцээ тэдгээрийн эрх ашгийг дордуулахгүй, хэргээ шударгаар шүүлгэх боломжоор хангагдсан байх зэрэг зохицуулалтыг тусган, хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичигт шинээр үүрэг үүсгэхгүй бөгөөд процессын журмыг хөнгөвчилж өгснөөр төрөл болон иргэнд үүсэх нэмэлт зардал байхгүй гэж хууль санаачлагч үзсэн байна.

Уг хуулийн төслийг ди-парламент мн цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Учрал хуулийн төсөлд цахим нотлох баримтыг шүүхийн шатанд үнэлэх асуудлыг тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд бага үнийн дүнтэй хэргийг нэг удаагийн шүүх хурлаар шийдвэрлэхээр тусгасан нь иргэдэд чирэгдэл үүсэх эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн нэг зүйл өөрчлөгдөхөд бусад олон зохицуулалт дагаж хөндөгддөгийг анхаарах шаардлагатай байгаа талаар саналаа хэлсэн.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэнгийн урилгаар БЗД-ийн ерөнхий боловсролын 33 дугаар сургуулийн 8-ын Ж ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт хүүхдүүд, багш сурагчдадаа сурлага, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг өөрөө тогтох учир сур сур дахин сураад бай л гэж байгаа шүү дээ. Амжилт хүсье.

Одоо ажлын хэсгийг танилцуулна.

Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх, Нямдоогийн Баярмаа Улсын Дээд шүүхийн шүүгч, Батсүрэнгийн Ундрах ШЕЗ-ийн гишүүн Ундрах шүүгч байгаа юу? байна. Навагчамбын Баасанжав ШЕЗ-ийн гишүүн, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн

хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мөнхдэлгэрийн Цолмон ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ. Ширнэнбандийн Адъяаа гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүнийх ороогүй байна гэж байна. Оруулж өгөөрэй. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа.

Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Энэ гэр бүлийн маргаан гараад шүүхээр тэтгэмж авах тогтоолгодог. Тэгэхээр энэ хууль энд хамаарч шийдэгдэх үү? Одоо энэ гадуур эцэг эхчүүдтэй уулзаад, ээжүүдтэй уулзахад энэ тэтгэмжийн асуудал хамгийн их яригддаг юм. Ялангуяа энэ Гэр бүлийн тухай хууль өргөн баригдаад хэлэлцэх гэж байгаа ийм үед. Тэгэхээр энэ бага үнийн дүнтэй гээд орсон байна л даа. Тэгэхээр ер нь бол энэ тэтгэмж их бага үнийн дүнтэй ордог. Тэгээд бага үнийн дүнтэй болохоор үүнийг нь нэг их тоож, шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр хариуцаж байгаа хүн байдаггүй. Тэгэхээр энэ чиглэлээр ямар бодлого баримтлах юм бол оо? Энэ асуудал энэ хуулиар шийдэгдэх үү гэдгийг асуух гэсэн юм. Яагаад гэхээр нэг 4 жилийн өмнө бол шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр нэг 30 хувь нь л төлөгддөг гэсэн ийм мэдээ байсан бол сүүл рүүгээ бага зэрэг нэмэгдэж байгаа. Тэгэхээр 50 хувь байлаа ч гэсэн ерөөсөө эцэг эхчүүд салаад л маргаашаас нь нөгөө хүүхдийн эрх зөрчигдөж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлыг энэ хуулиар зохицуулсан юм бий юу? Одоо гэр бүлийн дагнасан шүүх бас байгуулна гээд ярьж байгаа. Гэр бүлийн дагнасан тэр хүүхэдтэй ажилладаг байцаагч юунууд гарна гээд нэлээн дэвшилтэт юмнууд сонсогдоод байгаа юм л даа. Тэгэхээр энэ бага үнийн дүнтэй хэргүүд гээд энд байгаа юм.

Тэгэхээр үүн дээр яаж энэ хуулиар зохицуулах юм бол оо. Зөвхөн хуулиар зохицуулах нь орж байна уу эсвэл үүнийг дараа нь энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр бас хэрэгжүүлэх энэ механизм процесс нь бас орж байна уу гэдгийг асуух гэсэн юм. Ганц л асуулт байна

Г.Занданшатар: Хэн хариулах билээ? 83.

Н.Жамъянхүү: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөр бид нар энэ бага үнийн дүнтэй хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны энэ процесс ажиллагааг хялбар, шуурхай, үр дүнтэй байдлаар явуулах энэ үндсэн зорилгыг тавьж бол энэ хуулийн төслийг боловсруулсан. Энэ дээр энэ 75.1 штрих дээр нийтдээ 6 төрлийн нэхэмжлэлийн шаардлагыг ялангуяа мөнгөн дүнтэй хэрэг дээр авахаар ингэж оруулсан байгаа. Үүнд энэ гэр бүлийн хэрэг маргаантай холбоотой юу бол нэхэмжлэл маргаан бол энэ дээр хамаарагдахгүй юм. Өөрөөр хэлбэл энэ нь тусдаа ердийн журмаар явах ийм процесс ажиллагаанд бол хамаараад байгаа ийм хэрэг байгаа.

Мөн энэ хуулийн төслөөр зөвхөн шүүх дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдолтой процесс ажиллагааг бол хамаарахаар байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны энэ процесс бол энэ хуулиар хамаарагдахгүй байгаад байгаа.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр. Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулна, нэмж хариулъя.

Б.Энхбаяр: Одонтуяа гишүүний хөндсөн гэр бүлийн шүүхтэй холбоотой. хүүхдийн тэтгэмж төлөх харилцаатай холбоотой асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн төсөлд тусгаж оруулж ирж байгаа. Ирэх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар Шүүх байгуулах тухай болон Гэр бүлийн тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Ингээд Засгийн газар дэмжих

юм бол Улсын Их Хуралд өргөн бариг баригдаж, хоёр 7 хоногийн дараа Улсын Их Хурлын гал тогоонд орж ирнэ. Одоогоор хүүхдийн тэтгэмж төлөлт хамгийн сүүлийн байдлаар бол 60 хувьтай байна гэдэг би мэдээллийг авсан. 60 хувь нь төлж байна, 40 хувь нь бол төлөхгүй байгаа юм байна. Тэгэхдээ энэ өмнөхөөсөө бас ахиж л байгаа тоо юм байна. Жилийн өмнө бол хүүхдийн тэтгэмж төлөлт 50 хувьтай байсан байна. Энэ 60 хувь болоход гол нөлөөлсөн асуудал нь бол шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүүхдийн тэтгэмж төлөөгүй этгээдийн гадаад зорчих эрх дээр хязгаарлалт тавих асуудлыг нэмэгдүүлсэн байна. Үүнтэй холбоотойгоор хүүхдийн тэтгэмж төлөлт бол бас 10 хувиар нэмэгдсэн байна гэдэг дүн мэдээллийг надад танилцуулсан байгаа.

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байгаа. Энэ дээр нэг 2, 3 асуулт байгаад байна.

1 дүгээрт, Энхбаяр сайд аа. Энэ иргэний процессыг бүхэлд нь янзалж үзэгдэх судалгаа ажил хийгдэж байгаа юу? Эсвэл энэ процессын энэ нэмэлт, өөрчлөлт орж ирээд ингээд иргэний процесс бол ер нь бүхэлдээ жигдэрчихсэн гэж ойлгож явах уу?

2-т, энэ хялбаршуулсан журам бол их зөв л дөө. Цаг нь болчихоод байгаа юм. Гэхдээ энэ ердийн шүүхээрээ явах юм уу эсвэл энэ жишээ нь Улаанбаатар хотод дагнасан энэ бага үнийн дүнтэй маргаан шийдвэрлэдэг шүүх байгуулах юм уу. Нөгөө Смолд Лэймс Корт гэж байдаг шүү дээ тийм ээ. Тэр нь ерөөсөө зөвхөн ийм бага үнийн дүнтэй юмнуудыг аваад л хялбаршуулсан журмаар шийдвэрлээд л яваад байдаг. Тэнд өргөдлөө өгнө өө, тэнд гомдлоо гаргана гэдэг бол нэхэмжлэл гаргана гэдэг бол ерөөсөө түүгээрээ явна гэсэн үг. Ийм дагнасан шүүх байгуулбал яадаг юм бэ?

3-т, ер нь энэ шүүх байгуулах хуулийн төсөл орж ирэх гэж байгаа гэж би ойлгоод байгаа. Энэ дээр энэ дагнасан шүүхийн асуудлууд хэр орж ирэх вэ? Жишээ нь гэр бүлийн шүүхийн асуудал байна. Зарим тохиолдолд хөдөлмөрийн маргааны асуудлууд байна. Эсвэл энэ татвар санхүүтэй холбоотой тусад нь такс корт гэж байгуулсан ч болохоор болчхоод байна гэж би хараад байгаа байхгүй юу. Улаанбаатар хотод бол жишээ нь.

4 дэх асуулт, үнийн дүн нь бол яах вэ, ингээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй жинлүүлээд үзэхээр одоо бол нэг миний ойлгосноор 22, 23 сая төгрөг болж байна гэж ойлгох нь зөв үү тийм ээ. Тэгээд таны тайлбараас бол Европын холбоонд бол 5 мянган евро байдаг юм байна гэж ойлголоо. Энэ 22 сая төгрөг гэж арай өндөр биш үү. Манай Монголын нөхцөлд. Ер нь нийт шүүхийн хэрэг маргааны хэдэн хувь нь энэ 22 сая төгрөгөөс доош байна. Баярлалаа. Ийм 4 асуулт байна.

Г.Занданшатар: Зочид танилцуулна.

Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар Олон улсын соц интерний залуучуудын байгууллагын Ази Номхон далайн бүсийн чуулганы төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт нөхөд та бүхэндээ эв санааны нэгдэл, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлсэн эрхэм зорилго сайн сайхны мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Асуултад 82 гэсэн үү? 81 Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ ХЗДХ-ийн сайдын зөвлөх хариулна.

Д.Мөнх-Эрдэнэ: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Яг энэ үнийн дүнгийн хувьд бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 22 дахин нэмэгдүүлсэн буюу нийт одоогийн мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үржүүлэхээр 11 сая төгрөг

байгаа. Яагаад энэ дүн гарч ирсэн бэ гэхээр ер нь яах вэ, манай шүүхийн практикт энэ мөнгөн хөрөнгийн гүйцэтгэлтэй холбоотой нэхэмжлэл хэрэг маргааныг хэлэлцэж байгаа байдлыг харахаар нийт хэрэг маргааны 22 оны байдлаар бол 24 хувь ийм байгаа. Нийслэлийн хэмжээнд. Орон нутгийн хэмжээнд энэ тоо бас 13 орчим хувьтай байгаа. Тэгээд бид нар бас энэ дүнг гаргахдаа бас Европын холбооны жишээг бас харьцуулж үзсэн. Бас Солонгос, Япон гэх мэт улсуудын жишээг харьцуулж үзсэн. Тэгэхээр бас Европын холбоонд байгаа манай улстай бас ижил гараанаас гарсан Литва, Латви, Унгар, Румын гэх мэт улсуудад бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 600, 620, 700 гэх мэт ийм 1 сарын байдлаар тооцож үзэхээр ийм байгаа юм. Тэгэхээр нөгөө дундаж хэмжээ нь 5 мянган евро гээд ингээд тооцоод үзэхээр манайхтай бас нэг ийм жишиж харьцуулахад бол дүйцэхүйц ийм байгаа. Тэгээд нийт хэрэг маргааны маань 70 орчим хувь нь энэ ийм 11 сая төгрөг, нийт энэ хэрэг маргааны маань 11 сая төгрөгийн нэхэмжлэлтэй холбоотой нийт хэрэг маргааны маань 70 орчим хувь нь шүүхийн шатад хялбаршуулсан журмаар буюу талууд эвлэрэх, зохигчид эвлэрэх, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх гэх мэтээр шүүхийн шатад ийм хялбаршуулсан журмаар шийдэгддэг байгаа. Тэгээд давж заалдах шатны шүүхэд бол нийт хэргийн 3,6 хувь нь, хяналтын шатад 1,22 хувь нь ханддаг ийм статистик тоон мэдээллүүд байгаа учраас хэргийн үйл баримт, ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан үзээд бас бусад улсын жишгийг харгалзаж байгаад ингэж мөнгөн дүнг тавьсан байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Шүүх байгуулах тухай хуулийг чинь. Баярмаа ШЕЗ Улсын дээд шүүхийн шүүгч Нямдаваагийн Баярмаа 83. 82. Ажлын хэсэг 82

Н.Баярмаа: Шүүх байгууллагын хувьд дагнасан шүүхийг санал болгож

орж ирж байгаа. Энэ дээр гэр бүлийн шүүх, хялбар ажиллагааны шүүхийг бол дагнасан байдлаар байгуулъя гэж байгаа. Гэхдээ байрилын хувьд илүүтэй нийслэлд энэ шүүхүүдийг байгуулахаар төлөвлөж байгаа. Орон нутагт яаж ажиллах юм бэ гэхээр орон нутагт танхимын хэлбэрээр. Танхим гэдгийг бид бас ер нь дагнасан бол нэг төрөл өө гэж ойлгож байгаа учраас тэрийг бас хөгжүүлэх талаар ажиллаж байгаа. Харамсалтай нь бол хөдөлмөр юм уу татвар санхүүг бол энэ удаад яг дагнасан хэлбэрээр бол байгуулахаар шүүх байгуулахаар санал болгоогүй. Гэхдээ Шүүхийн тухай хууль дээр тухайн шүүх нь өөрийн хэргийн маргааныхаа төрлийг харж байгаад танхим байгуулах боломж нээлттэй байгаа. Тэгэхээр энэ цаашид бас хөгжих хэрэгтэй. Тухайлбал орон нутагт малын хулгай илүү их гардаг газар малын хулгайн хэргээр танхим байгуулах бол боломжтой.

Хөдөлмөрийн маргаан ч гэсэн аль нэг дүүрэг дээр түлхүү гарч байвал бас танхим байгуулах боломж нь хууль, эрх зүйн орчин нь байгаа юм гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ яг өнөөдөр хэлэлцэж байгаа энэ тусгай ажиллагааны хувьд үүнийг Хялбар ажиллагааны шүүхээр илүүтэй шийдвэрлэнэ. Тэгээд гол арга хэрэгслээ богино хугацаа байна. Дээрээс нь цахимжуулалт буюу цахим хавтаст хэрэг цахимаар мэдүүлэх, цахим нотлох баримтыг үнэлэх, шүүгч өөрөө шийдвэрээ цахим гарын үсэг, тоон гарын үсгээр гаргах, түүнийг мэдэгдэх процесс өөрөө илүү энэ техникийн дэвшилийг ашиглан гэж бол төсөөлж байгаа.

Г.Занданшатар: Тодруулж асууя. Оүнийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль дээр ийм заалтууд орж ирээгүй л дээ. Шүүх байгуулах тухай хууль өргөн баригдаагүй. Өргөн баригдсан хуулийн хүрээнд л хэлэлцүүлэг өрнөж байна. Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулж асууна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Би нэг ганц санал хэлчихье. Энэ хялбаршуулсан журмаар асуудлыг шийддэг болох гэж

байгаа бол уул нь энд яг дагнасан шүүхээрээ шийдүүлээд яваад байвал их үр дүнтэй юм болов уу гэж би зүгээр хараад байгаа юм. Тэгэхдээ дагнасан шүүхээ манай ШЕЗ-ийнхөн, Дээд шүүхийнхэн юу гэж бодож байгаа юм? Нэг хялбаршуулсан журмын шүүх гэж нэртэй байж бол зохихгүй ээ. Тэр чинь ерөөсөө гол онцлог нь болохоор үнийн дүн багатай маргаанууд л гэдэг л асуудал нь л тэр. Ерөөсөө гол ялгаа нь тэр байгаа байхгүй юу. Үнийн дүн багатай мөртөө хялбаршуулахгүйгээр хүн маргалдаж болно шүү дээ. Тэр эрх нь бас байж байгаа. Тэгэхээр ерөөсөө гол ялгагдаад байгаа юм нь үнийн дүн багатай смолд лэймс. Түүгээр л тэр хялбаршуулсан журмаараа явдаг, тэрийг нь дагнасан шүүх хийдэг байх юм бол энэ яг хүнд их өгөөжтэй. Шүүхийн ажлыг их хөнгөвчилсөн тийм шинэлэг зохицуулалт болох болов уу гэж би зүгээр саналаа хэлж байгаа юм шүү. Баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг, Дуламдоржийн Тогтохсүрэн, Гочоогийн Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Богд сумын 2 дугаар цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Манай Содномын Чинзориг гишүүн сайд бол давхар дээлтэй ч гэсэн хамгийн их хуралдаа идэвхтэй оролцдог. Харин ганц гэм нь дэндүү их ярьдаг л хүн байгаа юм.

Хэн хариулах билээ? Энэ санал байсан учраас Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууна.

Ж.Сүхбаатар: Энэ бас өмнө нь эрт орж ирэх ёстой байсан асуудлыг ингээд орж ирж байгаа бас явдал бол бас их чухал байна. Ер нь амьдрал дээр бол

маш их асуудал үүсдэг шүү дээ. Энд дотор бол 2 асуудал байна л даа. Нэг талаасаа иргэдийн хохирдог асуудал байгаа. Ажилгүй байсан хугацааны дундаж хөлстэй цалин тэнцэх олговор гаргуулна гээд л чирэгдээд л яваад байдаг. Тэгээд л олон сарын дараа нэг арай гэж нэг цалин хөлсөө нэг олговор гаргуулдаг. Гэтэл үүнийг ингээд хялбаршуулах гэж байна.

Нөгөө талаас та бүхэн мэдэж байгаа. Айлуудын доор СӨХ-ийнхөө мөнгийг төлдөггүй гээд л 5, 10 сая төгрөг төлдөггүй гээд л. Тэгээд зүгээр цахилгаан дулааныг нь нийтээр нь тасаллаа яана гээд байдаг. Нөгөө нөхөр нь төлдөггүй. Тэгэхээр энэ асуудлыг хүртэл шүүхээр ингээд оруулаад шийднэ гэхээр нийтийн эрх ашиг тэр коммунитинийнх нь эрх ашгийг нь хангах тухай асуудал байж байна. Энэ дотор СӨХ-ийн гишүүний үүргийн дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах асуудал орж байна. Бас барьцааны тухай асуудал байж байна. Тэгэхээр энэ болгон 11 сая төгрөг дотроо багтаад нэхэмжлэл гаргах юм бол ингээд шуурхай явъя гэж байгаа нь бол яг маш амьдралтай, олон хүн чирэгдүүлсэн хохироодог энэ зүйл бас ингээд цаг хугацаагаар чи чаддаг юм бол тэгээд гаргаад л авахгүй юу гээд л явдаг. Ийм яриа чинь үүнээс үүдэлтэй шүү дээ. Шүүх дээр очоод л чи олон сар болно, тэгээд чи яах юм гээд ингээд суугаад байдаг.

Тэгэхдээ энэ дээр би асуух гэж байгаа юм. Энд ингээд нийслэлийн хувьд ингээд маргаануудыг харахад ингээд хэргийг дунджаар 109 хоногт шийдвэрлэсэн байна. Ачаалал багатай газрууд дээр 37-75 хоног гэж байна. Энэ хууль гараад энэ хугацаа маань ер нь дунджаар яаж буурах бол гэдэг. Гаднынхан бол зардлыг нарийн тооцдог шүү дээ. Та хэд бол энд зардлыг нэг их тийм нарийн тооцсон юм алга. Ер нь хэдий хэрийн зардал гарахаар байж байгаа нь, зардал нь хэдий хэр буурах бол? Ер нь энэ Европын Холбооны чинь сүүлийн 20 жилд явуулсан бодлого нь бага үнийн дүнтэй иргэний хэргээс гадна, их үнийн дүнтэй бизнесийн хэргүүдийг хүртэл

өрсөлдөөнтэй энэ зах зээлийн нөхцөлд хугацаа алдахгүй байж өрсөлдөх чадварыг нь хангахын тулд яаж шуурхайлах уу гэдэг асуудал дээр чинь маш их ажиллацгаасан шүү дээ. Олон удаа зөвлөмжүүд гарч янз бүрийн байдлаар явж байгаа. Тэгэхээр бид бага үнийн дүнтэй дээр энэ удаа ингээд хийж байна.

Тэгэхээр их үнийн дүнтэй дээр ч гэсэн цаашидаа бол яг тэр тухайн улсын бизнесийн өрсөлдөх чадварыг дэмжих чиглэлээр нь ажилладаг юм байна лээ. Тэгэхээр түрүүн би хэн Мөнх-Оргил гишүүний хэлээд байгаа шиг тэр ер нь зохион байгуулалтын асуудал бол цаашидаа бол яригдах л байх л даа. Шүүх байгуулах тухай хуулийн хүрээнд ч гэдэг юм уу тодорхой цэгцтэй ингээд явах байх. Тэгэхээр би энэ зардал, хугацаа 2 маань яг ямар хэлбэрээрээ нэлээн буух бол гэдэг юм уу, шийдэгдэх бол, үүнийг зохион байгуулах нь мэдээж хэрэг бас шүүхийнх нь тэр хэрэг хянан шийдвэртэй холбоотой сургалт, тэр чиглэл юм эд нар дээрээ бол авч үзэх л байх л даа. Тэгэхээр энэ дээрээ бас өгмөөр байна. Одоо бол иргэдэд яг үүнийг ингээд ярихад өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудал бол яг иргэдийн СӨХ-ийнхөн бол бүүр хараад сууж байх асуудал болж байгаа байхгүй юу. Ажилгүй байгаа нөгөө нэг олговроо гаргуулж чадахгүй байгаа хүн энэ өчнөөн сар болно яана даа гэж байгаа хүн бол энэ Их Хурлын хуулийг хараад сууж байх ёстой байгаа байхгүй юу. Эд нар ер нь яг хийх гэж байна уу?

Барьцааныхаа юмыг хангуулж чадахгүй байгаа хүн бол бага хэмжээний 5, 6 саяын юмаа авч чадахгүй байгаа хүн энэ хууль гарчих юм бол ингээд шуурхай ийм шийдэгдчихдэг ийм тогтолцоо руу орох юм байна гэж харахаар байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр нь нэг жсоохон тийм тодруулга, тайлбар саяын юмнууд дээр хэлж өгөөч. Тийм ээ, 11 сая доторх төгрөгийн хэмжээний юмыг бид чинь илүү шуурхай шийддэг болох гээд байна шүү дээ. Гэтэл хүмүүс чинь нэг 5, 6 сая төгрөгийн асуудал өр зээл янз бүрийн

юм бодчихоор тэгээд л янз бүрийн гомдолтой байдаг шүү дээ. Тэгээд л ингээд өгөхгүй юм, чаргууцалдах юм, тэгээд шүүхэд нь өгөх юм, нөгөөдөх нь шийдэхгүй юм, ингээд л үндсэндээ хохирох юм. СӨХ дээр энэ их гарч байгаа. Лав л СӨХ болгоны тэр доор та бүхэн ингээд харахад нэг давхарт нь бараг ингээд хадчихсан л байж байдаг. Тэгээд л хүмүүс нь хамтдаа хохирно шүү гээд л гар ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ? 80 дугаар микрофон. Албан тушаал, нэрээ хэлээд асуултад хариулъя.

Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Миний бие Дээд шүүхийн шүүгч Баярмаа гэж хүн байна. Иргэний танхимын шүүхийн шүүгч. Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2 тодорхой асуулт асуулаа. Эхнийх нь бол ер нь энэ хууль батлагдсанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэрхэн үр дүнтэйгээр урагшлах юм бэ гэдэг асуулт байна гэж ойлгож байна. Энэ асуултад зүгээр миний бие нэг яг хуулийн төслийг цэвэр утгаар нь харах юм бол хуулийн төсөл энэ бага үнийн дүнтэй нэхэмжлэл гарснаар нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах буюу мэдэгдэх хуудас хүргүүлэх, шүүх хуралдааны тов тогтох, шүүх хуралдаан хийх, ингээд шийдвэр гаргах процессууд харьцангуй ердийн журамтай харьцуулбал хялбаршиж байгаа. Өөрөөр хэлбэл хугацаа тухайн тухайн шат бүр дээр алдахгүй байхыг аль болох өнөөгийн нөгөө цахим системтэйгээ уяж байгаад богиносгохыг хичээж байгаа. Зарчмын хувьд. Гэвч энэ дээр бол яалт ч байхгүй манай улсын өөрийн нэг бэрхшээл онцлог байна л даа. Тэр нь юу гэхээр хаягжилтын асуудал. Ер нь иргэний шүүх дээр хугацаа удаадаг 2 том шалтгааны нэг нь энэ хаягжилттай уялдаг. Иргэний шүүх өөрөө нэхэмжлэлээ хүлээж авдаг, өөрөө гардуулдаг, өөрөө мэдэгдэх хуудас, хурлын товоо хийдэг процесс ажиллагаатай, түүнд тусалдаг ямар нэгэн бусад систем гэж байдаггүй. Гэвч манай иргэдийн нэлээдгүй хувь нь хаяг дээрээ байдаггүй,

хаяг тодорхойгүй. Ер нь хаягжилтын систем нэлээд ард орхигдсон гэж хэлж болно. Энэ бол иргэний шүүхийн үйл ажиллагаанд хамгийн том сөргөөр нөлөөлдөг. Нэр хүндэд нь ч гэсэн сөргөөр нөлөөлдөг нэг хүчин зүйл байдаг.

2 дахь нь мэдээж шүүх хуралдаан хойшилж байгаа. Олон удаа шүүх хуралдаан зохигчийн хүсэлтээр хойшилж байгаа тохиолдол байгаа. Энэ 2-ыг хоёуланг нь аль болох өнөөгийн дэд бүтэцтэй суурилж байгаад шийдэхийг зорьсон байгаа. Тэгэхээр энэ мэдэгдэх хуудас гардуулах, тов тогтоох, нэхэмжлэлийг гардуулах, хариу тайлбар авах, хялбаршсан сайн процессыг бий болгож өгснөөрөө өнөөдөр тохирсон процессыг бий болгож өгснөөрөө энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж 109 хоногийн хугацаа ядаж 2 дахин багасгах болов уу гэсэн найдлага байгаа. Гэхдээ үүнийг үнэхээр хаана ч хэн ч баталгаа хийлгэх бол боломж байхгүй. Гэхдээ аль болох богиносгохыг хичээж байгаа. Эхлээд иргэний ердийн журмынхаа дагуу мэдэгдэх хуудсыг маань хүргүүлнэ. Үгүй бид нар өнөөдрийн технологийн бас дэвшилтэт бусад арга замуудыг хэрэглэнэ гэсэн ийм бодолтойгоор энэ хуулийн төсөл боловсрогдож байгаа.

Тэгэхээр энэ агуулгаараа хугацаа ямар нэг хэмжээгээр багасах байх. Харин шүүх хуралдаан олон удаа хойшилдог нөхцөл байдлыг иргэний энэ хялбар ажиллагааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим болж байгаа. 1 дүгээрт, үр үр дүнтэй байх, 2 дугаарт, мэтгэлцээний зарч ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт яах юм? Гүйцээгээд хариулчихъя Баярмаа шүүгч.

Н.Баярмаа: Мэтгэлцээний зарчим аман биш цаасан суурь дээр явах гэсэн үндсэн зарчмыг хуулийн төсөлд нэлээн хүчтэй суулгаж өгч байгаагаараа тэгээд арагшаа бусад заалтуудаараа дэмжиж байгаагаараа шүүх хуралдаан олон удаа

хойшилогдох боломж хязгаарлагдах юм. Тэгэхээр энэ агуулгаараа саяын ярьж байгаа 109 хоног маань хамгийн багадаа 2 дахин багасах энэ нөхцөл байдал руугаа дөхөх болов уу гэсэн ийм бодолтойгоор хуулийн төсөл дээр ажилласан байна.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу. Сүхбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Сүхбаатар: Би тодруулж асуухаа ч больё. Ер нь зүгээр манай энэ ажлын хэсгийн улсууд ч гэсэн Хууль зүйн сайд байж байна. Хэлэх юм нь, аль болохоор энэ дээр сая бол Баярмаа шүүгчийн хувьд бол 109 хоног маань бол ер нь 2 дахин багасах байх гэж байна. Тэгэхээр яг тэр чиглэл рүү оруулах хэмжээнд л нөгөө заалт, зохион байгуулалтын юмыг нь анхаарах ёстой. Мэдээж энэ хууль чинь бол яах вэ, юугаар шийдэгдэхгүй л дээ. Хууль баталснаар шийдэгддэггүй. Хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, явц, хэвшүүлж байгаа соёл, арга барил, техниктэй холбоотой асуудал байдаг. Тэгэхээр энэ хууль ингээд батлагдаад гараад ирэхээр зэрэг аль болохоор л яг л тэр хуулийнх нь зорилго руу л орох хэрэгтэй. Зардал буурна, хугацаа буурна, энэний төлөлтдөө юу яах вэ, тэр техник хэрэгслээ ашиглах байна уу, тэр зохигчдод юм хумаа гардуулдаг, баримт бичгээ хүргүүлдэг, ярьдаг тэр асуудлууд нь яах вэ олон удаа хойшилохгүй байх гэдэг юм уу энэ л чухал шүү. Энэ хуулийг ингээд л батлагдахад хүмүүс бол тодорхой хэмжээний ийм хөнгөн байх ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат, Ундрам, Өнөрболор нарын гишүүдийн урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны ЕБС-ийн 10-ын А ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Эрхэм багш, сурагчид та бүхэнд сурлагын өндөр амжилт, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Жамбын Батсуурь гишүүн асуултаа асууя.

Ж.Батсуурь: Баярлалаа. Тэгэхээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа юм. Гол нь гол дэмжиж байгаа шалтгаан нь бол энэ бага үнэтэй, бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шаардлага тохирсон хэрэг хянан шийдвэрлэх хялбар журмыг тусгаж, тус ажиллагааг аль болох богино хугацаанд, хэргийн оролцогчийг чирэгдэлгүй, хүндрэл багатай явуулахын зэрэгцээ тэдгээрийн эрх ашгийг дордуулахгүй, хэргээ шударгаар шүүлгэх боломжийг хангана гэж ингэж байгаа юм. Тэгэхээр энд энд л бидний дэмжиж байгаа гол зорилго гэж ингэж харж байгаа юм.

Гэхдээ нэг болгоомжилж байгаа зүйл бол нөгөө хэрэг хялбаршуулна гээд нөгөө авлигын хууль шиг юм болчих вий. Одоо юу гэдэг юм гэхээр том дүнтэй авлига аваад, газар дээрээ баригдаад, бүхэнд ил тод байж байхад хялбаршуулсан гээд 40 сая төгрөгөөр торгуулаад ингээд цайрчихдаг. Тэгээд энэ нь өөрөө нийгэмд бухимдал үүсгээд байдаг. Тэгэхээр хэдийгээр бага дүнтэй ч гэсэн хялбаршуулна гээд бас цаана нь яг түүнтэй адилтгах тийм хэлмэгдэл ч гэдэг юм уу, хүчтэй нь хүчгүйгээ дийлсэн ч гэдэг юм уу, ийм зүйл болох вий дээ гэж.

Тэгэхээр иргэний хэрэг шийдвэрлүүлэх гол хэцүү зүйл бол орон нутаг байдаг юм. Хоорондоо маргасан, эд хөрөнгийн маргаан, гэр бүл салалтын, хүүхдийн төлбөр гээд. Тэр багаас сум, сумаас аймагт ирж шүүх хуралд суунгуут олон дахин хойшилдог. Тэгэнгүүт нөгөө авах гэж байгаа мөнгөнөөсөө илүү их хэмжээний зардал чирэгдэл гаргаад байдаг. Тийм болохоор энэ нөхцөл байдлыг л бас анхаарч энэ хуулийн төслийг оруулж байгаа байх гэж ингэж бодож байна. Тэгэхээр аливаа хуулийг шинэчилж, нэмэлт оруулахад бол илүү сайн зүйлийг л хүсэж байгаа. Тийм учраас хамгийн гол нь манай хуулиудад тусаад байгаа зүйл бол

төвлөрсөн газруудын зүйлүүдийг цахим, хөнгөлөлттэй нөхцөлөөр шийднэ гээд байдаг. Тэгтэл орон нутагт байгаа хүмүүс маань тэр цахимд шилжиж чадаагүй, тэр утас шөрмөсөө сайн ашиглаж чадахгүй, тэр и-монголиа, бусад шинэ орчин цагийн зүйлүүдийг сайн ашиглаж чадахгүйгээсээ болж өөрөө энэ хохирлыг амсаад байдаг. Энэ тал дээр нь бас ингээд арга зүйн зөвлөгөө өгдөг гэдэг юм уу энэ нөхцөл байдлыг бүх шатын шүүхүүдэд анхаарах ёстой л доо. Яагаад вэ гэхээр энэ хуулийн төсөл батлагдсанаар шүүх болон шүүгчийн туслах янз бүрийн орон тоо нэмэгдэхгүй гэж байгаа юм. Миний бодлоор бол энэ шүүхүүд дээр нэг зөвлөн туслах орон тоо баймаар харагддаг. Яагаад вэ гэхээр хүн болгон өөрөө өмнөх ажлуудаа хийгээд байдаг. Хөдөө гадаанаас ирсэн хэл ул муутай, хүмүүст өөрийнхөө сэтгэл бодлыг нээж хэлж чадахгүй, цахим сүлжээ болон бусад зүйлүүдэд тийм ашиглаж чадахгүй, ах дүү, хамаатан садан муутай ийм хүмүүсийг зөвлөн туслах үйлчилгээгээр нэг оронтой байх юм бол би бол их олон зүйлийг хялбаршуулна маш олон хүнд бас буян болно гэж ингэж боддог.

Тэгээд надад бол асуугаад байх зүйл алга. Эдгээр миний хэлсэн зүйлүүдийг бас анхаарах юм бол энэ хуулийн төсөл бол бас ард иргэдэд, нийгэмд үр өгөөжөө өгөх боломжтой гэж ингэж харж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Батсуурь гишүүн байр сууриа илэрхийлээд үг хэлчихлээ, тийм ээ. Асуулт байхгүй гэж ойлголоо.

Одоо Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: Та бүхэнд бас өглөөний мэнд хүргэе. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хүрээндээ бас нэг энэ хялбаршуулсан горимоор, тусгайлсан журмаар аль болох бас нэг хэргийг шуурхай шийдвэрлэх, чирэгдэлгүйгээр, хүндрэл багатайгаар

богино хугацаанд шийдвэрлэх ч гэдэг юм уу энэ ерөнхий зарчим орж ирж байгаа нь их сайн, зарчим нь зөв. Би зүгээр анхаарах ёстой нэг зүйл байгаад байгаа нь та хэд маань бас мэдээж тооцож үзсэн л байх. Бид нар ерөөсөө гол үндсэн суурь маань ерөөсөө шударга шүүхээр иргэдийг энэ шүүлгэх эрхийг нь хангах л асуудал байгаад байгаа юм. Эргээд шударга шүүхээр шүүлгэхэд тэр иргэдийн эрхийг баталгаажуулах асуудал бол Үндсэн хуулиар олгогдсон эрх байгаад байгаа юм. Тэгээд би зүгээр энд та бүхний оруулсан энэ заалт дээр болохоор нэг зүйлд нь бас нэг энэ Үндсэн хуультай зөрчилдөх асуудал үүсэх вий дээ. 75.1.3 дээр чинь тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд сөрөг нэхэмжлэл гаргах, анх гаргасан нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, хариуцагч нэмж татах, гуравдагч этгээд оролцуулах, нэхэмжлэгч хариуцагчийг солих эрхийг нь хаачхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө нэг Үндсэн хуулийн чинь суурь зарчим болсон шударга шүүхээр шүүлгэх гэдгийг чинь энэ эрх нь зөрчигдчих асуудал үүсчихгүй юу. Уг нь тэр хэрэг том байна уу, жижиг байна уу, бага үнийн дүнтэй байна уу, их үнийн дүнтэй байна уу, энэ Үндсэн хуулиараа хэрэг л бол хэрэг. Тэрнээс тэрийг том, жижгээр нь гэдэг юм уу, их, бага үнийн дүнтэйгээр нь ялгана гэсэн зүйл байхгүй. Тэгээд бага үнийн дүнтэй жижиг хэрэг учраас бид нар үүнийг хялбаршуулсан шугамаар явуулж байгаа. Тийм үүднээс танд ямар нэг байдлаар сөрөг нэхэмжлэл гаргах эрх байхгүй ээ. Та юу гэдэг юм, анх гаргасан нэхэмжлэлийнхээ хэмжээгээр юу гэдэг юм, шаардлагаа нэмэгдүүлэх эрх байхгүй ээ гэж хааж байгаа чинь зарчим нь зөв юм уу гэж асуудал тавиад. Би тэгэхээр яах вэ, зүгээр зарчим нь зөв. Та бүхний оруулж ирж байгаа суурь. Үндсэндээ бид нар энэ хавар шүүх дээр очиж үзсэн. Баянзүрх болоод ХанУул дүүргийн шүүхүүд дээр үндсэндээ энэ шүүхийн ачаалал бас үндсэндээ аймаар болчихсон юм байна лээ. Хүндхэн болчихсон юм байна лээ. Би буруу дуулаагүй бол бараг 100 мянган хэргийг шүүдэг. Өдөрт бараг шүүх болгоноор л

400-1000 гаруй хүн ирж шүүхээр үйлчлүүлдэг гэсэн судалгаа байсан.

Тэгэхээр бид нар аль болох л энэ шүүхийн ачааллыг бууруулах, шүүхийн үйлчилгээг түргэн шуурхай болгох үүднээс үүнийг оруулж ирж байгаа нь зөв. Гэхдээ дараа нь энэ хууль батлагддаг, дахиад нэг Үндсэн хууль зөрчсөн гэдэг юм уу, ийм маргаан руу орчих вий гэсэн нэг тийм болгоомжлол байгаад байгаа, 1 дүгээрт. Тэгэхээр үүнийг та бүхэн маань бас яаж харж байгаа юм бол доо. Бид нар аль болох л нөгөө Үндсэн хуулийн түрүүний яриад байгаа л иргэн төвтэй шүүхтэй болъё, шударга шүүхээр шүүлгэх эрхийг нь баталгаажуулъя. Нөгөө нэг иргэдийн чинь итгэлийг хүлээсэн шүүхтэй болох гэдэг л үндсэн суурь зарчмын чинь л асуудал бас эсрэг болчих вий дээ гэсэн болгоомжлоод байгаа юм.

2 дахь нь, энэ дээр орж ирж байгаа нь цахим нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэнэ ээ гээд байгаа юм. Цахим нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэнэ ээ гээд байгаа юм. Тэгээд би бол бодит байдал дээр тэр энэ дүүргүүдийн шүүх дээр очоод үзэхээр, аймгуудын шүүх дээр ч гэсэн очоод үзэхээр яг үндсэндээ ийм цахим баримтад тулгуурлаж хэрэг шийдвэрлэх тийм дэд бүтэц боломж бололцоо нь та бүхэнд байгаа юм уу. Үндсэндээ дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжөөсөө авхуулаад ч гэсэн аягүй хүнд л юм байна лээ шүү дээ. Яг энэ хууль гардаг, цаашидаа ирэх жилээс ингээд хууль хэрэгждэг, тэгээд бараг л буруу хараагүй бол 10, 15 жилийн өмнөх л нөгөө нэг пентюм 3, 4 ч гэдэг юм уу бараг л тийм компьютертой байдаг юм байна. Бид нар чинь ерөөсөө улс ер нь төр орхичихсон гол үндсэн бас нэг салбар чинь бол ер нь шүүх байдаг юм байна шүү дээ. Тэгэхээр бид нар үүнийг цааш цаашидаа анхаарахгүй бол эргээд нэг ийм сайхан тунхаг шинж чанартай байдал хийгээд байдаг, бодит байдал дээр асуудал нь хэрэгжих боломж бололцоо байхгүй, дэд бүтэц байхгүй л нэг иймэрхүү л зүйл рүү л яваад байх шиг байна. Тэгэхээр давхар л бид нар энэ

асуудлыг нь анхаарч л явахгүй бол болохгүй л юм байна лээ дээ л гэсэн бас нэг сүүлийнх нь бол санал маягтай л зүйл хэлье.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн гишүүнээр асуултад хариулъя. ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр асуултад хариулъя. Ажлын хэсгээс нэмж хариулж болно.

Б.Энхбаяр: Тэмүүлэн гишүүний болгоомжилж байгаа тэр процесс тусгай журмаар шийдвэрлэхтэй холбоотойгоор 75-ын штрих 1.3-д зарим нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, хариуцагч нэмж татах, гуравдагч этгээд оролцуулах, нэхэмжлэгч, хариуцагчийг солих, эрх залгамжлах ажиллагаа хийхгүй гэдэг энэ асуудал бас Монгол Улсын Үндсэн хуулийн зөрчил болох вий гэдэг дээр бас болгоомжид хэлж байна. Бид энэ нэг асуудлыг бас хэлэлцүүлгийн шатад анхаарна.

Монгол Улсын ҮХЦ-ийн 2 удаагийн дүгнэлт бол байгаа. Нэг нь, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дээр ийм тусгай журам хийгээд зарим эрхийг хязгаарласан асуудал дээр Үндсэн хууль зөрчөөгүй гэж гарсан нэг дүгнэлт байгаа. Мөн зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор зөрчлийн хэрэг дээр 3 шатын процессоор явахгүй мөн их тусгай журмаар алх тогшидог шүүхийн журмаар явах энэ процесс дээр мөн Үндсэн хууль зөрчөөгүй гэдэг ийм шийдвэр гарсан байдаг. Ер нь манайх энэ Үндсэн хуульд заасан иргэний шударга шүүхээр шүүлгэх эрх гэдэгт яг юуг ойлгох вэ гэдэг бол өөрөө онолын асуудал. Урьд нь бол үүнийг бол зөвхөн 3 удаагийн шүүхээр гурвуулангаар нь явж байж дуусахыг шударга шүүхээр шүүлгэх эрх гэж ойлгоно гэж иргэд их ҮХЦ-д хандсан байдаг. Үндсэн хууль тогтоогч бол анх үүнийг ойлгохдоо 1937 оных шиг хуулиар байгуулагдаагүй Онцгой бүрэн эрхт комисс гэдэг нэрээр шүүн таслах ажиллагаа явуулж олон мянган иргэдийгээ хэлмэгдүүлж байсан гацуун түүхийг давтахгүйн тулд зөвхөн УИХ-

аар буюу хууль тогтоох Үндсэн хуулийн дээд байгууллагаар байгуулагдсан хууль ёсны шүүхээр шүүгдэх эрх гэж ойлгож Чимэд багш бол бас үүнийг ярьсан байдаг нь ийм учиртай.

Мөн шударга шүүхээр шүүлгэх эрх гэдэг энэ агуулга өөрөө шүүхээр хэргээ шударгаар шүүлгэх эрх гэж бид ер нь ойлгох учиртай юм байгаа юм. Шударга шүүх, шударга бус шүүх гэдэг хууль зүйн ойлголт бол байхгүй. Тийм учраас энэ өөрөө томъёоллын хувьд бол бас бид агуулгын хувьд үүнийг залруулж бас явж байх ёстой юм байна гэж үздэг. Ер нь дэлхийн бусад бүх улс оронд 3 шатын шүүхээрээ дамждаг тийм хэрэг маргаан гэж угаасаа байхгүй байдаг.

Мөн энэ хялбар хэргийн шүүхтэй холбоотойгоор илүү процессыг хялбарчилсан ийм үйл ажиллагаа бас бүх улс оронд байгаад байгаа. Мөн Тэмүүлэн гишүүний асуулт дээр нэмээд бас ажлын хэсгээс тодруулаад хариулчихъя.

Л.Мөнхбаатар: 80 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсэг хариулъя.

Н.Баярмаа: 2 асуулт асуусан байна. Эхнийх нь асуулт дээр сая Энхбаяр гишүүн хариулчихлаа. Гэхдээ би бас энэ дээр тодотгох юм байгаа гэж бодоод байна. Юу гэхээр энэ 75-ын итрих 1.3 буюу саяын энэ дурдсан ажиллагаануудыг хийхгүй гэж энэ хуулийн төсөлд заасан нь энэ нь үндсэндээ огт хийхгүй гэсэн үг ерөөсөө биш. Энэ ажиллагаа энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хялбар журмын үзэл баримтлалын шинжтэй нэг зүйл нь дурдагдсан 6 төрлийн нэхэмжлэлийн шаардлагыг эхлээд хялбар журмаар шүүхэд гаргана. Тэгээд 2 дахь зарчмын шинжтэй нэг шийдэл байгаа нь хялбар журмыг хүсэхгүй бол зохигч этгээд өөрөө ердийн журам руу шилжих боломжтой. Хүсэлтээ гаргаад шийднэ.

Ердийн журам руу шилжих 2 үндэслэл байгаа. Нэг нь тэр зохигчийн хүсэлт, нөгөө нь магадгүй шүүх цахим болон цаасан баримт дээр суурилоод

бичгийн хэлтсүүд мэтгэлцээний зарчмаар энэ асуудлыг шийдвэрлэх нь хэргийг үр дүнтэй шийдвэрлэхэд саад учруулахаар юм байна гэж үзвэл шүүх өөрөө ердийн журам руу шилжүүлж болно. Хэрэв хэргийн зохигч сөрөг гаргахыг хүсвэл, шаардлагаа нэмэгдүүлэхийг хүсвэл, эсвэл хариуцагч дахиад нэмж татахыг хүсэх юм бол ердийн журам руу ажиллагааг шилжүүлэхийг ийм шаардах хүсэлтээ гаргах хууль зүйн боломж нь бол нээлттэй хэвээрээ байгаа.

Ер нь анхан шатын шүүх дээр энэ ажиллагаа эхлээд орж ирэхэд нэхэмжлэгч ба хариуцагч талаасаа аль аль нь ажиллагаагаа хурдан дуусгах сонирхол нийлэх тохиолдол нэлээд элбэг. Хүн болгон хойшлуулъя, удаашруулъя гэсэн бодол байдаггүй. Тэгэхээр энэ хүсэлтийн журмаар ердийн ажиллагаа руу шилжих процесс бол тохиолдохын хувьд тохиолдоно. Тэгэхдээ тийм элбэг тохиолдоно гэж бодохгүй байна. Нэгэнт Үндсэн хуулийн эрх учраас бид нар үүнийг хааж болохгүй гэдгийг ажлын хэсэг маш сайн ойлгож байгаа. Тэгээд энэ агуулгаараа үүнийг шилжих боломжтой гэдгийг нээлттэй орхисон байгаа гэдгийг бас бол хэлмээр байна.

Л.Мөнхбаатар: 84 дүгээр микрофон өгье, ажлын хэсэг хариулъя.

Б.Ундрах: Баярлалаа. Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Тэр цаасан болон цахим нотлох баримттай холбоотой асуултад хариулъя. Энэ хуулийн төсөлд бол тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, цаасан болон цахим нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэх зарчим үйлчилнэ л гэсэн байгаа. Тэгэхээр яг энэ тохиолдолд бол процессын үндсэн зарчим буюу мэтгэлцэх зарчим бол хэвээрээ байна. Цаасан болон нотлох баримтыг бол талууд өөрсдөө бүрдүүлдэг. Тэгэхээр аль нэг хэлбэрээр буюу цаасаар, цахимаар аль нотлох баримтаар тэр хүн бүрдүүлж өгнө, тэрийг бол аль алиныг нь үнэлнэ л гэсэн утгатай.

Цахим баримт бол өөрөө дотор 2 янз байгаа. Процессын хуулиар ойлгоход бол. Нэг нь анхнаасаа бүрдэхдээ цахим хэлбэрээр бүрдсэн, дараа нь цаасан хэлбэрийг цахим хэлбэрт шилжүүлсэн ийм 2 хэлбэр байгаа. Тэгэхээр аль ч тохиолдолд талуудын гаргаж өгсөн баримтыг шүүх үнэлнэ ээ л гэсэн ийм агуулгаар орсон байгаа. Тэгэхээр цаасныг өгвөл цаасныг, цахимыг нь өгвөл цахимыг нь. Тэгэхээр аль нэг хувилбараар бүрдүүлэхийг бол шаардахгүй л гэсэн үг. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: 82 дугаар микрофоныг өгье. Манай ажлын хэсгийн гишүүд нэр, албан тушаалаа хэлээд хариулаарай. Яагаад гэвэл протоколд үлддэг, хэний асуултад хэн хариулаад байгаа нь их тодорхой байх ёстой юм шүү.

ШЕЗ гишүүн Баасанжав байна. Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр одоо бол яг дэд бүтэц чинь бэлэн юм уу гэдэг энэ бол үнэхээр суурь асуулт байна. Шүүхийн яг нөхцөл байдалтай танилцсан хүмүүс бол яг энэ асуултыг асуух нь бол зүйн хэрэг. Одоо яг бид нарын хэрэглэж байгаа хардвэй болон софтвэйр буюу техник тоног төхөөрөмж болон системийг харах юм бол яг маргаашаас бол энэ цахимаар хэрэг хянан шийдвэрлэнэ гэвэл бол нэлээн хүндрэлтэй. Гэхдээ бид софтвэйр талдаа буюу системийг бол хөгжүүлэх зайлшгүй үүрэг хүлээчихсэн. Шүүхийн тухай хуулийн 71.1.27 буюу зохиогчийн эрхтэй холбоотой болон түүнтэй холбогдох бусад эрхийн маргааныг цахим платформ үүсгээд шийдээрэй гээд аль хэзээ хуульдаа хийчихсэн.

Тэгэхээр нэгэнт и-платформыг хийх үүрэг гүйцэтгэсэн бол тэр платформоор бид энэ хялбар ажиллагааны хэргийг шийдэхэд яагаад болохгүй гэж. Үр ашигтай л байх ёстой болно. Гэтэл нөгөө хардвэй буюу техник тоног төхөөрөмж, дээр нь хүний нөөц маань яг энэ цахим технологи дээр ажиллах, систем дээр ажиллах, тийм

шаардлага хангасан бүр нэн чухал нь бол тоног төхөөрөмж нь байгаа юу гэвэл одоо энэ бол санхүү төсвийн асуудал болоод явж байгаа. Миний ойлгосноор бол энэ 24 оны төсөв дээр ШЕЗ-ийн цахимжуулалт гээд байгаа нь илүү систем талынх нь зардлыг одоогоор хасаагүй үлдээд, харин бусад зардал буюу яг энэ техник тоног төхөөрөмжийн зардлыг бол нэлээн хасчихсан гэж ойлгож байгаа. Тэр тохиолдолд бид системээ хийчхээд байдаг, системийг ажиллуулах тоног төхөөрөмж дээр яг ийм гацах байдал үүсээд байгаа. Тэгэхээр бол яг нөгөө талд нь энэ хууль баталбал энэ хууль амилах яг явах гол суурь болсон дэд бүтэц, түүний техник тоног төхөөрөмж, хүний нөөц тогтвортой ажиллах тэр тал тэгээд байр байшинг одоо тэр байр байшин гэдэг дотор чинь нөгөө Ай ти-ийнх нь бид нар серверээ байршуулна, ай ти жижиг центртэй байна. Тэгэхээр тэрийг бас харгалзан үзэж УИХ баталж өгөх байх л гэж ойлгож байгаа.

Энэ хууль батлагдвал дагаад төсвийн асуудал бас нааштай шийдэгдэх байх гэж бид бол ойлгож байгаа. Тийм хүлээлттэй байна.

Л.Мөнхбаатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Тэгвэл саяын тэр 75-ын итрих 1.3-аа та хэд маань бас томъёолол дээр нэг анхаараарай. Сая талууд хэрэв хүсвэл нөгөө I ердийн журам руугаа шилжиж болно. Тэр эрхийг нь гаргаж өгсөн гээд байгаа. Гэтэл нөгөө эрхийг ердийн журам руу шилжих асуудлыг нь шүүх шийдвэрлэхээр байгаа юм биш үү? Шууд хүсэлтийнх нь дагуу шууд шилжчихэж болдог процессыг заавал ч үгүй шүүх тэнд оролцоод шүүх түүн дээр нь юу гэдэг юм, ямар нэг захирамж юм уу, шийдвэр гаргаад ингээд оролцоод эрхийг нь хязгаарлаад байх чинь ер нь зарчмын хувьд зөв юм уу? Тэгэхээр энэ чинь өөрөө бас эргээд нэг сөрөг талтай, эргээд магадгүй тэр лүү шилжүүлэхгүй ч гэдэг юм уу, эсвэл

захирамж нь гарахгүй ч гэдэг юм уу, ингээд нэг удаашируулдаг, хүндрэл чирэгдэл учруулдаг нэг тийм бас нэг процесс болчих вий дээ л гэсэн болгоомжлол байгаад байгаа юм. Түүн дээр та хэд маань бас яаж харж байна?

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

Шүүгч Баярмаа Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. 75-ын итрих 6.1 дээр зохигч шүүх хуралдаан эхлэхээс өмнө хүсэлт гаргасан бол хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлнэ гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ дээр дунд нь шүүгчийн ямар нэгэн байдлаар дэнслэх асуудал бол энд байхгүй. Ер нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ шилжүүлгийн энэ процесс өөрөө шүүгчийн захирамжаар баталгаажих нь зөв л дөө, 1 дүгээрт. 2 дугаарт, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд ер нь бол иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлтийг шийдвэрлэхгүй удааширдаг тохиолдол бол би тун цөөхөн гэж ойлгож байгаа. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа хүсэлтийг 7 хоногийн дотор шийдвэрлэх ёстой, гарсан даруйд нь. Ер нь иргэний хэргийн шүүхийн практикт энэ хугацаа төдий л ер нь зөрчигддөггүй гэж хэлэхэд болно. Харин үүнийг гаргасныгаа дараа нь албажуулах асуудал, эсвэл амаар танилцуулах асуудал, албажсан захирамжийг ирээд гардаж авах тухай асуудал дээр зарим нэгэн практик зөрчил байсан байхыг бол үгүйсгэхгүй. Энэ тохиолдолд, бидний тохиолдолд шүүгчийн дэнслэх асуудал байхгүй, хянан шийдвэрлэх ажиллагаанд хүсэлт гаргасан байх нь шилжихэд хангалттай гэдэг агуулгаар боловсруулагдаж орж ирж байгаа.

Л.Мөнхбаатар: Дахиад тодруулах юм уу? Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Бас нэг асуудал нь яах вэ та хэд нөгөө шүүхийнхээ үйл ажиллагааг л илүү аль болох богино хугацаанд иргэдэд хүндрэл чирэгдэл багатайгаар хийе гэдэг үндсэн дээр хийж байгаа зарчим маш сайн. Үүнийг ингээд үргэлжлүүлээд явах нь зүйтэй. Бас нэг дутуу орхигдуулаад байгаа оруулж ирэх ёстой ч гэдэг юм уу, бид нар ер нь шүүхийн тогтолцоо дээр ерөөсөө анхаарч үзэхгүй байгаад байгаа нэг зүйл чинь энэ эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг бас нэг илүү идэвхжүүлэх асуудал биш үү. Бид нар чинь шүүхийн үйл ажиллагаа танилцахад ерөөсөө уг нь олон улсынхаа практикаар илүү эвлэрүүлэн зуучлах асуудал дээрээ илүү хөрөнгө мөнгө тавьдаг, илүү юу гэдэг юм тэндээ нь зөвлөх үйлчилгээг нь үзүүлдэг, тэр байр савыг нь аятайхан болгодог тэгж байж бараг нийт хэргийг чинь бараг 70, 80 хувь нь ч юм уу анхан шат дээрээ шүүх рүү бараг орохоосоо өмнө эвлэрээд, зуучлаад, ингээд эвлэчихдэг, тохиролцдог байдал руу уг нь шийддэг л юм байна л даа. Тэгтэл манайд ерөөсөө хамгийн их орхигдоод байдаг чинь бараг энэ болчихоод байгаа юм шүү. Бүгдийг нь л бараг шүүх рүү явуулаад байдаг л ийм процесс яваад байдаг. Тэгэхээр энэ дээр ер нь бид нар яаж анхаарах ёстой юм бэ? Ямар нэг шинэчлэл хийх ёстой юм бэ? Ямар өөрчлөлтүүдийг ер нь бараг энэ шүүхийн хуулийн хүрээнд хийх ёстой юм бэ? Энэ рүү нь чиглүүлэхийн тулд олон улсынхаа практик руу нийцүүлэх үү?

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. Эвлэрүүлэн зуучлахтай холбоотой асуулт асууж байна. Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье.

Баярлалаа. ШЕЗ-ийн гишүүн Ундрах. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа бол яг шүүхийн практикт бол эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн дагуу байгаа. Тэгээд шүүхийн ачааллын 60 хувийг үүрдэг буюу шүүхэд нэхэмжлэл гаргахаасаа өмнө талууд эвлэрүүлэн зуучлалд ханддаг ийм тохиолдол сүүлийн жилүүдэд ер нь ихсэх хандлагатай байгаа. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа яг шүүн таслах

ажиллагаанаас юугаар ялгаатай вэ гэхээр талууд өөрөө харилцан тохиролцож эвлэрэх л ёстой. Харилцан тохиролцож эвлэрэхгүй гэхдээ жижиг маргааны асуудлыг шүүх шийднэ ээ л гэж. Ингэж л харьяаллыг нь ялгах нь зөв байх.

Ер нь бол хандлага нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд бол заавал хуулийн боловсролтой, олон улсын хандлага нь бол заавал хуулийн боловсролтой хүн байхыг бол шаарддаггүй. Яг манай Монголын нөхцөл байдалд бол бид нар одоогоор яг шүүхийн тухай юу, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар бол эрх зүйч байхыг шаардаж байгаа. Тэгэхээр талууд өөрөө хүсвэл эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хандах, шүүхийн бус журмаар бас бусад эвлэрүүлэн зуучлалаар хандах ийм боломж бол хуулиар байгаа.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалангийн урилгаар Завхан аймгийн Яруу сумын ЕБС-ийн 1997 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн ажил амьдралд сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Өглөөний мэнд. Ер нь бид нар энэ шүүх хурлыг цахимжуулах, энэ төсвийг нь шийдэж өгөхөөс гадна ер нь хуулийн процесс өөрөө цахим болгох нэг тийм үүд хаалгыг нь нээж өгөхгүй бол яг ний нуугүй хэлэхэд ийм жижиг дүнтэй энэ гарч байгаа энэ хохирлын хойноос хөөцөлдөх нь өөрөө эргээгээд бараг хохирлоосоо илүү хэмжээний зардал гаргадаг л даа. Энэ дээр чинь хэд хэдэн асуудлууд байгаад байгаа юм.

Дээрээс нь нөгөө хаяг дээрээ олдохгүй байх асуудал гардаг. Бараг шүүх бол тэр хүнээ барьж ирээд шахуу өргөдлөө өгч байж л нөгөө гомдлыг нь

авдаг, хүлээж авдаг. Олон хохирогчтой хэрэг дээр заал танхим нь олддоггүй. Миний санаж байгаагаар тэр Хөвсгөлийн бэлдсэн Мөрөн билүү тэр чинь бараг хориод мянган хохирогчтой хэрэг байгаа байхгүй юу. Тэгээд тэр нэг сургуулийн заалд ээлжилж ээлжилж оруулж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ шүүх, шүүхийн сая ковидын үеэр бол ихэнх орнууд бол энэ цахим шүүхийг бол аягүй сайхан шийдчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд процессоо хүртэл тэрэнд тааруулаад хийчихсэн. Тэгээд манайх бол нөгөө бүх юм нь үргэлжилсэн хэвээрээ л нөгөө нотариатаар ч гарын үсгээ зуруулна, тэгээд гэрээ хэлцлээ баталгаажуулна, тэгсэн мөртөө тэр хаяг дээр олдохгүй байхад нь нотариат ямар ч хариуцлага хүлээдэггүй. Тэр хаяг дээрээ байгаа эсэхийг нь олж тогтоох нь хохирогчийн асуудал. Бараг л жишээлбэл болчихсон явж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр ямар шийдэл байх вэ?

Дээрээс нь цахим гарын үсэг, процессыг ингэж цахимаар өргөдөл гомдлоо гаргах боломжуудыг нь нээж өгөх, ер нь тэгээд бид нар энэ шүүх дээрээ энэ төсвийг нь шийдэх тал дээр бол Энхбаяр сайд онцгой анхаармаар байна. Одоо бид нар цахимжуулахтай холбоотойгоор бараг 1 их наяд төгрөгийн зардал гаргачихсан байна лээ шүү дээ. Цахимжуулахтай холбоотой. Бүх яамд тус тусдаа, төрийн захиргааны байгууллагууд агентлагууд цахимжуулах асуудлуудыг бол хийсэн. Тэгээд хооронд нь холболтыг нь бол зарим нэг нь бол и-монгол дээр хийж байх шиг байна. Гэхдээ гарсан зардал нь бараг 1 их наяд төгрөг. Зөвхөн ЭМЯ дээр цахим эрүүл мэнд дээр 200 гаруй тэрбум төгрөг явчихсан. Одоо хүртэл тэр нь цахимжаагүй л явж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр бол онцгой анхаарах хэрэгтэй юм байна.

3 дугаар асуудал болохоор энэ ер нь бол энэ бага дүнтэй юм дээр зардал нь хэтэрхий их болчихоод байдаг болохоор хүмүүс хөөцөлдөхгүй хаядаг түгээмэл тохиолдол их байгаад байгаа юм л даа. Тэгээд энэ дээр ер нь зардлыг нь

бууруулах, тэгээд хөнгөвчлөх ямар ер нь арга байна аа? Би бол сая энэ хуулиас харахад бол яах вэ, зүгээр хялбаршуулсан журмаар явах боломжууд л харагдаад байна л даа. Гэхдээ нөгөө хохирогч талдаа энэ чинь яг яаж хялбар болох гээд байгаа нь нэг сайн л надаа харагдахгүй л байгаад байна л даа. Процесс нь өөрөө хялбар болохгүй бол тэгээд тэр хохирлоо гаргачихлаа, энэ хэргээ шийдүүлье гэхэд тэр хаягийг нь тогтоох асуудал нь шүүх нь тогтоох бол уг нь сайн байна л даа. Бусад оронд бол Тахарын алба нь олдохгүй бол тэр олж ирээд, шүүх хуралд оруулдаг шүү дээ. Тэгээд яагаад энэ хохирогч талдаа үйлчлэх энэ тэр процессоо ер нь оруулж байж болохгүй байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганхуяг гишүүний асуултад ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр хариулья.

Б.Энхбаяр: Шүүхийг цахимжуулах асуудлыг бол Засгийн газар онцгой анхаарч байгаа. Нямбаатар сайд ч гэсэн энэ асуудал дээр онцгой анхаарч байсан. Миний хувьд ч гэсэн яг энэ бодлогыг үргэлжлүүлж шүүхийг цахимжуулахтай холбоотой бодлого санаачилгыг дэмжиж ажиллана гэсэн байр суурьтай байгаа. Шүүхэд ний нуугүй хэлэхэд сүүлийн 10 жил хөрөнгө оруулалт хийгдээгүй. Монгол Улсын хамгийн хоцрогдсон компьютертой газар Монгол Улсын шүүх байгаа. Тийм. Хамгийн нурж унах гэж байгаа байртай газар Монгол Улсын шүүх байгаа. Нэг жижигхэн өрөөнд 3 шүүх зэрэгцээд сууж байгаа. Өөд өөдөөсөө хараад өөрийнхөө хэргийг. 1 шүүгч дээр нь оролцож байгаа хэргийн оролцогч орж ирэхэд нөгөө 2 шүүгч нь хэргийг нь сонсоод сууж байгаа. Юун хараат бус байдал бол цаашаа болсон. Үйлчилгээ үзүүлэх нөхцөл байхгүй байгаа. Хэд хоногийн өмнө манай БЗД-ийн Иргэний хэргийн шүүхийн тог, ус тасарсан. Тэнд иргэд ямар ч ариун цэврийн өрөө орох боломжгүй байдалтай хэд хонож байна. Ийм л байгаа.

Тэгээд цахимжуулах асуудал дээр анх удаа 2024 оны төсөв дээр 10 тэрбум

төгрөг тусгаж оруулж ирж байгаа. Улсын хэмжээний шүүхийн энэ ямар ч байсан дэд бүтцийг нь бий болгоно. Энэ зүгээр нэг компьютер аваад өгчхөнгүүт цахим шүүхтэй болчихно гэдэг асуудал бол байхгүй. Хамгийн гол нь энэ процесстэй холбоотой хамгаалагдсан программ хангамжийн асуудал яригдаж байгаа. Үүнийг Монгол Улсын Дээд шүүх Солонгосын Койка олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтарсан дунд хугацааны төсөл хэрэгжүүлэх гэж байгаа. Нэлээн том төсөл.

Мөн энэ шүүх байгуулах тухай хууль дагалдуулаад таны хөндөж байгаа энэ цахимаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг хөндөж оруулж ирнэ. Би нөгөө Засгийн газар хэлэлцээний дараа энэ тоонуудыг нь бас хэлбэл жоохон танхимын зарчимд нийцэх гээд байна. Би нөгөө засгаар ороогүй асуудлаар бас хамаагүй их тийм ярихаар зарчимд бас нийцэхгүй болчихоод байгаа учраас жоохон түдгэлзээд байгаа юм гэдгийг та бас ойлгож хүлээж аваарай.

Энэ нөгөө процесстэй холбоотой түрүүн бас хохирогчийн эрхийг яаж хялбаршуулах вэ гэдэг дээр манай ажлын хэсгээс бас нэмж хариулж өгөөч.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Баярмаа шүүгч хариулья, ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

Н.Баярмаа: Хэдүүлээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хэлэлцэж байгаа гэж ажлын хэсэг бас тэр талаар танилцуулга хийгээд байж байгаа. Тэгэхээр 2 процессын эрх зүйн үндсэн зарчмаа бид нар бас нэг ялгаж харахгүй бол болохгүй л дээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүй гэдэг энэ эрх зүй бол эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас мөн захиргааны процессоос суурь ялгаатай. Өөрөөр хэлбэл, энд нэхэмжлэгч, хариуцагч буюу зохигч гэдэг 2 ойлголт байна. Нэхэмжлэгч

үргэлж хохирогч байдаггүй учраас өөрөөр хэлбэл энэ хувийн ашиг сонирхлоос үүдсэн маргаан байдаг учраас талуудын зарчим үйлчилдэг. Өөр талуудын зарчим гэдэг маань 2 талд шүүх яг эрх тэгш хандах тухай асуудал яригддаг. Тэгэхээр яг л энэ агуулгаараа хоёуланд нь эхний ээлжид нотлох баримтаар хэн нэгний гэм буруу тогтоогдоогүй нотлох баримт бүрдээгүй энэ шатад нэхэмжлэлийг гардуулж байгаа, хүлээн авч байгаа процесс ажиллагаа энэ бүх явцад аль нэг нь хохирогч мөн, биш гэсэн асуудал хэлэхэд бэрхшээлтэй. Тийм учраас анхнаасаа талуудын зарчим үйлчилнэ. Энэ ч агуулгаар иргэний хэрэг дээр цагдаагийн оролцоо гэж байхгүй. Шүүгч, түүний туслах гэдэг 2 л хүн байна. Тэгэхээр та анхнаасаа сайн дураараа хувийн эрх зүйн харилцаанд оролцсон. Оролцсон харьцаанаас та зөрчил үүсээд хохирол учирлаа гэж үзэж шүүхэд нэхэмжлэлээ гаргаж байгаа бол нөгөө этгээдийнхээ хаяг адрес байгаа газрыг тогтоож, түүнийгээ шүүхэд илэрхийлээд, нэхэмжлэлээ гаргах үүрэг нь нэхэмжлэгчид оногддог. Түүнийг эрэн сурвалжлаад хайгаад явах асуудал бол шүүгч ба түүний туслахын бас шууд үүрэг гэж хэлэхэд нөгөө талуудын зарчим маань бас харгалдаад байдаг. Тэгэхээр яг энэ талаасаа мэдээж хаяг нь олдохгүй, хаягтаа байхгүй байгаа бол шүүгч захирамж гаргаад цагдаагийн байгууллагад захирамжаа явуулна. Үүнийг эрэн сурвалжилж олж өгөөч ээ гэдэг. Цагдаагийн байгууллага түүнийг эрэн сурвалжлах ажиллагааг хийдэг. Эд нар бас энэ ажиллагаагаа хийх өөрсдийнх нь чиг үүрэг гэж байгаад байгаа.

Тэгэхээр энэ хялбар ажиллагаа дээр бол үүнийг дөхөм болгосон ямар зүйл байгаа вэ гэхээр ердийн журмаас нэг ганцхан ялгаатай зүйл байгаа. Ердийн журмын үед шүүх өөрийн санаачилгаараа хаягтай байгаа хүний хаягийг тогтоох, бүртгэлийн байгууллагатай харилцах үйл ажиллагаа хийдэггүй. Ийм боломж байхгүй ердийн ажиллагаа дээр. Тэгвэл хялбар ажиллагаа дээр ийм боломж байгаа. Шүүх эхлээд мэдэгдэх хуудас

баталгаат шуудангаар хаягаар нь хүргүүлнэ. Түүн дээрээ байхгүй гэж бол яг энэ хэсэг үнэндээ бол талуудын зарчимтай ямар нэг хэмжээгээр яг суурь агуулгаараа бас зөрчилдөхөөр байхгүй юу. Шүүх өөрөө санаачилгаараа бүртгэлийн байгууллагад хариуцагчийн хаягийг олж илрүүлэх ажиллагаа хийгдэж байгаа. Үүнийг хялбар ажиллагааныхаа үр дүнтэй хурдан шуурхай гэдэг зарчмынхаа хүрээнд зөвтгөөд, шүүх энэ ажиллагаа хийхийг энэ хуулийн төслөөр бол зөвшөөрч байгаа. Ингээд үүний дараа шүүх хаягийн дагуу ажиллагаа хийх бусад цахим ийм аргуудыг хэрэглээд явна гэсэн иймэрхүү байдлаа ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Тэгээд шүүхийн шийдвэр нь яах вэ, олон шат дамжлага дамжиж байгаад тэгээд 1 юм гарна. Тэгэнгүүт шийдвэр гүйцэтгэл дээр очно. Тэгээд тэнд очоод гацна. Нөгөө хуучин шийдвэр гүйцэтгэлийн гүйцэтгэгчид тодорхой хэмжээний урамшуулал өгдөг байсан бол урамшуулал нь байхгүй болчихсон. Тэгээд шийдвэр гүйцэтгэх ерөөсөө боломжгүй болчихсон. Тэгээд энэ дээр ямар өөрчлөлт орох вэ?

2 дугаар асуудал болохоор нөгөө олондоо танил болсон нөгөө авлига хороолол гээд манай Мөнх-Эрдэнэ дарга тэнд сууж байна, бүр нийслэлд ажиллаж байсан тийм ээ. НЗД-ын захирамж гарсан нураах захирамж гарсан. Тэгээд шүүхэд өгөөд бас гацаачихсан. Тийшээ оршин суугч нар орчих юм бол нураах ямар ч боломжгүй болно. Энэ дээр ямар арга хэмжээ авах вэ?

3 дугаарт, энэ барилгын компаниудын асуудал байна. Захиалга авдаг ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя, хэн хариулах вэ? Тодруулга дээр ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Би бол эрхэм гишүүдээсээ бол нэг зүйлийг хүснэ ээ. ХЗДХ-ийн сайдаас хэн нэгнийг барьж хорих уу, гаргах уу, Мөнх-Эрдэнийг сулла, эсвэл шоронд хий, тэр байшинг нураа гэдэг ийм асуултыг битгий асуугаач ээ гэж хүсэх байна. Яагаад гэхээр би энэ асуудлыг хариуцахгүй, хариуцдаггүй, бас оролцох нь хуулиар хориотой. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн шүүхийн шүүн таслах үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож нөлөөлөхийг хориглодог. Энэ асуудал шүүх дээр маргаантай байгаа бөгөөд эцэслэгдээгүй явж байгаа гэж ойлгож байгаа. Тийм учраас шүүн таслах ажиллагаа явагдаж байх үед ХЗДХ-ийн сайд энд нөлөөлөх шинжтэй аливаа үйлдэл, үг хэллэг гаргах нь зохимжгүй бөгөөд шүүхийн хуулиар хориотой. Хэрэв ийм нөлөөлөл үзүүлэх юм бол УХЦ-ээр тухайн УИХ, Засгийн газрын гишүүнийг огцруулах хүртэл Үндсэн хуулийн хариуцлагатай гэдгийг ойлгож хүлээж авахыг хүсье.

Л.Мөнхбаатар: Би бас нэг хэдэн зүйлийг ажлын хэсгээс нэг тодруулаад асуугаад орхиё. Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Тийм, нийслэлд ажиллаж байсан Мөнх-Эрдэнэ даргыг тэнд сууж байгаа болохоор асуугаад байгаа юм л даа.

2 дугаар асуудал болохоор шүүхийн шийдвэртэй холбоотой асуудлыг эргээд надад нэг хариу өгчхөөрэй.

3-д, энэ барилгын компаниуд байна. Иргэд ингээд урьдчилгаагаа захиалга авдаг тэгээд хамаг юмаа хамж байгаад урьдчилгаагаа өгчихдөг. Тэгээд барилга нь ашиглалтад ордоггүй. Манай дүүрэг дээр 2, 3 ийм асуудал байна. Тэгээд нөгөө мөнгө иргэд нь болохоор хэнд хандахаа мэдэхгүй, шүүхээр явах гэхээр өмгөөлөгчийнхөө зардлаа дийлэхгүй, тэгээд энэ дээр тухайлбал бид нар ямар арга хэмжээ авч болох вэ ер нь. Ер нь бол гадаадад бол дүүргийн атвор нь гэж

байдаг шүү дээ. Тэрэнд хандаад шаардлагатай бол үнэгүй өмгөөлөгч эд нар ийм олон нийт дээр хохирчихсон асуудал дээр үнэгүй өмгөөлөгч хүртэл гарах боломж байдаг л даа. Манай дээр энэ ямар арга чарга байдаг юм.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. 84 дүгээр микрофоныг өгье. Ажлын хэсэг.

Асуултад хариулъя. Ундрах гишүүн байна. Шүүхийн шийдвэр биелүүлэх асуудал хүндрэлтэй байдаг гэдэг талаар асуулаа. Энэ асуултад хариулъя. Тэгээд шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бол 2 өөр байгууллага. Шүүх шийдвэр гаргаад Шүүх дээр байгаа асуудал бол дуусдаг. Энгийн үгээр хэлэхэд. Ингээд шийдвэр гүйцэтгэл рүү явна. Харин тэр байгууллага тухайн асуудлаа хэрхэн яаж биелүүлэх вэ гэдэг бол тусгайлан хуулиар зохицуулсан ийм зүйл байгаа. Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад харин шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрхэн яаж хөнгөвчилж болох вэ гэдгийг бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан байгаа. Энэ бол 69 дүгээр зүйлд хөрөнгийг өөрчлөн битүүмжлэх ийм хүсэлтийг шүүхэд гаргах юм бол энэ бол байгаа хөрөнгийг нь битүүмжлэх ийм боломжтой. Тэгэхээр яг энэ нэмэлт, өөрчлөлт орох гэж байгаа энэ бүлэг дээр бол энэ асуудал бол нээлттэй. Тэгэхээр боломж юу хүсэлтээ гаргаад хөрөнгийг нь битүүмжлүүлэх, шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авхуулах бол боломжтой. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Та 2 удаа тодруулчихсан, дэгээрээ болсон байна. Үгүй ээ, энэ Мөнх-Эрдэнэ энд хариулах нь зохимжгүй байх. ХЗДХ-ийн сайдын зөвлөх хийж байгаа шүү дээ. Тэр асуултад нь хариулчих. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье.

Н.Баасанжав: Шийдвэр гүйцэтгэгч нар бол гүйцэтгэлээсээ тодорхой урамшуулал авдаг тийм

тогтолцоо байсан юм байна лээ. Одоо бол тэр бол байхгүй болсон. Тэгэхээр энэ шийдвэр гүйцэтгэл бол нөгөө ер нь гүйцэтгэх эрх мэдлийн асуудал байгаа учраас цаашид бол бас шийдвэрийг үр дүнтэй биелүүлэхийн тулд үүнийг бас онцгойлон анхаарах хэрэгтэй байх. Тэгэхгүй шүүхийн нэр хүнд бас олон нийтийн нөгөө ойлголт буруу байдагтай холбоотой шийдвэр нь биелэхгүй болохоор эргээд шүүх ер нь байсны ямар хэрэг байгаа юм гэдэг юм гараад байдаг. Тэгэхээр бас үүнийг ер нь бол анхаарах асуудал мөн гэдэг дээр бас санал нэг байна. Зүгээр хараахан шүүх болон яг энэ хууль дээр бол бид нар үүнийг оруулах боломжгүй. Яаж үр дүнтэй гүйцэтгэх вэ гэдгийг. Тэгээд ер нь шийдвэр гүйцэтгэл дээр бас аягүй цахимжмаар байдаг. Яг шүүх дээр ямар асуудал тулаад байна гэхээр гүйцэтгэх хуудсыг бичээд өгөхөөр хүнтэй нь аваад ир гээд шийдвэр гүйцэтгэл авдаггүй. Одоо хамгийн сүүлийн жишээ бид нар хорихоос өөр төрлийн буюу нийтэд тустай ажил хийлгэх хүнийг нөгөө хүнтэй нь аваад ир гэсэн шаардлагынх нь дагуу аваачиж өгөхийн тулд Баянхонгор луу Замын-Үүд-ээс явуулахад 1,9 сая төгрөг зардал шүүхээс гарчхаад байгаа байхгүй юу. Тэр нь бол хуулийн тэр заалт өөрөө оновчгүй байгаа, тэр шийдвэр гүйцэтгэл бас зарим энэ дээр гүйцэтгэлийн ажиллагаа дээр онцгой ялангуяа иргэний гүйцэтгэл дээр арай өөр механизмаар ажиллаж чадахгүй байгаатай л бас холбоотой байх гэж боддог. Үүнийг бол боловсронгуй болгох бүр зайлшгүй шаардлагатай.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн Дархан сумын МАН-ын хорооны дэргэдэх Ахмадын хорооны гишүүдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм ахмадууд та бүгддээ ажил амьдралд нь сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Пүрэвдорж гишүүн сурталчилгаагаа хийхээ больё. Хуралдаан хэвийн болох нөхцөлийг нь хангая.

Энэ ажлын хэсгээс би нэг хэд хэдэн зүйлийг бас тодруулж асуух зүйлүүд байна. Бага үнийн дүнтэй нэхэмжлэлтэй хэрэг маргааныг тусгайлсан журмаар буюу хялбаршуулж шийдэх энэ процессыг оруулж ирж байгаа нь бол зөв. Гэхдээ энийгээ хийхдээ яг та бүгдийн хүсэн хүлээгээд байгаа тэр үр дүнд гарах уу, үгүй юү гэдэг дээрээ бас та бүгд бас нэлээн хэлэлцүүлгийн явц сайн хармаар юм шиг харагдаад байна. Ер нь бол бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийддэг дагнасан ийм шүүх байгуулах нь бол зүйтэй. Энэ талаар бол бас бодлогын баримт бичиг явж байгаа. Ингээд шийдээд явах нь бол хамгийн зохимжтой хувилбар гэж хараад байгаа юм.

Энэ дээр нэг ийм хэд хэдэн зүйл байгаад байх юм. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар шийднэ гэж байгаа юм, тийм ээ. Үүнийг бас нэг жаахан тодруулж бас ажлын хэсэг хариулаач ээ. Нэг шүүх хуралдаан гэдэг нь нэг удаа хуралдаад хэлэхээ шийдэж байна уу? Энэ чинь хойшилно, ингээд их олон зүйлүүд болно, ирэх ирэхгүй зүйлүүд болдог. Эсвэл давж заалдах хяналтын шатаар шийдэхгүй гэсэн энэ агуулгыг бас илэрхийлж байгаа юу гэсэн зүйлүүд байна. Ер нь энэ зарчмыг нэг тодорхой тайлбарламаар байна гэдгийг хэлье. Ер нь гол юм чинь бол энэ тусгайлсан энэ журмын чинь гол амин сүнс бол нэг удаагийн хурлаар шийднэ ээ л гэсэн ийм агуулга байгаад байна шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр энэ агуулгыг чинь энэ одоо энэ процессууд чинь ер нь хангаж чадахаар байгаа юу гэдгийг асууя.

2 дахь нэг зүйл нь нэг ийм зүйл байгаад байна. Энэ 75-ын чинь 1 дээр бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг хэлэлцээд энэ зохигч шүүх хуралдаан эхлэхээс өмнө хүсэлт гаргасан бол хэргийг ердийн журмаар шийднэ ээ гэж байгаа юм. Тэгэхээр л энэ журам чинь бас их

төвөгтэй болох болохгүй юу? Нэхэмжлэгч юм уу хариуцагч чинь ердийн журмаар гээд хэлчихнэ байна шүү дээ, тийм ээ. Тэгэнгүүт тэгээд л ердийн журмаар болчих юм байна л даа. Тэгэхээр чинь анхнаасаа хялбаршуулж шийдэх гээд хүсэлтээ өгчихсөн мөртөө нэхэмжлэлээ өгчихсөн мөртөө ингээд ердийн журмаар гээд хэлчих юм бол уул нь ингээд ердийн болоод явчих юм бол энэ чинь өөрөө энэ агуулга чинь бүхлээрээ ингээд уначхаж байгаа юм биш үү гэж хэлэх гээд байгаа юм, би. Тэгэхээр үүнийг зохигч хүсэлт гаргасан гэдэг энэ шалтгаанаар ингээд ердийн журмаар хэлэлцээд явах нь зөв юм уу, буруу юм уу? Энэ зохигчид ийм эрх эрх өгөх үү, үгүй юү гэдгийг бас та бүхэн юу гэж харж байна гэж үзэж байгаа.

75-ын тэр 6.2.3 дээр байна. Шүүх тухайн хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхэд тохиромжгүй гэж үзсэн гээд байгаа юм. Энэ тохиромжгүй гэдгийг яг юу гэж ойлгох вэ? Шүүхийн үзэмжийн асуудал болох гээд байна шүү дээ. Үзэмжээр шийдэх нь байна тийм ээ, тохиромжгүй гэдэг ойлголт чинь ер нь та нарын хууль зүйн хувьд ямар ойлголт байна вэ гэдэг зүйл харагдаж байна.

Энэ хуулийг уншаад үзэхээр бас хэд хэдэн энэ томъёоллын хувьд ч бас хэдэн зүйлүүд харагдаад байх юм. Тэр 75.1.4 дээр чинь гэр бүлийн харилцаанаас үүсэх маргаан гэсэн ийм албан ёсны тодорхойлолт байна уу? Энэ Гэр бүлийн хуульд байгаа болохоор та нар эшлээд байгаа юм уу? Би бол ийм зүйл сайн хараагүй санагдаад байх юм. Гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан гэдэг хуулийн нэр томъёог бас та бүгд нэг хэлж өгөөч тийм ээ. Тэгэхгүй бол энэ их өөрөө их тодорхойгүй зүйл байгаад байна.

Дараагийн зүйл нь энэ нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагааг хязгаартайгаар явуулж болно гээд байгаа юм, тийм ээ. Хязгаартай явуулна гэдэг чинь ямар агуулга юм? Яг ийм ийм зүйлийг хийж болно, үүнийг болохгүй гээд ингээд тодорхой зааж болохгүй юм уу, тийм ээ, хэдэн хувь нь хязгаартай байх юм. Тэр 75

хувь нь юм уу, 25 хувь нь байх юм уу, ингээд 50 хувь нь ч гэдэг юм уу. Нэг ийм зүйлүүд бол байгаад байна. Ингээд ийм жаахан энэ жаахан дур зоргын шинжтэй ийм заалтууд болоод явчих вий дээ гэж харагдаад байна. Тэгээд энэ хязгаартай явуулна гэдгийгээ та бүхэн яаж ойлгох юм.

Энэ төслийг уншаад үзэхээр 75.1.1 дээр чинь энэ 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс доошгүй үнийн дүнтэй нэхэмжлэлийг хэлэлцэхээр байна шүү дээ тийм ээ. Ер нь бол яах вэ, амьдрал дээр зээлийн маргааны 80 хувь нь бол 13 сая төгрөгөөс доош байна гээд байна 13 саяас, тэгээд 20 дахин нэмэгдүүлсэн гэхээр бол энэ танилцуулгад дурдсанаар чинь бол 11 сая төгрөг юм байна тийм ээ. Энийгээ яаж та нар томъёолсон юм? Яах вэ, энэ инфляц болж байна. Энэ олон зүйлүүдээс хамаараад амьжиргааны түвшин олон зүйлүүдээс хамаараад энэ 11 сая чинь ер нь жаахан бага биш үү? Энийгээ жаахан өсгөх боломжууд нь ямар байгаа юм бол? Та бүгдэд байгаа судалгаанууд чинь бол юу байна гэж.

2 дугаарт, энэ бичилтийн хувьд энэ би бас сайн уншаад ойлгохгүй байгаа нэг юм байгаад байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс доошгүй үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэнэ гэххэж байна шүү дээ тийм ээ, доошгүй гэдэг нь өөрөө ингээд яагаад ингэж бичсэн юм бол? Доошгүй гэдэг нь. Нэмэгдүүлснээс доош байх ёстой гэдэг агуулга шүү дээ тийм ээ. Бичилтийн хувьд. Тэгэхгүй бол доошгүй гээд тэгэх юм бол тэрнээс их гэсэн ийм санаа шүү дээ. Ер нь бол тийм ээ, их гэсэн санаа. Тэгэхээр энэ энэ чинь өөрөө бичилтийн хувьд хэр зөв томъёолол вэ? Үүнийг бас нэг тайлбарлахгүйгээр харагдаж байна шүү. Энэ мэтийн яг хэлэлцүүлгийн явцад анхаарах тийм зүйлүүд байгаад байна. Энэ дээр бас ажлын хэсгээс хариулт аваад цаашаа явъя.

Хэн хариулах вэ? 80 дугаар микрофон өгье. Баярмаа шүүгч хариулъя.

Н.Баярмаа: Хамгийн 1 дүгээрт 1 шүүх хуралдаанаар шийдвэрлэх зарчим баримтлах гэдэг ойлголтыг тодруулаач ээ гэж байна. Тийм ээ. Ер нь 2002 оны одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчим бол өөрөө бүр бас л нэг л шүүх хуралдаанаар асуудлыг шийдвэрлэх тухай зарчимтай байгаа. Өөрөөр хэлбэл энэ хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д шүүх хуралдаан дээр нотлох баримт гаргаж өгөх нь хүндэтгэн үзэх шалтгаантай, нотлох баримт гаргуулах хүсэлт гаргах нь хүндэтгэн үзэх шалтгаантай л бол нэг л удаа хойшилно гэдэг санаа байдаг. Өөрөөр хэлбэл ердийн журмын үед ч гэсэн шүүх хуралдаан олон хойшлуулах тухай тийм үзэл баримтлал тэр хуульд бол байхгүй. Тэгэхээр өнөөдөр яах вэ практикт бүр эсрэгээрээ тогтчихоод байна л даа. Ерөөсөө шүүх хуралдаан хойшлох нь энгийн үзэгдэл мэт. Гэтэл бол үгүй юм аа. Уг нь хуулийн концепц бол нэг л шүүх хуралдаанаар асуудлыг шийдэх ёстой, анхны шүүх хуралдаанаас өмнө нотлох баримтыг гаргаж өгөх, нотлох баримт гаргуулах хүсэлтээ өгөх, түүнийгээ шүүхийн хуралдааны бус журмаар шийдүүлэх ажиллагаа хийх энэ тэр нь өмнө нь хийгдэх ёстой ажиллагаа байгаа. Энэ хуулийн одоо үйлчилж байгаа хуулийн 105 дугаар зүйлээс энэ бол тодорхой харагддаг. Энэ зарчим эвдэгдчихээд байгаа энэ практикийг хялбар ажиллагаа дээр яг үндсэн зарчмаар нь бид нар суулгахгүй бол энэ ажиллагааны шүүх бол ямар ч үр дүнгүй. Энэ шүүх ажиллагаа бол ямар ч үр дүнгүй болно. Тэгэхээр яг энэ агуулгаараа шүүх хуралдаан хийнэ. Шүүх хуралдаан явахад талууд зохигчид хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд ирж чадаагүй эсвэл шүүх хуралдаан дээр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй байгаа тохиолдолд эхний тохиолдолд шүүх хуралдаан магадгүй хойшлохыг үгүйсгэхгүй.

2 дахь тохиолдолд шүүгч хэрэгт энэ хүртэлх хугацаанд авагдчихсан байгаа бичгийн болон цахим цаасан бусад нотлох

барим баримт дээр суурилоод асуудлыг шийдээд дуусгал гэсэн санаа 1 дүгээрт. 2 дугаарт энд давж заалдах журам бол үйлчилнэ. Яагаад гэвэл давж заалдах эрх манай Үндсэн хуулийн эрх. Энэ агуулгаараа давж заалдах шат руу гомдох эрх нь байгаа. Харин давж заалдах шатын шүүх энэ асуудлыг мөн л богино хугацаанд шийдвэрлэх энэ юуг үндсэн зарчмыг бол хуульд бас хийсэн. Тэгэхээр энэ агуулгаараа давах дээр очоод бас энэ хэрэг маань удаашираад байж болохгүй ээ гэдэг энэ нөхцөлийг нь бас суулгаж байгаа юм. Энэ бол 1 дүгээрх нь.

2 дугаарт нь, зохигч шүүх хуралдаан эхлэхээс өмнө хүсэлт гаргасан бол хэргийг ердийн журмаар шийдвэрлээд энэ нэхэмжлэгч шууд саналаа өгөөд явчихвал ингээд л ердийн журам руу ороод л энэ хууль чинь үр дүнгүй болох нь байна шүү дээ гэдэг асуудал. Тэгэхээр яг үүнийг бол нэлээн үзэл баримтлалын түвшинд бол би ажлын хэсэг бодсон гэж ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл ердийн журмыг ингэж өөрчилж байгаа бага үнийн дүнгийн энэ хатуу процесс ажиллагааг хэдүүлээ уян хатан биш байдлаар шууд суулгаж өгөх үү, эсвэл үүн дээр эхлээд зөв фракцыг тогтох хүртэл хугацаанд тодорхой хэргүүд дээр ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмээд хариулчихъя, 80 дугаар микрофоныг өгье.

Н.Баярмаа: Богинохон хариулъя. Энэ ажиллагаа маань аль болох үр дүнтэй байх вэ гэдэг нь сонголт хийх тухай асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр ер нь иргэний эрхийг нэгэнтээ бид нар ингээд тодорхой түвшинд бас нэлээн хатуу байдлаар хааж байгаа энэ хянан шийдвэрлэх ажиллагаа учраас нөгөө тал руугаа хөрвөх боломжийг нь олгож өгөхгүй бол энэ өөрөө бас уян хатан биш зохицуулалт болох гээд байна гэдэг ойлголт яригдаж байгаа. Үүнийг ажлын хэсэг бас тийм байна гэдэг үүднээс ийм үзэл баримтлалтай хууль гарч иржээ гэж ойлгож байгаа.

3 дахь асуулт шүүхэд тохиромжгүй бол хүргэнэ гэдгийг яаж яаж ойлгох вэ гэж байна. Тэгэхээр одоо Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль дотор ч байж байгаа. Шүүх өөрөө тухайн хэрэг ээдрээ төвөгтэй гэж үзэх юм бол бас бүрэлдэхүүнтэй шийдэх тухай асуудал байна. Дангаараа шийдэх шүүх дээр. Ээдрээ төвөгтэй тухайн хэргийн голлох нотлох баримт өөр газар байна гэж үзэх юм бол бас энэ асуудал дээр нэгтгэх, нийлэх, хэргүүдийг нэгтгэх, хуваах эсвэл хэрэгт шилжих тухай асуудал ч юм уу байдаг. Энэ бол процесс ажиллагааны өөрийнх нь үндсэн зарчимтай зөрчилдөөгүй зүйл ээ гэдгийг хэлмээр байна.

Тэгэхээр энэ субъективний гэхээсээ илүү шүүгчид бас хэрэг өөрөө ээдрээ төвөгтэй байвал ердийн журам руу шилжүүлэх, хэргийн оролцогчийн байр байдал, хэргийн нөхцөл байдлыг мэдрэх тухай асуудал юм гэдгийг бас бол хэлэх хэрэгтэй байгаа.

Гэр бүлийн харилцаа гэдэг дээр энэ нэр томъёоны хувьд анхаарах тухай асуудал байж магадгүй. Гэхдээ ерөнхийдөө гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бол иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа дотроо онцгой ажиллагааны ажиллагаа шиг бас нэлээн өөр журам үйлчилдэг. Харьцангуй шүүх өөрөө дотроо санаачилгатай ханддагаараа талуудын зарчим хөндөгддөг ийм процесс ажиллагаа байдаг. Энэ нэр томъёо нь бас үүдэлтэй, угшилтай нэр томъёо байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй байна.

Нотлох баримт шинжлэн судлахтай холбоотой асуудалд та ярилаа. Тэрэн дээр яах вэ, ер нь шүүх яг хуралдаан эхлээд хурлаа зараад зарлаад нотлох баримтаа шинжлэн судлах шатдаа очихоороо яадаг вэ гэхээр нэг бүрчлэн уншин танилцуулах тухай асуудал яригддаг. Бүх нотлох баримтыг. Тэр нь хэдэн хавтас байсан ч хамаагүй. Тэгэхээр энэ процесс ажиллагаанд яг тэр журам үйлчлэхгүй байж болно. Яагаад

гэвэл шүүгч эхлээд өмнө нь танилцаад орж байгаа, нэр төдий, тэр олны өмнө уншин сонсгох ажиллагааг бас хийхгүй, энэ арай хялбар байдлаар явагдаж болно гэсэн санаа.

Тэр хуулийн төслийн 1.1-ийн дээшгүй, доошгүй гэдэгтэй бол санал нэгдэж байна. Энэ дээр бичилтийн алдаа гарсан байна. Ийм 7 асуулт асуулаа гэж ойлгосон. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ер нь яах вэ, манай ажлын хэсэг Их Хурлаас ажлын хэсэг бас байгуулагдах байх. Тэр үед хэлэлцүүлгийнхээ явцад бас саяын зүйлүүдийг бас нэлээн анхаарах шаардлагууд бол байна шүү. Яах вэ, мэдээж хуулийн төслийг бол цаашид нь засаж залруулах боломжууд бол хэлэлцүүлгийн явцад байгаа.

Одоо Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Иргэдийн шүүхэд итгэх итгэл сайнгүй байгаагийн нэг хүчин зүйл нь энэ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, маргааныг эцэслэн шийдвэрлэх энэ үйл ажиллагаа, процессын үйл ажиллагаа нь өөрөө ээдрээ төвөгтэй, удаан, магадгүй иргэдийг залхаадаг. Ийм учраас бас иргэдийн шүүхэд итгэх итгэл сайнгүй байна гэж үзэж байгаа юм.

Нөгөө талаар хэдийгээр удаан ч гэсэн нэг юм шүүхийн шийдвэр гарлаа гэхэд хэрэгжилт нь шүүхийн шийдвэрийн хэрэгжилт бас хангалтгүй байгаад бас иргэдийн шүүхэд итгэх итгэл бас нөлөөлж байгаа гэж ойлгож байгаа юм. Тэгээд сая та бүхний тайлбараас бол шүүхийн шийдвэр гүйцэтгэл бол манайд хамаарахгүй тусдаа хуулиар явдаг гээд. Тэгээд эндээс юу харагдаж байна вэ гэхээр ерөөсөө эцсийн зорилго нь бид нар энэ иргэдийг аль болох шүүхээр удаан залхаахгүй байх, асуудлыг нь, гэмт хэргийг хөнгөн хэргүүдийг хурдан шийддэг байх, гарсан шийдвэрийг хурдан хугацаанд хэрэгжүүлдэг байх нь л эцсийн үр дүн шүү

дээ. Тэгэхээр энэ чинь нөгөө хуулийг ингээд цогцоор нь асуудлыг цогцоор нь авч орж ирэхгүй ингээд алаг цоог ингэж авч явж байгаа нь өөрөө бас дутагдалтай байна шүү. Тийм учраас энийгээ дагаад шүүх хэдийгээр удаан байгаа ч гэсэн шийдвэр нь ачаалал ихтэй, маргаан явна төвөгтэй байгаа ч гэсэн шийдлээ гээд эцсийн шийдвэр нь хэрэгжихгүй байвал бүр л энэ иргэдэд шүүхэд итгэх итгэл алдраад байгаа юм. Наанадаж л иргэн хоорондын маргаан, зээлийн асуудлаас болоод хохирогч, хариуцагч шийдвэр гардаг. Гүйцэтгэл дээр очоод л 2 чихнээс өөр юм алга, авбал ав гээд ингээд сууж байдаг. Ийм тохиолдол 1-д.

2-т, өнөөдөр цахим бүх юм цахимжчихаад байж байхад шийдвэр удаан гарч байгаагийн нэг шалтгаан нь та бүхэн хэлж байна шүү дээ. Иргэний хаягийн бүртгэл тодорхойгүй байдлаас болоод энэ шийдвэр бас удаан, маргаан удах нэг нөхцөл болж байна гэж. Энэ чинь юу гэсэн үг юм бэ? Хороо захиргаа гэж байна. Иргэний бүртгэл гэж байна. Энэ банк санхүүгийн байгууллагуудаас доор байж болохгүй шүү дээ. Тийм учраас энэ шүүх өөрөө бусад төр, захиргааны байгууллагуудтайгаа хамтарч ажиллах, бүртгэл судалгаануудыг сайжруулах тал дээр бас энэ өөрсдийнхөө программ хангамжийг сайжруулах гээд энэ чиглэл дээр бас анхаарч ажиллах ёстой юм биш үү гэж ингэж бодож байна.

Нөгөө талаас энэ хөнгөн 11 сая төгрөг буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй хэмжээний энэ хэмжээний энэ дотор багтах хэмжээний хэргийг үүнд хамааруулах гэж байгаа юм байна. Тэгвэл хэдийгээр хэргийнх нь агуулга нь хөнгөн шугамаар шийдсэнээс энэ 11 сая 100 мянган төгрөгийн асуудал байвал яах вэ? Тэгэхээр 11 сая гээд хатуу хуульчилчихаар миний хувьд юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр энэ интервалыг нь бас тэдээс дээш, доошгүй байхаар эд нар гэж ингэж өгвөл яах вэ? Та бүхэн бол ингээд л 11 сая төгрөгөөс л дооших асуудлуудыг л хөнгөн гэмт хэрэг гээд ингээд үүнд хамааруулаад

нэг удаагийн шүүхээр шийдэх гэж байна шүү дээ. Гэтэл асуудал нь хөнгөн боловч мөнгөн хэлбэр нь 12 сая төгрөг байвал яах вэ гэдэг асуудал байна. Тийм учраас энэ хохирлын энэ хэмжээг бас эргэж харах, дээш, доош нь болгох тэр бололцоо боломжууд юу байна вэ гэдгийг нэг тодруулж асууя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах юм? ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр хариулъя. Дараа нь ажлын хэсэг нэмж хариулъя.

Б.Энхбаяр: Шүүхийн шийдвэр гарсан ч гэсэн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа удааширалтай, хүндрэлтэй, иргэдийг ихээхэн чирэгдүүлдэг, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх энэ ажил дээр ялангуяа иргэний хэрэг дээр, асуудал байгаа гэдэгтэй санал нэг байна. Нэг амьсгаагаар шийдэж болохгүй юм уу гэж. Нэг амьсгаагаар би нэг 3, 4 үе шаттай л юм оруулж ирэх гээд л байна. Тэгээд цаг хугацааны хүчин зүйл бас байна. Намрын чуулган бол энэ удаагийн парламентын сүүлийн отгон чуулган бараг шахуу болно. Үндсэндээ нэг 2 сарын л хугацаа байгаа юм. Тэгээд яарч байгаа. Одоогоор бол нэг 3, 4 хуулийн төсөл өргөн баригдчихаад байна. 11 сард ирэх 7 хоногт Шүүх байгуулах хууль, Гэр бүлийн хуулиа оруулж ирнэ. Шүүх байгуулах хуулийг дагалдуулаад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд бага зэргийн өөрчлөлт оруулна. Бага зэргийн. Том хэмжээний өөрчлөлт бүтцийн өөрчлөлт явбал бүхэлдээ бас хуулийн хувь заяанд нөлөөлж болзошгүй байна. Тухайлбал, иргэний шийдвэр гүйцэтгэлийн харьяалалтай холбоотой асуудал орж ирэх юм бол энэ удаагийн парламентын босго би давахгүй байх улс төрийн эрсдэл байна гэж тооцож байгаа. Тийм учраас яг чадахыгаа буюу нэн чухал яаралтай гэсэн асуудлаа түрүүлж оруулж ирж байгаа юм. Чухал бөгөөд хэдий ч, цаг хугацааны хүчин зүйлээ давахаргүй асуудлаа түр хойш нь тавьж байгаа. Түр гэдэг нь би энэ намрын чуулганыг л яаж байгаа гэсэн үг. Тэрнээс бүхэлдээ хойш нь

тавьж байгаа гэсэн агуулга бол байхгүй байгаа гэдгийг бас танд хэлье.

Ер нь иргэний шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудал дээр ер нь нэлээн л өөр зарчим барихгүй бол яг энэ байдлаараа бол үнэхээр болохоо больчихсон байгаа. Хүний асуудал байна, дотоод асуудал байна, процессын асуудал байна, хөшүүргүүд байна, хариуцлагын асуудлууд байна. Энэ шийдвэр гарч байгаа шүүхийн шийдвэртэй холбоотой асуудал ч байна. Өөрөөр хэлбэл яг ямар хөрөнгөөс нь энэ юмыг нь барагдуулах вэ гэдгийг шүүх шийдвэртээ бас сайн тусгахгүй бол хөрөнгөөс нь гээд битүү гаргачихвал бас эрсдэлүүд байна. Үүнтэй холбоотой бас ҮХЦ дээр гарсан нэг шийдвэртэй холбоотой хууль зүйн асуудал бас байна. Өөрөөр хэлбэл тухайн үнийн дүнгийн 70 хувиар барагдуулдаг барьцааны хөрөнгийг барагдуулах уу, 50 хувиар барагдуулах уу гэдэгтэй холбоотой ҮХЦ Улсын Их Хуралд чиглэл болгочихсон бас нэг шийдвэр байгаа юм байна лээ. Үүнийг бас хууль болгож батлах уу гээд их олон ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрэм, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн ажил хөдөлмөрт сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгээс нэмж хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофон. Мөнх-Эрдэнэ хариулъя.

ХЗДХ-ийн сайдын зөвлөх Мөнх-Эрдэнэ Сандагочир гишүүний асуултад хариулъя. Энэ 11 сая төгрөг гээд яагаад ингээд тавьчихав гэж асууж байгаа. Бусад улсын жишээг харвал үнэхээр бас хатуу мөнгөн дүн заадаг байгаа. Жишээ нь Европын холбоонд 5 мянган евро хүртэл, Их Британид 10 мянган фунтээс

хэтрэхгүй байх, Японд 1 сая 400 мянган иенээс хүртэл гээд ингээд тодорхой заачихсан байдаг. Тэгэхээр бид бол яах вэ, энэ инфляцын хэлбэлзэл, янз бүрийн байдлаа харж байгаад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэйгээ уячих нь бас зүйтэй юм байгаа гэж үзсэн юм. Тэгээд ингээд тооцохоор бол хуулийн төсөлд тусгасны дагуу тооцохоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 22 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх гэж бол өнөөдрийн байдлаар 11 сая хүртэл төгрөг гарчхаад байгаа юм. Тэгэхээр энэ маань хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нөхцөл байдлаасаа хамаараад өөрчлөгдөж байгаа тохиолдолд дээшээ, доошоо хэлбэлзээд явчихна гэж ойлгож болно.

Энэ хугацааны хувьд бас түрүүн нэлээн олон удаа ярьсан. Энэ ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бол ингээд л хэрэг үүсэх хугацаанаас авхуулаад шүүх хуралдаан гээд ингээд явахаар дунджаар бол анхан шатад бол нийт хугацаа 109 хоног байгаа гэж байгаа юм. Энэ бид нарын төсөлд тусгаснаар хэрэг маргааныг нэг удаагийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ. Ингээд бусад процессын хугацааг богиносгосонтой холбоотой аваад үзэхээр багадаа 48 хоног, ихдээ бол нэг 65-72 хоног байхаар ингэж харагдаж байгаа.

Давж заалдах шатанд жишээ нь давж заалдах гомдол гаргах хугацааг одоо ердийн журмаар 14 хоног гэж байгаа бол бид нар төсөлдөө 7 хоног, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа 30 хоног гэж байгаа бол манай төсөлд 21 хоног гэх мэтчилэн ингэж багасгаж тусгасан байгаа. Тэгэхээр нөгөө нэг удаагийн шүүх хуралдаанаар асуудлыг шийдвэрлэнэ. Процессын энэ хялбаршуулсан ажиллагааг ингээд тооцоод үзэхээр зардал бол нэлээн хэмнэгдэж байгаа. Хугацаа түрүүний хэлсэнчлэн ингэж багасгаж байгаа гэдгийг хэлье.

Түрүүн бас яах вэ нөгөө Мөнх-Эрдэнэ гэж нэр заагаад асууж байсан учраас би бас нөгөө мэдээлэл хэлэхэд

манай энэ Барилгын хуулиар чинь газрын зөвшөөрөл олгоогүй, техникийн нөхцөл олгоогүй, зураг төсөл нь эцэслэж батлагдаагүй энэ барилгын төслүүдэд хөрөнгө төвлөрүүлэхийг хориглохсон байдаг байхгүй юу. Тэгэхээр манай энэ гараад байгаа энэ барилгатай холбоотой энэ иргэд хохирсон асуудал дээр бол дийлэнх нь зөвшөөрөл нь эцэслэгдэж гараагүй байхад хөрөнгө төвлөрүүлснээс болоод үүсээд байгаа маргаан луйврууд байгаа шүү. Тийм учраас үүнийг юу гэдэг юм иргэдэд зөв мэдээлэл өгөх, энэ ААН-үүдэд хариуцлагын энэ асуудлыг нь сайн ярихгүй бол зөвшөөрлөө аваагүй байж байж, мөнгө босгоод хөрөнгө төвлөрүүлээд, тэгээд иргэдийг хохироогоод байгаа ийм асуудал байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Мөнх-Эрдэнэ зөвлөх өө, энэ гишүүний асуугаад байгаа зүйл бол нэг ийм зүйл асуугаад байна шүү дээ. 20 дахин нэмэгдүүлсэн гэхээр 11 сая төгрөг байгаад байна. Гэтэл та нарын хийсэн нэлээн судалгаанууд хийсэн байна шүү дээ. Хийсэн судалгаагаар чинь 13 сая төгрөг нь зээлийн маргааны 80 хувь нь буюу 13 сая төгрөг байна гээд байна. Тэгэхээр чинь 11 сая 500 яах юм, 12 сая гээд энэ чинь тэр бол чинь 2 саяын хоорондын зөрөө гараад байна шүү дээ. Үүнийг л гишүүн асуугаад байна л даа. Сандаг-Очир гишүүний асуулт бол гол агуулга нь түүн дээр нь илүү тодруулж хэлмээр байгаад байх юм. Тийм.

Үгүй ээ үгүй. Эхнээсээ яагаад 13 болгочхоогүй юм бэ гэж асуугаад байгаа байхгүй юу. Сандаг- Очир гишүүн чинь тэгж асуугаад байна шүү дээ. Гол санаа нь 20 гэж одоо 20 гэхээрээ яах вэ 11 сая болчихоод байна шүү дээ. Гэтэл ихэнх нь 13 сая дотор байгаад байна гэсэн судалгаа гарчхаад байхад яагаад 11-ээр хийгээд байгаа юм бэ л гэж асуугаад байна. Мөнх-Эрдэнэ хариулах уу? Ажлын хэсгийн 81 дүгээр микрофон өгье.

Д.Мөнх-Эрдэнэ: Энэ Нээлттэй нийгэм форумаас гаргасан 22 онд гаргасан судалгаан дээр бол энэ 13 сая

төгрөг гэсэн энэ бага үнийн дүн гэсэн ийм судалгаа байдаг аа. Энэ үнэн. Гэхдээ бид энэ ажлын хэсэг дээр хуулийн төсөл боловсруулах явцад энэ манай энэ иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол маргааны нэг зээлийн зээл болон иргэдийн хооронд байгуулсан худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой энэ маргаанууд байдаг. Энэ дээр байгаа маргааныг судлаад үзэхээр нийт маргааны нийслэлийн хэмжээнд яриад үзэхэд л нийт маргааны 24 орчим хувь нь 11 сая хүртэл төгрөгийн үнийн дүнтэй маргаан байгаа юм. Тэгээд энэ нөгөө 11 сая хүртэл үнийн дүнтэй энэ зээлийн маргаан, зээлийн гэрээтэй холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлэгдэж байгаа байдлыг хараад үзэхээр, хараад үзэхээр 80 орчим хувь, 70 орчим хувь нь 70 орчим хувь нь эвлэрэх, хялбаршуулсан журмаар буюу нөгөө нэг түрүүний хуульд заасны дагуу зохигчид эвлэрэх, хариуцагч тэр нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах гэх мэт нөгөө хамаагүй хялбар журмаар асуудал нь шийдэгдээд байгаа ийм практик жишээ байгаа юм. Тэгэхээр бид энэ хялбар хэргийн шүүх гээд байгаа бага үнийн дүнтэй маргаан шийдэж байгаа энэ практик хуулийн зохицуулалт маань анх удаа энэ манайд орох гэж ирэх гэж байгаа учраас эхлээд төлөвшүүлэх. Үүнийг зөв практикт хэвшүүлэх ийм шаардлага байна. Тийм учраас аль болох үйл явдал нь тодорхой, ээдрээ төвөг багатай ийм ойлгомжтой маргаануудыг хэлэлцдэг ийм практикийн шүүхийн практикийг бий болгосныхоо дараа дараа нь байх магадгүй энэ хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, үр нөлөөг нь судалж байгаад ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Ерөнхийдөө хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол агуулга нь бол ганц удаагийн шүүх хуралдаанаар асуудлыг бага үнийн дүнтэй асуудлаар шийдэх гээд байна л даа. Тэгэхээр хохирогч болоод нэхэмжлэгчийн хүсэлт

хангагдаагүй тохиолдолд сэтгэл ханамжийг юу гэж үзэж байгаа вэ? Давах, хяналтын шатын шүүхэд очих эрх нь бас байх ёстой Үндсэн хуулиар олдсон. Үүн дээр та бол ингээд нэмэлт, өөрчлөлтөөр ийм хууль батлагдсан танд бол давах эрхгүй ээ гээд л ингээд л алх тогшигч нь байна шүү дээ. Тэгэхээр эргээд энэ чинь бас иргэдийн бас нөгөө асуудлаа шийдүүлэх, давах эрх нь бас байгаа. Үүнийг юу гэж харж үзэж байгаа вэ?

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

ХЗДХ-ийн сайдын зөвлөх Мөнх-Эрдэнэ Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 75-ын итрих 9 гээд шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрөх гээд ийм зүйл байгаа. Энэ дээр таны хэлсэн давж заалдах шатад гомдол гаргах энэ эрхийг баталгаажуулсан процессыг хуульчилсан төсөлд тусгасан байгаа гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Тэгэхээр иргэний эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ тухайн маргааны онцлог шинжид тохирсон хэрэг хянан шийдвэрлэх энэ арга руу орж байгаа нь өөрөө шүүхийн ачааллыг бууруулах, шүүгчийн ачааллыг бууруулах, зөв хуваарилалт хийх, эцэст нь шударга шүүх буюу яг иргэдийг хохироохгүйгээр зөв шийдвэр гаргахад нөлөө үзүүлнэ ээ гэж үзээд жишигээр бага үнийн дүнтэй энэ асуудлыг оруулж ирж байгаа юм байна гэж би харж байна. Мэдээж энэ бол яг үнэн. Яагаад гэвэл бид нар бас ЧД-ийн жишигээр шүүхийн шүүгчдийн ажлыг харахад нэг хүний ачаалал бол дэндүү ихэдсэн. Тэгээд энэ тэнд байгаа хүн бараг л ар гэр, амьдрал нь байхгүй болчихсон байдаг. Сая түрүүн салбарын сайд бас хэлж байна шүү дээ. Тоног төхөөрөмж тэр ажиллах орчин нөхцөлийн хувьд бол үнэхээр хамгийн хүнд нөхцөлтэй байдаг гэдэг дээр санал нэг

байна л даа. Тэгээд аливаа зүйл бол санхүүжилтгүйгээр гаргасан хууль хэрэгжихгүй шүү дээ. Тэгэхээр та бүхэн маань Энхбаяр сайд хариулах байх. Энэ 2024 оны төсөв дээр яг саяын хэлээд байгаа энэ жишигээр, одоо өнөөдөр энэ хуулийг дэмжээд явчихвал батлаад гараад ирэхэд хэзээ хэрэгжүүлэх юм, хэрэгжүүлэх санхүүжилт нь суугаагүй бол хий дэмий бид нар энэ хуулийг гаргах хэрэг байгаа юм уу гээд. Тэгээд энэ дээр 1 дүгээрт бас тодорхой сайн анхаарч бид нар бас асуудлыг цогцоор нь шийдвэл үр дүнд өгөх байх гэж бодож байна. Яагаад гэвэл энэ Зөрчлийн хуулийг нэг бөөнөөр нь 1 нэгтгэж, Улсын Их Хурлыг гарсны дараа асар их хэргүүд гарсан. Ялангуяа иргэний хэрэг энэ хянан шийдвэрлэхтэй холбоотой бага үнийн дүнтэй юм уу, иргэд хоорондын зөрчлүүд бол асар их нэмэгдсэн. Энэ бидэнд чирэгдэл учруулж байна гээд иргэдтэй уулзахад бол маш их хэлж байсан л даа. Ганц жишээ гэхэд барилгын компани түр хугацаагаар ажиллаж асар нь цалингаа авах гэхээр цалинг нь өгдөггүй, хэдэн сар болчихсон. Энэ маргаанаас болоод шүүх дээр очдог, ажил ч үгүй, амьдрал ч үгүй, орлого ч үгүй болоод. Тэгээд энэнд барилгын компани ч шийдэл гаргадаггүй, шүүгч энэ хугацаа нь удаад яваад байдаг, энэ зүйл ч гэсэн ингээд маш олноороо байж байна шүү дээ. Тэгээд үүн дээр жишигээр иймэрхүү хөдөлмөрийн маргаан энэ тэр дээр бид нар өнөөдөр энэ хуулийг хэрвээ би дэмжээд нэмэлт, өөрчлөлтийг дэмжээд гаргачихвал энэ жишигээр хөдөлмөрийн ийм маргаанууд бүрэн шийдэгдэх бололцоо үүсэх үү? Энэ өөрөө шүүгчийн орон тоон дээр ч гэсэн нөлөөлөх асуудал болно гэж би бол бодоод байх юм. Тэгээд энэ дээр ямар бодолтой байна? Нэгд хариулт авъя.

2-т нь, би бас энэ нөгөө судалгаануудыг хараад үзэхэд Монгол Улсын иргэний хэргийн энэ шүүн таслах ажиллагааны нэгдсэн статистик мэдээн дээр яг шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн үнийн дүнгийн нэхэмжлэл нь өөрөө нэхэмжлэлтэй холбоотой мэдээлэл байдаггүй гээд байгаа юм. Одоо энэ

мэдээлэл байгаа юу? Яагаад гэвэл бас энэ чинь яг үнийн дүнгийн нэхэмжлэлтэй холбоотой мэдээллийг үндсэн статистик дээр нь нэгдсэн систем дээр байж байвал хүмүүс чинь бас энэ хараад түүн дээрээ дүн шинжилгээ хийх, энэ нь өөрөө нөгөө шүүхийн нээлттэй шударга ёсонд бас нийцнэ шүү дээ. Тэгээд энэ мэдээллүүд тусгагдаагүй байдал нь асуудал учруулдаг гээд тэр нээлттэй нийгэм форумын 2022 онд гаргасан судалгаан дээр онцгойлж хэлсэн байна лээ л дээ. Тэгэхээр энэ зүйлүүд засагдаж байгаа юу. Эсвэл та бүхэн сая хэлээд байна. Бид нар тоног төхөөрөмжийн хүндрэлтэй, компьютерын хувьд хамгийн хоцрогдсон учраас нэгдсэн систем дээр жишээлбэл энэ хянан шийдвэрлэсэн үнийн дүнгийн нэхэмжлэлийн мэдээлэл өөрөөр хэлбэл төлбөртэй холбоотой энэ мэдээлэл энэ тэр нь байна уу, үгүй юү гэдэг асуудал байна. Энэ дээр би бас нэг хариулт авахыг хүсэж байна.

2 дахь зүйл нь, энэ судалгаанаас харахад ингэсэн байгаа. Иргэний хуулиар шийдвэрлэсэн иргэний эрх зүйн маргааны ихэнх нь 47 хувь нь энэ эзэлж байгаа хэр нь 34 хувийг нь онцгой ажиллагааны болон бусад хэрэг гэгчихсэн байгаа. Онцгой ажиллагаа гэдэг дээр яг юуг хэлж байгаа юм? Ямар онцгой ажиллагааны маргаан яг иргэнийг хянан шийдвэрлэх дээр ингэж 34 хувь гээд өндөр оноотой байдаг юм бол? Тэгээд энэ дээр бас би хариулт авахыг хүсэж байна.

Тэгээд бид нар нэгэнт л энэ асуудлыг шийдэж байгаа бол цогцоор нь явах хэрэгтэй. Яагаад гэвэл энэ дэндүү их ачааллыг нь үүрүүлчихдэг, тэгээд энэ нь өөрөө эргээд шүүгчдээ ч хүндрэлтэй, иргэдэд бол бүр чирэгдэл учруулсан ийм маргаанууд байгаад байна гэдгийг хэлье.

Нөгөө талаасаа өнөөдөр энэ асуудал хэлж байхад нэг иргэнээс асуудал ярьж байна л даа. 2 иргэн хоорондын нэг эд хөрөнгөтэй холбоотой багахан маргаан юм байна. Тэгсэн чинь нөгөө хүнд нь мэдэгдэхгүйгээр хилээр гарах энэ

хүнийг эрэн сурвалжилж байна гээд баахан олон... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн харилцаа холбооны салбарын ахмад албан хаагчид, социал демократ Монголын залуучуудын холбооны төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн ажил амьдралд сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Асуултад хариулъя. Хэн хариулах вэ? ХЗДХ-ийн сайд Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, ер нь манай энэ иргэний хэрэг бол сүүлийн 10, тэр дотроо сүүлийн 5 жилийн хугацаанд огцом нэмэгдэж байгаа. Хүн амын тоо ч ихсэж байна. Нас залуужиж байна. Гэр бүл ихээр салж байна. Энэний золиос хүүхэд их болж байна. Өмчийн маргаан маш их болсон байна. Иргэд хоорондын бизнес арилжааны гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүдсэн хөрөнгийн маргаан маш их болсон. Энэтэй холбоотойгоор жил тутам өмнөх жилтэйгээ харьцуулахад 4,5 хувиар иргэний хэрэг маргаан нэмэгдээд байгаа юм. Тэгэхээр ерөөсөө сүүлийн 5 жилийн дотор иргэний хэрэг маргаан 2 дахин нэмэгдчихсэн байна. Шууд даблдчихсан гэсэн үг. Тоо. Харамсалтай нь шүүгчийн тоо нь нэмэгдээгүй, цалин нь нэмэгдээгүй, туслах нь нэмэгдээгүй, байранд нь нэг ч төгрөг тавиагүй. Хөдөө шүүгч нар хэргийн оролцогчийнхоо машинд суугаад хэргээ шийдэх гээд явж байна шүү дээ. Машин унаа байхгүй. Сүүлийн 10 жил шүүхэд нэг ч төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээгүй, нэг ч машин шинээр авч өгөөгүй. Хөдөө. Нэг будаг түрхэж өгөөгүй, нэг сандал ширээ авч өгөөгүй, шүүгч нар өөрсдөө хуучирч муудсан ширээ сандлыг нь эвлүүлж, хадаад, бас давхар мужаан болчихсон, шүүх хуралдааны заалаа тохижуулаад байж байгаа. Та

өөрөө үзсэн байх. Асуудал бол нэн төвөгтэй байдалд орсон.

Тийм учраас ирэх онд бол ямар ч байсан шүүхийн цахимтай холбоотой асуудлыг шийднэ. Төсөв мөнгөний хувьд бол үнэхээр анхаарахгүй бол болохгүй. Тэгчхээд шүүхээс шударга ёс нэхээд байх нүүр байхгүй шүү. Их Хуралд лав нүүр байхгүй. 10 жил нэг ч төгрөг хялайлгаагүй байж байж та нар шударга ажилласангүй гэж нэг юу байхгүй.

2 дугаарт, иргэний шүүгчээр зарлаад шүүгч болъё гэдэг хүн байхгүй болчихсон. Хан-Уул дүүргийн иргэний шүүхэд сүүлийн нэг жил шүүгчийн орон тоо зарлаад нэг ч хүн өрсөлдөхгүй байна. 2 сая төгрөгийн цалинтай, цаг наргүй, хувийн амьдралгүй, ийм их өндөр ачаалалтай, ажил хийх хуульч олдохгүй байна, одоо. Бодит байдал нь шүү. Бодит байдал дээр. Тийм учраас энэ асуудлыг бол ер нь цогцоор нь анхаарч, шүүх дээр ер нь 5 жилийн хугацаанд энэ бүх хөрөнгө оруулалт, байр савны асуудлыг нь л шийдэхгүй бол болохгүй ээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулах уу? Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье.

Н.Баасанжав: Би зарим асуултад нь л хариулах юм. Энэ шүүгчдийн тоо нэмэгдэх үү гэсэн асуулт байсан. Тэгэхээр энэ дээр бол нөгөө нэмэгдэхүүний байр л солигдоно гэсэн байдал харагдаж байгаа. Тухайлбал энэ хэргүүд чинь энэ бага үнийн дүнтэй хэрэг байгаа, тэрийг нийт шүүх маань л шийдэж байгаа. Тэгэхээр үүнийг хялбар ажиллагааны гэж нэрлэх юм уу, бага үнийн дүнтэй яг тэр шүүх байгуулагдах юм бол нөгөө ердийн шүүхээсээ 11 саяас доош хэргүүд нь, тэгээд яг энэ төрлөөрөө заасан хэргүүд нь, нөгөө хялбар ажиллагаа дээрээ хүрээд ирэхээр нөгөө шүүх дээр ачаалал нь буураад тэгэхээр ачаалал буурч байгаа хэрээрээ тэндээс шүүгч нарынхаа тоог татчихна гэсэн үг. Тэгэхээр нийт шүүгчдийн маань тоонд бол өөрчлөлт орохгүй. Нэгэнт Энхбаяр сайд бол

шүүхийн орон тоо дутуу зарлаад байгаа боловч ирэхгүй байгааг хариулчихсан учраас ер нь зүгээр яг бүгдээрээ ажиллаж байгаа, ачаалалгүй байгаа гэж үзвэл шүүгч нараа л нааш цааш нь шилжүүлэх л асуудал гарах юм. Тэгэхээр бол яг тэрүүн дээр бол эффект гарахгүй ээ.

Л.Мөнхбаатар: Нэмээд хариулчих тийм ээ. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье.

Н.Баасанжав: Одоо яг манай ШЕЗ-ийн цахим хуудас judcouncil.mn дээр, яг мэдээ хэсэг дээр шүүхийн шууд таслах ажлын статистик гээд ингээд ороод харах юм бол яг ямар ямар төрлөөрөө, ямар хэргүүд шийдвэрлэсэн байгаа. Тэгэхээр энэ дээр бид яг бага үнийн дүн гэдгийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 үржүүлсэн буюу 11 саяас доош байя гэсэн албан ёсны ийм тоо статистикийн баланс интервал гараагүй учраас яг 11 саяас доош гэдэг ингээд ийм үзүүлэлтээр бол статистик байхгүй. Статистикаас дотор юу байгаа вэ гэхээр нөгөө хэргийн төрлүүдээрээ байдаг. Гэр бүл, иргэн, түрээс, зээл, ажил гүйцэтгэх, банкнаас олгосон зээл гэх мэт энэ төрлүүдээрээ байгаа юм. Бид зүгээр энэ хуулийн төсөлтэй холбоотой манайхаас гэхдээ энэ дотор чинь дүн нь ямар байгаа юм бэ гэдгийг тусгайлан судалснаар энэ статистик гарч байгаа. Цаашид бол яах вэ гэхээр 11 саяыг бага үнийн дүн гэж тооцъё. Тэр тоо чинь ямар байх юм гэхээр цаашид бол энэ дүнгээрээ ингээд статистик гараад явчихна гэж ойлгож болно. Одоогоор бол ингээд яг уламжлалт аргаараа гардаг төрлүүдээрээ байж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулж асуух юм уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Иргэний хэргийн хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаа яг бодит утгаараа сайн хөгжсөн улс орнуудад энэ үнийн дүнгийн нэхэмжлэлтэй холбоотой мэдээллүүд нь яг саяын төрөлтэйгөө адилхан ингээд

байж байдаг юм шүү. Тэгээд энэ чинь өөрөө бас нөгөө ил тод, авлига, хээл хахуулиас шүүх ангид байгаа гэдгийг ч гэсэн харуулах нэг жишиг учраас та бүхэн энийгээ давхар хийчих хэрэгтэй. Энэ бол цахимын л асуудал шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэ бол бас байвал зүгээр гэж бодож байна.

Тэгээд сая түрүүн Энхбаяр сайдын хэлсэнтэй бол бас санал нэг байна. Сая энэ зун орон нутгаар явж байхад жишээлбэл шүүхийн байр нь, прокурорын байр нь эвдрээд үнэхээр хүнд байдалд орчихсон, засвар хийх шаардлагатай болсон чинь тэнд шалгагдаж байгаа компанийн захирал нь компани нь хийж өгч байгаа гэгчхсэн яриад сууж байгаа байх. Тэгэхээр яаж шударгаар тэр шүүхийн шийдвэр гарах юм, яаж тэр прокурор тэр асуудлыг хянан шийдвэрлэх юм. Иймэрхүү зүйл бол хэзээ ч байж болохгүй учраас яг энэ удаад зөвхөн Их Хурал биш л дээ. Салбарын сайд бол уг нь Засгийн газар дээрээ энэ хүний нөөц, санхүүжилт, бүх юмаа багцлаад тусгах юмаа тусгаад засаг ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: 2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Энэ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж байна л даа. Энд бас хялбаршуулсан журмаар шүүх, аливаа хэрэг маргааныг хурдан шийдвэр бүхий ийм анхны гарц гаргалгааг хайсан ийм эрлийг хийсэн ийм хууль болж байгаа л гэж ойлгож байгаа. Энд 11 сая төгрөгөөс доош үнийн дүнтэй тодорхой хэрэг маргааныг энэ хурдавчилсан, хялбаршуулсан журмаар шийдэх юм байна гэсэн ойлголт байна. Энд тэр Үндсэн хуулийн шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх хангагдах энэ зарчим чинь ер нь хэр биелэгдэх вэ? Ийм асуудал гарах эрсдэлтэй гэж би хараад байгаа юм.

Тэгэхээр энд ямар бодлого байх вэ гэдэг асуудал байна.

Түүнчлэн шүүх хуралд оролцогчдын эрх үүргийн тухай асуудал. Ерөөсөө өнөөдөр энэ шүүхийн иргэний хэрэг ч бай, эрүүгийн хэрэг ч бай энэ шүүхээс ганцхан л юмыг ард түмэн, иргэд шаардаад байгаа шүү дээ. Энэ шүүх хурал олон удаа хойшилдог. Олон удаа өмгөөлөгч бусад оролцогчид гэдэг оролцохгүй байна. Тодорхой шалтгаануудаар ингээд шүүх хуралд олон удаа хойшилоод, хэдэн жил ч дамнаж хойшилдог. Ийм асуудлаас болж өнөөдөр шүүхэд итгэх итгэл, шударга ёсонд, итгэх итгэл алдардаг. Энэ асуудлыг зохицуулахын тулд хууль санаачлагч ШЕЗ ямар шийдлийг олоод байна. Ямар арга барилыг бид шийдэх ёстой вэ? Төртэйгөө хамтарч, хууль тогтоох байгууллагатай хамтарч үүнийг шийдэхгүй бол бид өнөөдөр тэр шүүхийн нэр хүндийг өсгөх, хуульд итгэх итгэл алдарсан үүнийг босгож ирэх боломжгүй байгаа гэж бодож байгаа. Энэ ямар шийдлийг та нөхөд олж байна аа? Хуульд үүнийг яаж зохицуулах вэ гэдэг асуудал байна.

Дээр нь ингээд анх удаа цахим хэлбэрээр шүүх аливаа маргаан хэргийг шийдэх ийм асуудал өнөөдөр энэ УИХ дээр орж ирж байна. Энэ цахим хэлбэрээр шийдэх шийдэлд гарах үр дагавар гэж олон байгаа. Дэд бүтцийн хувьд, боловсон хүчний хувьд энэ шийдлийг хэрхэн төсөөлсөн бэ? Энд ХЗБХ дээр ч тэр, гишүүд, Учрал гишүүн энэ тэр ярьж л байсан. Энэ дэд бүтцийг эхлээд шийдэж байж хуулиа шийдэх боломж байсан уу, байхгүй юу гэдэг дээр нэг хариулт авъя гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Адьяа гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг хариулах уу? Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье.

Н.Баярмаа: Хурал хойшлох бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулдаг өөрөө нэг шалтгаан мөн. Гэхдээ үүнийг бас 2 талтай авч үздэг ээ.

Нөгөө талдаа нөгөө шүүхээр хэрэг маргааныг шийдвэрлэх гэж байгаа иргэн хэргийн оролцогчийн бас эрх тодорхой хэмжээгээр хангагдах ёстой. Үнэхээр хүндэтгэн үзэх шалтгаануудыг бол бас шүүх харгалзан үзэх ёстой шалтгаанууд байдаг. Тэгэхээр тэр талд нэгэнт маргаанаа шийдүүлж, байгаа, тэгээд ялангуяа иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа талуудын зарчим дээр явж байгаа нотлох баримтаа гаргахад ийм хүндрэл байна эсвэл хуралд оролцоход ийм хүндрэл байна гэдгийг бид нар авч үзэхээс өөр аргагүй байдал үүсдэг ээ. Гэхдээ энэ бүхнийг шийдвэрлэх гарцаа ШЕЗ-өөс юу гэж авч үзээд байна гэхээр ядаж энэ процессыг бид нар тэр хүсэлтүүд гарахыг цахимаар авах, цахим платформ ашиглах байдлаар, 2-т нь шүүх хуралдаануудын товыг урьдчилан эрт гарч байгаа тохиолдолд нэг өмгөөлөгч байгаа, эсвэл нэг хэргийн оролцогчид итгэмжилсэн төлөөлөгчид, олон шүүх хуралдаан дээр давхар оролцож байгаа тохиолдолд тов давхцахгүй байх. Хамгийн түрүүн шүүх хуралдаанаа товлосон тэр шүүхийн тов бусад шүүхүүдтэй нээлттэй тэр платформ хөгжихөөр, систем хөгжихөөр, нөгөө цахимжуулалтаар гэсэн үг шүү дээ мэдэгддэг байгаад бусад шүүхүүдийнхээ талаасаа хурлыг давхцуулан товлохгүй байх зэрэг яг ийм зохион байгуулалтын ажлыг бид нар хийх байдлаар тодорхой хэмжээний ахиц гаргаж бол чадна гэж харж байгаа.

Зүгээр тэр үндсэн эрх рүү бол орох нь бас төдийлөн төвөгтэй. Түүнийг бол хуулиар аль болох боломжит хэмжээнд бид нар ухаалгаар л зохицуулах тийм боломж бүрдэх байх.

Дэд бүтцийн хувьд 2 дахь асуултын хувьд эхлээд дэд бүтцээ хийж байж хууль нь орох юм уу, эсвэл хууль нь орж байж дэд бүтэц нь бий болох юм уу гэдэг дээр ер нь энэ цахимаар явна гэдгийг бол систем нэвтэрч байгаа л гэж уг нь ойлговол зохилтой байгаа юм. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дээр байгаа мэдүүлэх гэдэг юм уу нотлох баримт гаргах гэдэг юм уу тэрэн дээр бол

онцгой өөрчлөлт гарахгүй шүү дээ. Тэгэхээр мэдүүлдэг бол хэвээрээ. Нотлох баримт гэдэг хэвээрээ. Гагцхүү тэр нь системээр л явах. Мэдүүлэхдээ системээр мэдүүлнэ. Нотлох баримт нь өөрөө анхнаасаа тэр цахим хэлбэрээр үүсчихсэн байвал бид нар цахимаар авч чаддаг л шүүх байх ёстой. Цаасан хэлбэрээр үүсчихсэн бол цаасаар авч чаддаг л шүүх байх ёстой байгаад байгаа юм. Тэгээд 2 талууд хоорондоо анхнаасаа хийгдчихсэн цахим гэрээг бид нар манайд тийм юм байхгүй ээ гээд хүлээж авахгүй байж л болохгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр нийгмийн харилцаа маань өөрөө хурдтай хөгжөөд, бизнесүүд бас илүү хурдтай байгаад, энэ гэрээ тэгээд баримтууд бүрдэх чинь өөрөө цахим хэлбэр дээр нэгэнт бий болчихоод байгаа. Гэтэл нөгөө талдаа цаасан хэлбэрээрээ явж байгаа бас маш их байна. Тэгэхээр бид нар аль алийг нь авч чаддаг тийм л шүүх байх ёстой байгаад байгаа. Тэгэхээр бол энэ ерөөсөө дэд бүтцийг хийх төдийлөн хуулийг хүлээхгүйгээр бид нар платформыг хийж л байх ёстой. Дээрээс нь энэ хуулийн орчин нь бол тэр үүсчихсэн зах ... /минут дуусае/

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууя.

Ш.Адьяа: Энэ их бага дүнтэй хэрэг маргаан гэж ер нь байхгүй л дээ. Бүгд л энэ өөрийнх нь эрх ашигтай холбоотой асуудал. Энэ дээр хамгийн гол асуудал бол өнөөдөр энэ хурдан шуурхай шийдэх, олон удаа хэрэг маргаан буцдаггүй байх, энэ ард иргэдийг чирэгдүүлж залхаадаггүй байх, одоо энд бид энэ хуульд ер нь энэ хуульд өөрчлөлт оруулах олон асуудал байгаа. Нэг өмгөөлөгч авдаг, өөрт нь таалагдахгүй болохоор өмгөөлөгчөө сольдог, шүүгчээсээ татгалздаг гэх мэт ийм асуудлуудыг үргэлжилсээр байгаад нэг хэрэг маргаан нь 1 сараас 2, 3 жил хүртэл үргэлжилдэг юм шүү дээ. Үүнийг хуулиар зохицуулах ийм шийдлийг бол бид бүгдээрээ олох ёстой байхгүй юу. Энэ дээр ШЕЗ энэ хууль санаачлагч Хууль

тогтоомжийн тухай хуулиар бол энэ энэ Их Хурлын гишүүдийн асуудал биш. Энэ хууль санаачлагч Засгийн газрын асуудал энэ ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Адьшаа гишүүний асуултад ХЗДХ-ийн сайд Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Сая хавар Тэмүүлэн гишүүн Төсвийн байнгын хорооны дарга бас анхаараад бид энэ шүүхийн ачаалал дээр гүйцэтгэлд суурилсан бас үнэлгээ хийж үзсэн. 9 сард энэ үнэлгээний тайлан гарсан. ХЗБХ-ны гишүүдэд ирээд тараагдсан байгаа. Энэтэй Адьшаа гишүүн маань ХЗБХ-ны гишүүний хувьд уншиж танилцаарай. Нэг шүүгчид ногдож байгаа ...

/2:13:15.2-2:30:41.7 хүртэл чуулганы нэгдсэн хуралдааны бичлэг байхгүй, тасалдав/

12.32 цаг

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

Г.Занданшатар: Амгаланг айлтгая. Улсын Их Хурлын намрын чуулганы 10 дугаар сарын 27-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалдаа оръё.

Үдээс хойших хэлэлцэх асуудалдаа оръё.

Баттөмөр гишүүний тавьсан асуулгын хариуг сонсох асуудал байна.

Эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.1 дүгээр зүйлд заасны дагуу, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу, Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын чуулганд мэдээлэл хийх үүрэгтэй нэг асуудал байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1-д Монгол Улсын засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн эрхт шууд оролцож мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ гэж заасан.

Мөн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12-т төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага албан тушаалтан иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй гэж заасан байдаг. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн иттрих 1-д Үндсэн хуульд заасан энэхүү засаглах эрхээ ард түмэн эдлэхдээ тодорхой асуудлуудыг шийдвэрлэх талаар асуулт асуух, санал өгөх эрхээ Улсын Их Хурлын албан ёсны программ хангамжуудаараа дамжуулан хэрэгжүүлж болно гэж заасан. Түүнчлэн Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд иргэдийн тавьсан асуудлуудыг Улсын Их Хурал хэлэлцэхээр заасан. Эдгээр хуулийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ди-парламент цахим платформын шинээр нээсэн ди-өргөдөл цахим системд нийтдээ 489 санал ирж, үүний 50 хувь нь буюу 200 гаруй санал нь нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой ийм давхацсан саналууд ирсэн.

Мөн албан бичгээр Худалдаа аж үйлдвэрийн танхим, Сео клуб зэрэг төрийн бус байгууллагууд, олон нийтийн зүгээс олон давтамжтай ирсэн учраас 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Ди платформын ди өргөдөл системд НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэхийг дэмжиж байна гэсэн асуултыг энэ олон нийт төрийн бус байгууллагуудын саналын дагуу тавьсан. Уг асуултыг 2023 оны 10 дугаар сарын 23-ны байдлаар буюу 6 хүрэхгүй хоногийн хугацаанд 104791 иргэн дэмжиж, дан системд цахим гарын үсгээрээ саналаа

өгсөн байна. Энэ бол Монголын парламентын түүхэнд иргэд анх удаа төрийн хэрэгт цахимаар шууд, бодитой оролцсон ийм үйл явдал энэ өнгөрсөн 7 хоногт болж өнгөрлөө. Үүнтэй холбогдуулан энэхүү мэдээллийг хийж байна.

Монгол Улсын энэ дан систем, цахим гарын үсгээрээ өгсөн энэ саналд тийм зүгээр нэг дэмжээд санал өгчихсөн хэрэг биш. Иргэд ухамсартай тодорхой зорилготой өгсөн ийм санал бодлоо илэрхийлснээ уламжилсан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 1 дүгээр тогтоолоор баталсан журамд хэрэв иргэдийн санал 100 мянгад хүрсэн бол 30 хоногоос өмнө дуусгавар болгож болно. Санал авах ажиллагааны үр дүнг Тамгын газар ажлын 3 хоногт багтаан Улсын Их Хурлын даргад хүргүүлнэ. Журамд заасан шаардлагыг хангасан буюу 100 мянган хүний гарын үсэг цугларсан бол холбогдох Байнгын хороо 14 хоногийн дотор авч хэлэлцэнэ. Хуулийн төслийн талаарх саналыг 100 мянга ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол Улсын Их Хурлын дарга уг асуудлын талаар Улсын Их Хурлын чуулганд мэдээлж, холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ гэж заасны дагуу нийтийн өргөдлийн дүнг чуулганы нэгдсэн хуралдаанд мэдээлж, Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэх талаар олон тооны санал Улсын Их Хурлын даргын нэр дээр ирсэн. Мөн үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, Сео клуб саналаа ирүүлж, тооцоо судалгаа ирүүлсэн. Монголбанк, ҮСХ, Үндэсний аудитын газар холбогдох судалгаа хийж, дүгнэлт гаргасан. Эдгээр санал, дүгнэлтүүд төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирсэн, иргэдээс ирсэн саналуудыг нийлүүлж энэ өргөдлийг цахим системд би оруулсан. Ингэснээр улс орны эрх ашгийн төлөө олон нийтийн

санал бодлыг цахимаар, бодитоор сонсох хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах бодит жишиг болно. Өөрөөр хэлбэл ард түмний төлөөлөгчдийн байгууллага ард түмнийхээ санал бодлыг шууд сонсож, үндэслэж асуудал хэлэлцэх ийм Үндсэн хуулийн заалт дамжиж хэрэгжиж байгаа юм.

2 дугаарт, технологийн дэвшил буюу ди-парламент цахим систем ашиглан төр, иргэний холбоог ойртуулах, улмаар төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх чухал бодитой алхам болно гэж цахим дэвшлийг үзэж байгаа.

3 дугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1-д заасан засаглах эрхээ ард иргэд анх удаа ил тод, нээлттэй, бодитой хэрэгжүүлж чадлаа.

Иргэдийнхээ үзэл бодлыг эрхэмлэн сонсож, хууль тогтоох нь Монгол төрийн үндсэн зарчим тул Улсын Их Хурал анх удаа нийтийн өргөдлийг хуулийн дагуу хэлэлцэх гэж байна. Мэдээж хэрэг аливаа асуудал эерэг, сөрөг тал, бэрхшээл ололтыг аль алийг нь үүсгэнэ. Энэ асуудлын тухайд улсын төсөвт тодорхой хэмжээний ачаалал үүсгэх нь бодит үнэн. Тийм учраас эерэг, сөрөг талыг Төсвийн байнгын хороо энэ хууль, журмын дагуу нарийвчлан хэлэлцэж шийдэх ёстой.

Өнөөдөр иргэн бүрийн нүдэн дээр ил байгаа НӨАТ-тай холбоотой нэг асуудал бол аль ч дэлгүүр, худалдааны байгууллагуудаас бараа худалдан авахад НӨАТ-ын 10 хувиар наймаалцаж байгаа бодит байдал юм. Энэ бодит үнэнийг нуухын аргагүй. Өөрөөр хэлбэл бараа авахад НӨАТ-тай авах уу, НӨАТ-гүй авах уу гэж асуудаг. Хэрвээ НӨАТ-гүй авъя гэвэл и-баримт өгөхгүйгээр үйлчилдэг, орлогоо нуудаг. Иргэд маань хууль зөрчиж байгаагаа мэддэг ч 2 хувийн буцаан олголтоос 10 хувийн НӨАТ төлөхгүй байхыг илүүд үздэг нь хэвийн үзэгдэл болсон. Нийгэмд ил байгаа энэ асуудлыг, хуулийн зөрчлийг бид засахгүй, арга хэмжээ авахгүй, шийдвэр гаргахгүй төлөөлөгчдийн байгууллага байж

таарахгүй. Иргэд нь ч, албан байгууллагад нь ч хууль зөрчөөд байгаатай эвлэрээд ингээд суугаад байна гэдэг бол хууль хэрэгжихгүй байх үндсэн шалтгаан болдог. Өөрөөр хэлбэл тэмээ хяруул толгойгоо элсэнд нуучхаад бусдыг харахгүй байна гэж бодохтой ялгаагүй зүйл болно.

2 хувийг 5 хувь болгосноор төсөвт нэмэлт зардал гарах ч орлого тал дээр нэмэлт орлого орж ирэх бололцоотой. Өөрөөр хэлбэл ил тайлагнасан тооцоонд 4,4 их наяд төгрөг 50 сая төгрөгөөс дээш орлоготой иргэн, ААН байгууллагууд НӨАТ төлөөгүй ийм бодит тооцоо судалгааг Статистикийн газар гаргасан. Энэ нуусан орлого ил болж нэмэгдэхээр зөвхөн НӨАТ-ын орлого ч биш бусад татварын орлого ч дагаад нэмэгдэх учиртай. Гэтэл энэ нэмэгдэх орлогыг ярихгүй зөвхөн зардал талаас нь харж өрөөсгөл ойлголтыг бас төрүүлж болохгүй. Аль алийг нь тэнцвэртэй, нухацтай судлах ёстой.

НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэх нь шууд татвар бууруулж байгаа хэрэг биш бөгөөд иргэдийн баримт авах, түүнийгээ системд бүртгүүлэх сэдлийг нэмэгдүүлж энэ хэмжээгээр и-баримтын олголт нэмэгдэнэ. И-баримтын олголт нэмэгдэх хэрээр далд эдийн засаг ил болно.

Монгол Улсын далд эдийн засаг, Дэлхийн банк, ОУВС, Монголбанкны хийсэн судлаачдын судалгаагаар далд эдийн засгийн хэмжээг 16,5-22,5 хувь байна гэж дүн гаргасан. Улаанбаатар хотын 15 худалдааны төвийн 279 цэгээс авсан тандалтаас үзэхэд тандалт ажиглалтаас үзэхэд ҮСХ-ноос хийсэн тандалтаас үзэхэд худалдаа эрхлэгчдийн 53 хувь нь и-баримт өгдөг байна. Тэгэхдээ и-баримтыг зөвхөн иргэд шаардсан тохиолдолд эсвэл үнийн дүн өндөртэй бараанд л ихэвчлэн өгч байгаа нь тогтоогдсон. Тэднээс асуулга асууж ярилцахад сүүлийн үед НӨАТ-ын буцаан олголттой холбоотойгоор иргэд и-баримт шаардах явдал нэмэгдсэн учир и-

баримтын олголт нэмэгдэж байгаа гэж ярьсан. Зөвхөн энэ мэдээлэл ард иргэдийн санхүүгийн боловсрол дээшлэхэд ийм хандлага нэмэгдэж байгаа юм чинь бодитоор энд далд эдийн засгийг шаардах ямар боломж гарах вэ гэдгийг харах ёстой.

2 дугаарт, төлөх татварын хэмжээ нэмэгдэнэ. Өнөөгийн байдлаар хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 34,9 хувь нь и-баримтад бүртгүүлсэн байна. 50 саяас дээш борлуулалттай НӨАТ төлөгч биш 4292 хувиараа хөдөлмөр эрхлэгч байгаа бөгөөд тэдний нийт борлуулалт 2022 онд 1,9 их наяд төгрөг байжээ. Энэ 50 саяас дээш орлоготой мөртөө татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдаагүй энэ хэсэг НӨАТ төлөөгүй байна.

Мөн 50-аас дээш 50 саяас дээш борлуулалттай 5,4 мянган ААН НӨАТ төлөгч биш байна. Тэдний нийт борлуулалт 2022 онд 2,5 их наяд төгрөгт хүрсэн байна. НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлснээр юуны өмнө татварын системд бүртгүүлсэн ч төлөөгүй байгаа эдгээр 4,4 их наядын орлогод татвар тооцох боломж бүрдэнэ гэж үзсэн байна.

3 дугаарт, иргэдийн засаглах эрхээ хэрэгжүүлэх, хууль тогтоох үйл ажиллагаанд шууд оролцох, тухайлбал, татварын боловсрол, санхүүгийн боловсрол, мэдлэгээ тэлэх сайхан боломж бас бий болж байна. Ди-парламент, ди-өргөдлийн цахим системийг ашигласнаар иргэд маань маш чухал ойлголт мэдээллийг бас авч чадлаа. 30 мянга, 70 мянга, 100 мянган иргэн нэгдэж саналаа өгвөл цахимаар нь төрийн хэрэгт оролцовол ямар ажиллагаа хийгддэг, ямар боломжууд байдгийг бас мэдэж авлаа. Энэ боломжийг үр дүнтэй ашигласнаар төр, иргэний харилцаа холбоо сайжрах, зөвхөн энэ тохиолдолд гэхэд татварын шударга орчин бий болж, иргэдийн хэвтээ хяналт, хариуцлагын тогтолцооны үр дүнд авлига, хууль бус үйлдэлтэй тэмцэх шинэ хөшүүрэг болно.

Энэ Монгол Улсын Ерөнхий сайдын авлигатай тэмцэх энэ санаачилгыг дэмжиж байгаа, ард иргэдийн хөдөлгөөнийг дэмжиж байгаа, шударга бус үйлдлүүдтэй тэмцэж байгаа үйл ажиллагааг урамшуулж байгаа хэлбэр гэж бас нэг талаасаа хэлж болно.

Энд бас нэг асуудлыг онцолж тэмдэглэе гэж бодож байна. НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэх саналыг дэмжсэн 104791 иргэнд саналаа өгсний 30,4 хувь нь 18-25 насныхан, 21,8 хувь нь 26-30 насныхан, 22,3 хувь нь 31-35 насныхан байна. Өөрөөр хэлбэл 18-35-ны насны залуус нийт санал өгөгчдийн 74,5 хувийг эзэлж байна. Бид залуусынхаа оролцоог үгүйсгэдэг байсан ч асуудал тэдэнд биш бидэнд байсныг эндээс харуулж байна. Шинэ үеийн залуус тодорхой, зөв бодлого дээр өндөр идэвхтэй, зөв чиг баримжаатай оролцож чадна гэдгээ харууллаа. Тэд зөв үйлдэлд цахимаар нэгдэж чадна гэдгээ ч илэрхийллээ. Түүнчлэн санал өгсөн хүмүүсийн 70 хувь нь эмэгтэйчүүд байлаа. Эмэгтэйчүүд өрхийн санхүүгийн гол оролцогч, худалдан авагч татварын хэмжээ НӨАТ-ын буцаан олголт тэдний санааг зовоосон асуудал мөн болохыг үгээр нотлогдож байна.

2023 оны 10 дугаар сарын 26-ны байдлаар ди-өргөдөл буюу дан систем нь цахим гарын үсгээр баталгаажсан 389 иргэн 453 нийтийн өргөдөл санаачлаад байна. Тэдгээрээс 250 гаруй иргэдийн санал нь НӨАТ гэсэн санал байсан учраас нэгтгэж оруулсан. Нэг хүний нэр дээр би оруулснаар нэг аль нэгийг нь оруулж болохгүй учраас олон төрийн бус байгууллагууд байсан учраас тэдгээрээс бусад 48 иргэд л 48 өргөдөл шаардлага хангаж нийтлэгдсэн. Одоогоор нийтдээ бас 302795 иргэн дэмжиж, хэлэлцэгдэж байна. Нийтлэгдээгүй өргөдлийн 50,6 хувь буюу 205, ингээд энэ олон саналууд ди-өргөдлөөр дамжуулан иргэд маань тулгамдсан асуудал санал бодлоо илэрхийлж байна.

Иймд та бид бас үүнийг анхааралдаа авч, холбогдох шийдвэр гарах үйл явц цаашидаа бас идэвхэжнэ гэсэн үг.

Монголын төр иргэдээсээ хоцорсон гэдгийг хүлээн зөвшөөрөх цаг болсон. Монголын төрийн хөшүүн байдал, шинэчлэлээс тойрдог айдас урагшлах замаас ухрааж байна. Гэтэл иргэд шинэчлэл, өөрчлөлтийг хурд маневрыг үсрэнгүй хөгжлийг хүлээж залхаад биднийг шүүмжилж байна. Асуудлыг деталь бүр дээр нийгмийн эрүүл хэлэлцүүлэг явж байхад бид бас энд мэтгэлцээд буруу хараад сууж байж таарахгүй. Тэгээд энэ өөрчлөлтийн цаад углуургад нь бид нийтийн санхүүгийн реформыг эхлэх шаардлагатай байна. Нийтийн санхүү, төсвийн орлого, зарлага энэ бүхэн дээр цогц реформыг нийгэм шаардаж байгааг харуулж байгаа юм. Энэнээс хөвөрч бид энэ төсвийн зардлын тогтолцоонд, татварын тогтолцоонд цогц реформ хийх энэ өөрчлөлт эхлэх учиртай.

Төрийн санхүүд зөрчил хавтгайрч, төсөвт хулгай нүүрлэж, тендерт авлига гаарсан байна гэж иргэд саяхны судалгаагаар дуу нэгтэй шүүмжилсэн байна. Татвар, шимтгэл, түүний бүрдүүлэлтийн хэт харьцангуй байдлууд, Засгийн газрын өр, ТӨК-уудын үрэлгэн байдал гээд зайлшгүй шийдэх олон асуудлууд бий. Одоо эхлүүлье. Эхлүүлэхдээ хамгийн том хүрээг хамарсан нийтийн шууд сонирхолтой холбогдож байгаа энэ худалдан авалт, худалдааны хэрэглээний татвар болох эцсийн хэрэглэгчийн төлдөг татвараас энэ хэвтээ хариуцлагыг бий болгож, ард иргэдийнхээ хяналтын доор, ард иргэдийнхээ мэдлэг мэдээллийг сайжруулах замаар далд эдийн засгийг илчлэх, авлигын мөнгийг бүртгэлжүүлэх зэрэг олон асуудлууд эндээс хурч идэх учиртай.

Бид том улс, цөөхүүлээ үндэстэй. Гэтэл бид нэгдмэл үнэт зүйлсийн хомстолд орж ард түмний эв нэгдэл суларсаар байгаа. Төр, иргэний итгэлцэл

ямар түвшинд байгааг бид бүгд мэдэж байгаа. Энэ бүхний шийдэл нь оролцоог дэмжсэн засаглал байх болно гэдэгт итгэлтэй байна. Төрийн бодлого шийдвэрүүд нийтийн оролцооны зөвшилцөл хэлэлцүүлэг дээр үндэслэгдэн гарч байвал ард түмэнтэйгээ хамт нэг зүгт харж чадаж, нэгдмэл үнэт зүйлс маань сэргээж, итгэлцэл сайжран, эв нэгдэл бэхжих үндэс болох нь гарцаагүй.

Монголын нийгэмд бухимдал их байгааг нуух хэрэггүй. Стратеги судалгааны хүрээлэнгээс саяхан хийсэн судалгаагаар нийгмийн бухимдлын түвшин хамгийн өндөр түвшинд, бухимдал үүсгэж байгаа үндсэн шалтгааны эхний 5-д үнийн өсөлт, авто замын түгжрэл, ажилгүйдэл ядуурал, худалдан авах чадвар, өрхийн хомстол, авлига хээл хахууль, шударга бус байдлыг нэрлэсэн байна. Нэн даруй шийдвэрлэхийг хүсэж байгаа нийгэмд тулгамдсан асуудлын нэгээр татварын бодлогыг өөрчлөх, НӨАТ-ыг өөрчлөх, бизнесийг дэмжих гэж нэрлэсэн байгааг бид анхааралдаа авах ёстой.

Татварын тогтолцооны реформын хүрээнд иргэдийнхээ саналаар НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэх замаар энэ бодит шинэчлэлийг нэг жилийн хугацаанд хэрэгжүүлчхээж болно гэсэн ийм саналууд бас ирсэн байна. Тиймээс төрийн бодлогод өөрийн саналаа өгч, өөрчлөлт хийх үйл хэргийг манлайлсан Монгол Улсынхаа зургаахан хоногийн дотор ийм санал өгсөн Монгол Улсынхаа 104791 иргэнд Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Цаашид засаглах эрхээ цахимаар хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг ард түмнээсээ хүсье. Ардчилалд ард түмнийг мэдээлэлгүй гэж басаж болдоггүй. Татвар бууруулахыг 3 саяулаа дэмжинэ гэж бодож болохгүй. Тэр саналууд нь ийм 100 мянгад хүрээгүй. Харин энэ дээрээ дагаад чирэгдээд өсөөд байсан бол энэ саналыг, санал асуулгыг системээс авснаас хойш тэр сааралт

өсөлт буурч байх жишээтэй. Ард түмэн ухаантай, энүүгээр юугаар юу хийдгийг сайн мэдэж байдаг. Ийм учраас үүнийг нарийвчлан судлах цаашидаа ч асуудал болно гэж итгэж байна.

Ингээд цаашид засаглах эрхээ цахимаар хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг дахин ард түмнээсээ хүсье.

Ер нь энэ мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд ирүүлсэн үндэслэл, саналууд 100 мянга хүрсэн саналыг Улсын Их Хурлын чуулганд мэдээлж, холбогдох байнгын хороонд шилжүүлнэ гэж заасны дагуу ингээд Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Мэдээлэл хийлээ. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тухай хуульд заасны дагуу мэдээлэл хийлээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Сайд нар ирсэн байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Монгол улсын ерөнхий сайдад хандаж “Ирээдүй өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсоно.

Асуулгад Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс “Ирээдүй өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын дагуу холбогдох мэдээллийг бэлтгэн танилцуулж байна.

Ирээдүй өв санд Хүний хөгжил сангаас шилжин ирсэн өр төлбөрийг 2019 онд бүрэн барагдуулж дуусгаснаар тус санд хуримтлал үүсэж эхэлсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар Ирээдүй өв санд 2,7 их наяд төгрөгийн хуримтлал үүсээд

байна. Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсын төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,3 их наяд байгаа. Өөрөөр хэлбэл тус Ирээдүйн өв сангийн 2,7 их наяд төгрөг нь бүрэн мөнгөн хөрөнгөөр баталгаажиг байна гэсэн үг.

Өнгөрсөн 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, ирээдүй өв сангийн хөрөнгийг 2025 он хүртэл Засгийн газрын гадаад өрийн дарамтыг харгалзан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хуримтлуулна гэж өөрчилсөн байгаа. Ирээдүй өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд 22 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн оруулсан өөрчлөлтийн хүрээнд 23 онд тус санд нэмж 550 тэрбум төгрөг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгаснаар 2024 онд 1,3 их наяд төгрөгийн орлого нэмж төвлөрүүлэхээр хуримтлал үүсэхээр байна.

Сангийн яам нь тус сангийн хөрөнгийн удирдлагын хэрэгжүүлэхдээ ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сан зэрэг өнгөрсөн хугацаанд гарсан гишүүн туршилагаас сургамж авч, өндөр хүүтэй, өндөр ашигтай хөрөнгө оруулалт гэхээс илүүтэйгээр ирээдүй хойч үедээ зориулж хуримтлуулж байгаа хөрөнгийг найдвартай аюулгүй хадгалах чиглэлд анхаарч ажиллаж байна.

Мөн түүнчлэн 2025 он гэхэд Ирээдүй өв санд хуримтлагдах мөнгөн хөрөнгийг Ирээдүйн өв сангийн тухай хуульд заасан дагуу сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх корпорацад бүхэлд нь хүлээлгэж өгөхөөр үе шаттайгаар арга хэмжээ аван ажиллаж байна. Өөрөөр хэлбэл 2024 оны 12 сарын 31 гэхэд бий болгох хуримтлал буюу ойролцоогоор 4,3 их наяд төгрөгийг 100 хувь мөнгөн хөрөнгөөр хүлээлгэж өгөхөөр

одоогоос бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Асуулгын хариулттай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлье.

Тэр хооронд ажлын хэсгийн гишүүдийг танилцуулна. Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Бэлтрэгийн Цогбадрах, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Нарангийн Мөнхсүх.

Батсуурь гишүүнээр тасаллаа. Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Ирээдүйн өв сангийн хууль 2016 оны 02 сарын 05-нд батлагдаад 2 сарын 10 юу, 2017 оны 01 сарын 01-нээс эхлээд мөрдөгдсөн. 8 дахь жил рүүгээ ороод явж байгаа. Энэ юу вэ гэхээр энэний зорилго юу вэ гэхээр нөхөн сэргээгдэх баялгаас улсын төсөвт төвлөрүүлэх, ирээдүй хойч үедээ тэнцвэртэй хуваарилах зарчмыг бий болгох, макро эдийн засгийн үр ашигтай удирдлагын тогтолцоог л бүрдүүлэхэд л энэ хуулийн зорилго чиглэж байсан.

Асуулт байна. 1 дүгээрт нь, 2017-22 оны хооронд ирээдүйн өв санд 5 их наяд 488 тэрбум төгрөг цугларч, 2 их наяд 870 тэрбум төгрөг нь зарлага гарч, 2,7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаад байна. Энд яагаад ашигладаггүй байгаад байна. Энийг яаж байна гэсэн Засгийн газрын хариулт бол сангийн хөрөнгийг гадаад зах зээлд удирдах ажил

удааширалтай байна. Дагаж мөрдөх хуулийг ковид манай эдийн засагт үүсгэх сөрөг нөлөөллийг бууруулах, валютын нөөцийг хадгалах зорилгоор 2025 оныг хүртэл хойшлуулсан гэж байгаа байхгүй юу. Яагаад 5 жил хойшлуулдаг юм бэ. 1, 2 жил яагаад хойшлуулж болоогүй юм. Бид 5 жилийн дараахыг харж чадаж байгаа юм уу? Энд эхний асуулт байна.

2 дахь асуулт. Ковид 2022 онд дууссан. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зарлачихсан шүү дээ. Тэгээд 2,7 их наяд төгрөг хадгалагдсаар байдаг. 2020-22 онд инфляц ойролцоогоор нэг 35 орчим хувийн инфляцтай. Зөвхөн 22 онд гэхэд л Монгол төгрөгийн ханиш 20 хувиар уначихсан байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 2,7 их наяд төгрөгийн үнэ цэн хэдэн хувь уначхаад байна. Энэ их мөнгийг гадаад зах зээлд эрсдэлтэй гэж үзсэн бол дотоодын зах зээлд ашиглаж болохгүй байсан юм уу. Хуульдаа өөрчлөлт оруулаад ашиглах боломж байгаагүй юм уу гэсэн асуулт байна.

Монголбанкны бодлогын хүүгээр бодохоор 13 хувиар хадгалахад л үнэ цэн нь багасах ийм боломж бас байсан. Үнэ цэнийг нь уналтыг бууруулах чиглэлээр юу хийсэн бэ гэж. Алдагдсан боломжийн тооцоо гэж юу байна?

Хуулийн 6.3.1-д сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хадгалах арвижуулна гээд заачихсан. Энэ асуудалд ер нь ямар хариулт өгөх вэ?

3 дахь асуулт. Сангийн хөрөнгийг удирдуулахаар гаднын баахан компаниуд бичиг илгээгээд 11 санал ирж, 8 компани татгалзаж, 3 компани удирдах саналаа илэрхийлсэн. Энэ 3 компанитай яаж ажилласан юм бэ?

Монголбанкаар удирдуулна гэсэн чинь Сангийн яам, Монголбанк 2 хоорондоо тэр нэг шимтгэл дээрээ тохироогүй байгаа юм. Үүнийг ЗГ, Их Хуралд танилцуулсан юм уу?

Ковид дуусаад нэг жил боллоо. Ирээдүйн өв сангийн энэ 2,7 их наяд төгрөг 25 он хүртэл ингээд хадгалагдаад байх уу? Үүнийг тэр ковидтой холбох арга хэрэггүй л дээ. Энэ чинь өөрөө цахимаар явагдана шүү дээ. Гадаа зах зээлээс арилжаа.

Г.Занданшатар: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Үүнийг Сангийн яам мэдээж удирдаад 25 он хүртэл хойшлуулаад ч юм уу эсвэл гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хийж хөрөнгийн зах зээл дээр эргэлдүүлэхгүй өгөөж хойшлуулаад байгаа зүйл огт байхгүй шүү. Энэ Ирээдүй өв сангийн хуульд 2020 оны 8 сард орсон өөрчлөлтөөр Ирээдүй өв сангийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг Сангийн яамны дэргэд байдаг Төрийн сан дотор хийж удирд аа гэсэн ийм үүрэг энэ хуулиар өгсөн байгаа. 25 оны 01 сарын 01-нээс корпорацад цаашид удирдуулах тэр үед мөнгөн хөрөнгөөр тусгаарлаж өгөх ийм цаг хугацааны бид даалгавартай явж байгаа. Тэгэхээр саяын таны асуудаг тэр гадаадын хөрөнгө оруулалтын компаниудад санал тавьж байсан юм байгаа юм байна лээ. Тэр нь 19 он хүртэл шүү. Өөрөөр хэлбэл Төрийн санд ороогүй, Төрийн сангаас наана тусдаа байх үед нь ийм ингэж удирдах ийм хувилбарууд байсан юм байна лээ. Одоо бол Төрийн сан дотор явж байгаа учраас төв банк дээр манай Төрийн сангийн данс байдаг. Тэнд өнөөдрийн байдлаар 4,3 их наяд төгрөгийн мөнгөн хөрөнгө байгаа. Өөрөөр хэлбэл ирээдүйн сангийн өнөөдрийн 2,7 их наяд маань 100 хувь мөнгөн хөрөнгөөр баталгаажгаад ингээд байж байгаа юм.

Тэгэхээр бид нарын энэ яг цаг хугацааны үүрэг даалгавар юу вэ гэхээр 24 оны 12 сарын 31 хүртэл одоо байгаа энэ ирээдүй өв сангаа нэмж хуримтлуулаад, энэ жил нэг 550-аар нэмэгдэх байх. Хойтон 1,3 орчмоор нэмэгдэх байх. Ингээд нийтдээ нэг 4,3 орчим болох болов уу хойтон. Тэгэхдээ үнэхээр манай гол

гадаад түүхий эдүүдийн үнэ сайн байх юм бол энэнээс ч нэмэгдэх ийм боломжтой. Гэтэл ийм хөдөлгөөнтэй байдаг ийм зүйл. Тэгвэл тэр мөнгийг тухайн үед нь буюу ирээдүйд 25 оны 01 сарын 01-нд 100 хувь мөнгөн хөрөнгөөр тусгаарлаж өгөөд, цаашаага харин яг таны хэлж байгаа шаардаж байгаа шиг Хөрөнгө оруулалтын санд хийнэ үү, эсвэл Төв банкандаа хадгалуулна уу, эсвэл дотоодынхоо зах зээл дээр эргэлдүүлж өсгөх үү гээд ийм зүйлүүд яригдана. Харин бид нарын үүрэг дахиад хэлье. Одоо аюулгүй хуримтлуулаад 25 оны 01 сарын 01 гэхэд мөнгөн хөрөнгөөр 100 хувь тусгаарлаж өгөх л ийм цаг хугацааны зорилготой явж байгаа.

Хэрвээ алдагдсан боломж ярих юм бол зөвхөн ирээдүй өв сан дээр биш Монгол Улс тэр чигээрээ л яригдах ёстой. Сүүлийн 3 жилийн хугацаанд Төрийн сан бид маш хүнд ийм үеийг хөнгөрүүлж туулаа. Гэсэн хэдий ч Засгийн газрын болон дотоод болон гадаад өр дээр бид нар ямар нэг дефолт үүсгэхгүйгээр бүх зүйлийг амжилттай зохицуулж чадсан. Засгийн газрын энэ төрийн бүхий л Төрийн сангаас санхүүждэг үйл ажиллагаануудыг ямар нэг доголдолгүйгээр бүрэн санхүүжүүлж ирлээ. Энэний нөгөө талд мэдээж инфляцад идэгдсэн, инфляцаар үр өгөөж нь буурсан зүйлүүд байлгүй яах вэ. Гэсэн хэдий ч энэ бүх үйл ажиллагааны үр дүнд ДНБ 2 дахин өслөө. Нэг хүнд ноогдох үндэсний орлого маань мөн 4 мянга орчим байсан бол ирэх жил 6 мянган долларт хүрэхээр ийм нааштай үзүүлэлтүүдийг бид удирдаж бий болгож чадсан гэж үзэж байгаа юм.

Гол санаанууд ингэж байна. Дутуу зүйл байвал Баттөмөр гишүүн надад хэлээрэй. Би нэмж хариулахад бэлэн байна.

Г.Занданшатар: Би нөгөө Их Хуралтай холбоотой юм болохоор нэг юм тодруулчихъя. 20 оны 8 сард ямар өөрчлөлт, яг ямар зүйл, заалтаар ямар өөрчлөлт орсон гээд та хэлчихэв. Би 20

оны 8 сард өөрчлөлтийг хайгаад ямар ч өөрчлөлт ороогүй байна л даа. Хамгийн сүүлд 23 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Сангийн яамнаас өргөн мэдүүлсэн төсвийн тодотголыг хэлэлцэхдээ дагаж оруулж ирсэн хуулийг чинь л баталсан. УИХ санаачилж Ирээдүй өв сангийн тухай хуульд ерөөсөө өөрчлөлт оруулаагүй. Та нарын баталсан хууль гэсэн агуулгатай хэлээд байна л даа.

Жавхлан сайд, Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Би Их Хурлын даргаас уучлалт хүсэж байна. Ирээдүй өв сангийн тухай хууль гээд би буруу хэлчээж. Ирээдүй өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль шүү. Энд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан 2 зүйлийг би уншиж дуулгая.

5.1 дүгээр зүйл дээр. Ирээдүй өв сангийн хөрөнгийг 2025 он хүртэл Засгийн газрын гадаад өрийн дарамтыг харгалзан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах, мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хуримтлуулна гэж байгаа юм.

5.2 дээр нь Ирээдүй өв сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг 25 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө гэж байгаа юм. Энэ нь нөгөө корпорацын үйл ажиллагааг нь хэлж байгаа юм.

Г.Занданшатар: Баттөмөр гишүүн тодруулъя гэсэн үү? Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Яах вэ, ер нь Монгол төгрөг маань өдөр тутам цаас болоод байгаа шүү дээ. Сая яах вэ, нүүрс дээр хийсэн менежмент, уул уурхайн бирж гээд ингээд арга хэмжээ авсны оронд Монголд валют их хэмжээгээр орж ирээд, хани тогтвортой байна. Цаашидаа тогтвортой байна гэсэн баталгаа

байхгүй байгаа. Сайдын хэлж байгаагаар яах вэ, 2024 оны эцэст нэг 4 их наяд гаруй төгрөг болох юм байна л даа. Яг үнэ цэнээ хадгалж чадах уу, үгүй юү? Энэ мөнгө өнөөдрийн энэ үнэ цэнээ хадгалж чадах уу, үгүй юү. Аливаа юмны үнэ цэн чухал шүү дээ. Тийм ээ, тэр тоо чухал биш. Энэ утгаар л асуугаад байгаа юм л даа, 1 дүгээрт тэр.

2 дугаарт нь, энэ Баялгийн санг Засгийн газрын хариултад цаашид ер нь Ирээдүй өв санг хэрэггүй юм байна, Баялгийн сан байгуулна гэж. Ирээдүй өв сан гэдэг чинь Баялгийн сан шүү дээ, нэг л нэршил нь шүү дээ. Норвегийн баялгийн сан гэж байгаад л тэтгэврийн сан болсон шүү дээ. Тийм учраас энэ Ирээдүй өв сангийнхаа менежментийг 25 оныг хүртэл ингээд байлгаад байх уу, яах юм. Энэ хууль энэ тэрдээ өөрчлөлт энэ тэр хийгээд дотоодын зах зээлдээ оруулдаг барьдаг ийм юм үр ашгийг нь ярь ... /минут дуусав/

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Баялгийн сантай холбож яривал би нэг зүйл дээр маш хатуу байдаг хүн шүү. Одоогоор яах вэ, Баялгийн сан дээр хэд хэдэн хувилбарууд ингээд л яригдаад л байгаа юм. Баялгийн сан яаж явах юм, би урьдчилж хэлж мэдэхгүй байна. Гэхдээ бид ямар ч тохиолдолд Ирээдүй өв сандаа өөрчлөлт оруулж боломгүй юм байна лээ. Одоо байгаа энэ яг энэ хуулиараа өнөөдөр олж байгаа газрын баялгаас олж байгаа энэ ашгийг, өгөөжийг ирээдүй хойч үедээ хадгалж үлдээх нь. Тэгээд тэр үед яаж юундаа зарцуулах нь хойч үе маань өөрсдөө шийдэг. Би ингэж боддог хүн. Ийм байр сууриа ч гэсэн Баялгийн санг ярьж байгаа энэ хувилбарууд дээрээ би энийгээ хатуу хэлж байгаа.

Өнөөгийн үнэ цэн дээр алдаж байгаа гэдэг дээр би тантай ерөнхий агуулгаараа бид санал нийлж байна. Бид гашиун туршлагатай. Үүнийг үнэ цэнийг нь алдуулахгүй өсгөх гэж байна гээд

аваачаад банкнууд дээр ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сан ... /минут дуусав/

Г.Занданшатар: Уг нь Ирээдүйн өв сангийн тухай хууль маш сайн хууль байсан. Одоо ч мэдэхгүй ээ, одоо.

Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Баярлалаа. Ирээдүйн өв сангийн тухай хууль ер нь бид нар түрүүн яриад байна л даа. 4,3 их наядын хуримтлал байгаа. 2,7 нь бодит мөнгөн дүнгээр гэж байна. 1,6 нь яг ямар хэлбэрээр байгаа юм бэ? Энэ дээр нэг асуулт асуучихъя. Яах вэ, ер нь зүгээр бид нарын Баттөмөр гишүүн тодорхой л асуугаад байна л даа. Яг энэ үүргээ гүйцэтгэж байгаа юм уу? Зүгээр Төрийн сангийн нэг бичилт дээр тавьчхаад тэр нь өөрөө цаг хугацааныхаа хувьд ханшийн зөрөө, өнөөдрийн үнэ цэн нь буураад байдаг, арвижна гэхээсээ илүүтэй арвижиж байгаа нэртэй харагдавч цаанаа эргээд агуулгаараа нөгөө үнэ цэний бууралт нь өнөөдрийн хийж байгаа мөнгө хоёрынх нь зөрөө дээр эргээд л алдагдалтай ийм нэг сангийн асуудал харагдаад байна л даа. Энэ жилийн хувьд 24 он. Энэ жилийн төсөв дээр 24 онд 1,3 их наядаар сан нэмэгдэх юм байна. Ер нь жил болгон өөр байгаа. Тэгээд 22 онд бүр 1 төгрөг ч нэмэгдээгүй шүү дээ. Тийм ээ. Энэ жилийн хувьд 550 гэсэн үү, 50 тэрбумаар нэмэгдэж байгаа юм байна. Тэгэхээр энэ олон энэ ялгаанууд нь та бүхэн бас яг энэ ард иргэдэд бас бодит яагаад 1,3-аар өсөхөөр томъёолж байгаа юм. Яагаад 22 онд Ирээдүй өв сан маань 1 ч төгрөгөөр нэмэгдээгүй юм гэдэг энэ асуудлууд дээр бас хариулт авчихъя.

Тэгээд найдвартай хадгална гээд нэг үг хэрэглээд байна л даа. Найдвартай хадгалалт гэдэг нь яг ямар хадгалалт юм бэ? Эрүүл мэндийн болон нийгмийн даатгал дээр зарцуулалтын буруу алдаанаас болоод гээд. Үүнийг нь ард иргэд мэдээд байна л даа. Хүмүүс ойлгоод байна. Тэгэхдээ буцаагаад асуучихъя. Тэр

найдвартай хадгалалтаа нэг сайхан тайлбарлаад өгөөч.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ганибал гишүүний асуултад хариулъя. Сүүлийн хэсгээс нь эхэлье. Найдвартай гэдэг нь Монгол Улсынхаа Төв банкныг л хэлж байгаа юм. Төв банк дээрээ байришиж байгаа нь бид Төв банкандаа итгэхгүй өөр хэнд итгэх вэ. Ирээдүй хойч үедээ эхлээд нэг бүтэн хүлээлгэж өгөх нь их чухал байгаа. Бүтэн. Бид мөнгөгүй байх хэцүү, жоохон мөнгөтэй болохоор бүр хэцүү юм. Тал тал тийшээ ингээд татаж авч явах гээд. Илүү өгөөжтэй болгох гээд өөр газар аваачиж хадгалаад бүр алдаж байхаар, ямар ч байсан бид хуулиар өгсөн даалгаврын дагуу 2024 оны 12 сарын 31 хүртэл хуримтлуулахаар 4,3 ойролцоогоор болж байгаа юм шүү, Ганибал гишүүн ээ. Тэрийг хэлж байгаа юм шүү, ирээдүйд болохыг хэлж байгаа юм. Өнөөдөр бол 2,7 их наяд. Нөгөө 4,4 их наяд гэдэг маань өнөөдөр манай Төрийн сан төв банк дээр байгаа төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,3 орчим их наяд байгаа юм. Би 1,4 их наядтай хүлээж авсан юм, Төрийн сан. Одоо Төрийн сан маань 4,3 их наяд төгрөгийн бэлэн мөнгө байж байна.

Нөгөө дансандаа хуримтлагдаж байгаа ирээдүй өв сангийн үлдэгдэл маань яг өнөөдрийн байдлаар 2,7 их наяд. Ингээд хойтон бол нэг 4,3 орчим болно. Тэгээд энэ мөнгө, үүнийг яг мөнгөн хөрөнгөөр 100 хувь корпорацад хүлээлгэж өгөөд, ёстой тэрнээс цааш яаж хөрөнгө оруулалт хийж, яаж өсгөх нь корпорацын хариуцлага болоод ингээд явах юм байгаа юм. Ийм л юм байгаа юм.

Зүгээр өнөөгийн үнэ цэн, инфляц ярих юм бол ер нь дэлхий нийтээрээ сүүлийн 3 жил маш их үнэ цэнээ алдсан. Мөнгө, өртөг маш их нэмэгдсэн. Бодлогын хүү өндөр боллоо. Гадаад зах зээл дээрээс бид нарын авах эх үүсвэр, өр зээлүүд маань бас их үнэтэй болсон. Гэсэн хэдий ч

бид нар энийгээ гадна талдаа гадаад өр, Засгийн газрын зээллэгээ маш сайн удирдаж чадсаны үр дүнд өнөөдөр бид ямар нэг гадаад өрийн дарамтгүй, гадаад өрийн дефолт болох ийм аюулгүй явж байна. Тийм учраас Ирээдүй өв сангийнхаа энэ хуримтлал маань яг хуулийн хүрээнд, бүрэн найдвартайгаар, хуримтлагдаад, нэмэгдээд явж байгаа гэдгийг албан ёсоор хэлье.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн. Одонгийн Цогтгэрэл гишүүн, Одонгийн Цогтгэрэл гишүүн. Одонгийн Цогтгэрэл гишүүн картаа ахиж уншуулахгүй бол карт уншигдаагүй байгаа юм шиг байна. Харин нэр орчихсон байх юм. Тэгээд гаргачихсан юм уу, яасан юм.

О.Цогтгэрэл: Ирээдүйн өв сангийн хууль 2016 оноос батлагдаад, хэрэгжээд явж байгаа. Тэгэхдээ агуулгын хувьд асар их зөв хууль. Яг бодит байдал дээр зөв хуулийг хэрэгжилт нь тааруу болохоор бас ямар үр дүнтэй байдгийн жишээ Ирээдүйн өв сан дээр л явж байна л даа. Сан гэсэн нэртэй, өнөөдөр Сангийн яамны нэг данс. Сан гэдэг зүйл чинь уг нь удирдлага менежменттэй, тэрийгээ дагаад удирдан зохион байгуулдаг, өсгөн үржүүлдэг, үнэ цэнийг нь нэмэгдүүлдэг, тэр зорилго бүхий зүйлийг Сан гэж байгаа байх. Одоо бол Сангийн яамны нэг данс, ерөөсөө л тэнд нэг данс. Тэгээд энийгээ бид нар их Ирээдүйн өв сангийн удирдлага менежмент бүхий сан. Уг нь хуулиараа удирдлага менежментийн компани, корпорац байгуулагдах ёстой. Ассет менежментийн буюу хөрөнгийн удирдлагын компани дагаж байгуулагдах ёстой. Энэ бүх зорилгууд ингээд өнөөдөр байхгүй. Өнгөрсөн хугацаанд алдагдсан боломж, хуримтлагдсан байх боломж гээд ярих юм бол олон тоо ярьж болно. Зөвхөн зарим ерөнхий тооцоогоор өнөөдөр хэрвээ төсвийн алдагдлыг нөхөөгүй, элдэв алдагдлын оронд үүнийг зарцуулаагүй байсан бол магадгүй 9 их наяд, 10-аад их наяд төгрөг өнөөдөр энэ санд хуримтлагдсан байгаад дахиад энэ

дээр удирдлага менежмент хийгдсэн байх ёстой гэсэн тооцоолол ч бас энд явдаг.

Тэгэхээр энэнтэй холбоотой бид нар олон зүйл ярьж болох юм байна лээ. Ер нь Монгол Улс нүүрсний экспорт ярьж эхэлснээс хойш бараг 2005, 2006 оноос эхэлж ярих юм шиг байгаа юм. Бас олон олон тоо байдаг ч гэсэн нэг 70-80 тэрбум долларын борлуулалтууд хийсэн. 20-оод жилийн хугацаанд. Энэ чинь бараг 3-аас 400 их наяд төгрөгийн борлуулалт. Энэнээс өнөөдөр хуримтлагдсан байгаа хэмжээгээ ингээд аваад үзэх юм бол үндсэндээ 1 хувийг нь л бид нар Ирээдүйн өв сандаа хадгалж байна. 1 хувийг нь. Энэ тэгэхдээ миний хэлж байгаа тоо биш энэ Дэлхийн банкнаас гаргасан ийм мэдээлэл ч бас явж байсан байх. Бид нар Ирээдүйн өв санд энэ уул уурхай, газрын баялгийн борлуулалтын 1 хувийг л өнөөдөр бид нар хадгалж байна. Тэгэхээр энэний цаана бид нар бодлогын хувьд хийх ёстой асар олон зүйлс энэ дээр яригдах нь. Бид нарын энэ нэг бүгдээрээ л тооны машин аваад бодож үздэг тоогоор бол өнөөдөр хэрвээ 9 их их наяд байсан бол 3 сая иргэнд хуваахаар иргэн бүхэнд, иргэн бүхэнд үндсэндээ дахиад 3 сая орчим ингээд ийм Ирээдүйн өв санд нь ийм үнэ цэн бүхий мөнгө хадгалагдаж байх ёстой байж. Энэ бүгдийг байж байж гээд яриад байвал асар олон зүйлүүдийг бид нар ингээд ярьж болно.

Тэгээд энэ бүгдтэй холбоотойгоор ер нь энэ Засгийн газраас энэ уул уурхайн орлого энэ нөхөн сэргээгддэггүй энэ орлоготой холбоотойгоор Баялгийн сангийн хууль гэдэг дээр ямар бодлого чиглэл барьж байгаа вэ? Энэ дээр шинээр тийм тодорхойлсон бодлогын баримт бичиг ойр орж ирэх үү? Зөвхөн Ирээдүйн өв сан тогтворжуулалтын сангаас ... /минут дуусав/

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ирээдүй, өв сангаа хамгаалж, энэ найдвартай өсөж байх

ёстой гээд энэ ерөнхий агуулгатай би 100 хувь санал нийлж байна. Төсвийн алдагдалд зориулдаг сан бол хуулиараа Тогтворжуулалтын сан гээд тусдаа шүү. Ирээдүй өв сан бол алдагдалд зориулагддаг тийм сан биш. Байнга хуримтлагдаад нэмэгдээд явж байдаг. Өнөөдрийг хүртэл нэмэгдээд бий болсон хуримтлал нь 2,7 их наяд. Энэ жил нэг 550 орчмоор нэмэгдэнэ. Хойтон оруулж ирсэн төсвийг хойтонгийн төсвийг та бүхэн харж байгаа байх. Түүн дээр 1,3 орчмоор нэмэгдэхээр. Ингээд 24 оны 12 сарын 31 гэхэд одоо төсөөлж байгаагаар нэг 4,3 орчим болох болов уу гэж ингэж харж байгаа юм. Тэр үед нь хуулиараа ингээд тусгаарлаад корпорацад нь хүлээлгэж өгөөд, жинхэнэ яг ассет менежментийнхээ ийм утгаараа явна. Гэхдээ би тэр ассет менежментийг тэр 25 оноос хойших ирээдүйд одоогийнхоосоо илүү их санаа зовж байна. Тэнд их найдвартай сайн зарчим баримтлаасай. Тэр нь юу вэ гэхээр энэ манай Төв банкны хууль дээр Монгол Улсын валютын нөөцийг яаж хадгалах талаар нэг ийм зарчим байдаг юм. Та нэг уншихвал бас их илүүдэхгүй шүү. Энэ их мундаг зарчим байдаг юм.

Монгол Улсын валютын санг, валютын нөөцийг эхлээд найдвартай хадгалах ёстой.

2 дугаарт, хөрвөх чадвартай байх ёстой. Энэ 2 хангагдаж байвал өгөөж хайж болно гэж байгаа юм. Хадгаламжийн даатгалын корпорацын хууль дээр ч гэсэн яг энэ утгаар нь би бүр яг энэ заалтыг би оруулж байсан юм. Тэгэхээр 25 оноос хойш ажиллах тэр ассет корпорац ийм зарчмыг бариасай. Тэгэхгүй ингээд үүнийг өгөөж яах гэж байна, өгөөж нэмэх гэж байна, ашиг олох гэж байна гээд нэг баахан хувьцаа авчихдаг, хөрөнгө оруулалт хийчихдэг, тэгээд энэ бүр нэг нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сан шиг ингээд дампууруулаад хаячих вий дээ. Тийм учраас тэр хуульд нь бас нэмэлт, өөрчлөлт оруулмаар юм байна лээ. Бүр чангалж өгөөд. Хамаагүй бас ийш тийш

нь хөрөнгө оруулаад явчхаж болохгүй. Их өгөөжийн цаана их эрсдэл байдаг гэдгийг маш сайн санах хэрэгтэй. Энэ зарчим дээр. Би дахиад хэлье. Мөнгөгүй байх хэцүү байдаг, мөнгөтэй болохлоор ингээд тал тал тийш нь татаж авч явчих гээд өгөөж хайна. Ингэж өсгөнө, тэгж хуримтлуулна гээд бүр эрсдэлд оруулаад хаячих вий. Ямар ч байсан үүнийг нэг бүтэн хүлээлгээд өгчих ийм зорилготой бид ажиллаж байна. Яг энэ Сангийн яам бидний яг энэ үе. Тэгээд яг ийм нэг гэрийн даалгавартай ажиллаж байгаа гэсэн үг.

Баялгийн сангийн талаар яах вэ, оруулж ирээгүй, өргөн баригдаагүй хууль дээр би янз бүрийн юм түрүүлж яримааргүй байна. Жоохон санал зөрөөтэй зүйлүүд байгаа. Жишээ нь Ирээдүй өв сан байна. Ирээдүй өв санг Баялгийн сантай хутгамааргүй байгаа юм. Яг энүүгээр нь хуримтлуулаад л хойч үедээ 30 он гэж байгаа, хүлээлгээд өгчих хэрэгтэй, өсгөөд, хуримтлуулаад. Тэрнээс хойш ёстой юунд яаж зарцуулахыг хойч үе нь шийдэх байх.

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна.

О.Цогтгэрэл: Ирээдүйн өв сан үндсэндээ төсвийн алдагдал руу шууд бус утгаараа зарцуулагдсан л даа. Өнгөрсөн жил хүүхдийн мөнгийг Ирээдүйн өв сангаас өгсөн. Үнэндээ хүүхдийн мөнгийг төсвөөс тавьж өгнө гэсэн, өгч явж байсныг төсвөөс өгөлгүйгээр Ирээдүйн өв сангаас өгчихнө гэдэг чинь яг үнэндээ төсвийн алдагдлыг л өнгөрсөн жил санхүүжүүлсэн шүү дээ. Харин ч алдагдлын хувь хэмжээгээ өөр газраас санхүүжүүлээд хувь хэмжээ бага харагдсан. Ийм талууд байгаа.

Тэр Баялгийн сангийн хууль үнэхээр цаг үеийн хувьд өнөөдөр энэ уул уурхайн баялагтай холбоотой төрийн өмчүүд, энэний цаана хулгай зэлгий, энэний цаана бид бүгдийн хувьд асар олон зүйлс ирээдүйдээ өр биш өв үлдээх бодлого, дахиад иргэн нь халамжаар биш иргэн нь хувьцаатай иргэн, хөрөнгө оруулагч

иргэний чиглэлд хийгдэх энэ Эрдэнэс тавантолгойгоос эхлээд энэ бодлогын энэ хувьцаа гээд бас энэ хоосон дансны бичилтүүдээс эхлээд энэ олон зүйлийг яг улс орны хөгжлийн төлөө иргэн баян бол улс нь баян байдаг тэр зарчмын төлөө хийхэд үнэхээр ... /минут дуусав/

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Төсвийн алдагдлыг бууруулсан гэж яримааргүй байгаа юм. Бид төсвийн бөгөөд нийгэм эдийн засгийн маш хүнд үеийг л тууллаа шүү дээ, хэдүүлээ. Бид маш амархан гэж мартаж болохгүй. Төсөв бид 8,8 их наяд, мөнгөн дүнгээр хувиар бол 12 хувийн алдагдалтай ийм төсөв бид хүлээж авч байсан. Хэдүүлээ хамтдаа Цогтгэрэл гишүүн ээ, манай цөөнхийн бүлэг энэ манай төсвийг маш сайн ойлгож дэмжиж ингэж ажилладаг, маш амжилттай алдагдлуудаа ингэж бууруулж ирж чадсан. Хойтон 2,8 хувь дээр ирж байгаа. Тэрнээс хойш энэ алдагдлыг бүр тэглэх ийм бүрэн боломжуудыг суурийг нь хэдүүлээ ингээд тавьж өгсөн.

Ирээдүйн санг бид төсвийн хүнд үед, магадгүй хүүхдийн мөнгө бүр тавьж чадахгүй байх тийм хүндрэлтэй төсвийн үед, энэ Ирээдүйн өв санг ирээдүйн иргэддээ зориулж ... /минут дуусав/

Г.Занданишатар: Төсвийн байнгын хороо дээр энэ Ирээдүйн өв сангийн талаар нэг судалгаа хийгээд байсан. Тодруулж хариулж болно шүү дээ. Тэр алдагдсан боломжийн өртөг нь биш, хуримтлагдах боломж алдсан өртөг нь 10 их наяд төгрөг байна, энэ тэр гээд та нэг судалгаа хийсэн гээд байсан түүнийгээ нэг юу яаж хараад хэлээрэй.

Жамбын Батсуурь гишүүн. Одоо хариулах юм уу? Жамбын Батсуурь гишүүн.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр үг хэлнэ.

Б.Баттөмөр: Энэ Ирээдүй өв сангийн энэ эх үүсвэр их тодорхой шүү дээ. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч төрийн өмчтэй компанийн төрд ноогдох хувьцааны ноогдол, ашигт малтмалын нөөц ашигласан татвараас тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийг нь 65 хувь гэсэн 2 эх үүсвэрээс л бүрдэж байгаа юм. Ингээд нэг 5,4 их наяд төгрөг цугларсан байна. 2,7 их наяд нь хадгалагдаж байна.

Ирээдүй өв сангийн хөрөнгийг 2025 оныг хүртэл ашиглахгүй гээд шийдчихсэн. Энэ хуулийн 6.3.1-д сангийн хөрөнгийн үнэ цэнийг хадгалах, арвижуулна гээд заачихсан байгаа юм. Харамсалтай нь арвижаагүй, үнэ цэнээ алдчихсан. Хувь хүн хэрвээ байсан бол өөрийнхөө мөнгийг ингээж хадгалахгүй шүү дээ. Тийм ээ. Тийм учраас төрийн мөнгө учраас эзэнгүй байна л даа. Хариуцах ёстой хүмүүс нь санаачлахгүй ажиллаж байна гэж би бодож байгаа юм.

Ирээдүйн өв сангийн удирдлагыг корпорац хэрэгжүүлнэ. Корпорацаа байгуулсан. Корпорац юу гэхээр цаашаага ажиллаагүй. Шалтгаан нь ковид, гадаад валютын албан нөөц, гадаад нөхцөл байдал гэсэн ийм шалтгаанаар ажиллаагүй. Хуульд заасны дагуу сангийн хөрөнгийг корпорац мандат заасны дагуу удирдана гэсэн. Мандатыг 2020 оны эхэнд баталчихсан. Тэгээд “А” /эй/ нэмэх дээр зэрэглэлтэй Засгийн газрын үнэт цаас 90-100 хувь, “А” /эй/ нэмэх буюу түүнээс дээш зэрэглэлтэй Засгийн газрын инфляцаар индексжүүлсэн үнэт цаас байна гээд заасан. Энэ их л том өндөр шаардлага л даа. Тэгээд үнэт цаасанд тавих шаардлага гэдгийг 3 “А”, тэгээд 2 “А” гээд нэмэх өндөр шаардлага тавьсан боловч хэрэгжээгүй.

Хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшин нь АНУ-ын Засгийн газрын 5

жилийн хугацаатай үнэт цаасны өгөөжийн түвшинээс багагүй байна гэсэн. Тэгээд нэгэнт ажиллаагүй юм чинь энэ бас байхгүй байгаа.

Сангийн хөрөнгийг ам.доллароор гаргачихсан санхүүгийн хэрэгсэлд оруулна гэсэн, оруулаагүй. Сан ажиллаж өгөөжөө олох боломж байсан уу гэвэл байсан. Тэгээд энэ хуулийг гаргахдаа магадгүй алдаа гаргасан байж магадгүй, засаад явах боломж байсан. Харамсалтай нь засаагүй ганц ам.доллароор биш үр өгөөж өгч болох үнэ цэн байвал бүх валют байж болно. Монгол төгрөгөөр ч гэсэн эх орны бүтээн байгуулалтад хөрөнгө оруулах гээд их өгөөжтэй байсан. Энэ байгаагүй. Өндөр үр ашигтай эрсдэлгүй багцад хөрөнгө оруулна гэж хаширлаад өөрөө өөрийгөө шалтгаалд л яваад байна л даа.

Гаднын 3 байгууллага ажиллаж гэсэн. 11 байгууллагаас 3 байгууллага нь ажиллаж гэсэн. Тэгээд тэндээ яаж ажилласан юм? Тодорхойгүй. Засгийн газрын хариултад тодорхой юм ажиглагдаагүй.

Монголбанк, Сангийн яам 2 зардал дээрээ тохироогүй. Энэ 2 байгууллага юу гэхээр Сангийн яам Засгийн газрынх, Монголбанк Улсын Их Хурлын байгууллагын хувьд бол Улсын Их Хурал Засгийн газрын түвшний энэ асуудлыг яриад шийдэх боломж байгаагүй юм уу?

Одоо нийслэл бонд гаргах гэж байгаа юм. Жилийн 17 хувийн өгөөжтэй. Энэ бас найдвартай бонд гэж би харж байгаа юм. Ингээж хадгалж байснаас энэ бондод оруулдаг барьдаг энэ эрх зүйн орчныг нь бид нар бүрдүүлбэл яасан юм бэ гэж.

Тэгээд ингээд Засгийн газрын тэр санал дотор энэ Ирээдүй өв санг Баялгийн сан болгож удирдана гээд өгчихсөн байгаа. Сая Сангийн сайд Баялгийн сангаа юу, Ирээдүй өв сангаа цаашаа явуулна гэж. Би ч гэсэн яг тийм бодолтой л байгаа. Тэгээд үүнийг үзнэ биз дээ. Энэ

Ирээдүй өв сан бол Баялгийн сангийн нэг төрөл шүү дээ.

Тэгээд бид нар муу ажиллаж л байна л даа. Энд бол Норвегийн Тэтгэврийн сан Тимасек гээд Кувейтийн сан гээд их том том бид нар юм ярихаа больё л доо. Бидэнтэй адилхан нэг гараанаас гарсан Казахстан улс, Самарук гээд Хөрөнгө оруулалтын сан байгуулаад 65,8 тэрбум долларын хуримтлал бий болгочихсон байна шүү дээ. Монгол Улсын ДНБ-ээс 3 дахин, Монгол Улсын төсвийн орлогоос 9 дахин ийм их хөрөнгө оруулалтыг бий болгочихсон байж байна шүү дээ. Тэгээд ОУВС-ийн тодорхойлолтод Баялгийн сан нь Засгийн газрын өмчид байдаг тусгай зорилго бүхий хөрөнгө оруулалтын сан байна гээд ингэж заачихсан. Тэгээд би бодохдоо 25 оны энэ хугацааг эргээж харах хэрэгтэй. 25 оныг хүртэл цаг хугацаа яаж өөрчлөгдөхийг мэдэхгүй. Хугацааг өөрчилж, үр ашигтай зүйлд хөрөнгө оруулалт хийж, үр ашгийг нь дээшлүүлэх ёстой гэж.

22 оны эхэнд 1 ам.доллар 2700 орчим төгрөг байсан. Өнөөдөр энэ доллар тэр доллароор нь тооцох юм бол 1 тэрбум орчим долларын мөнгө байсан. Гэтэл өнөөдөр 750 сая төгрөг болоод үнэ цэн нь 250 сая доллароор буурсан. Энэ юу гэхээр 850 тэрбум төгрөгөөр үнэ цэнээ алдсан гэсэн үг. Тэгээд харамсалтай байна л даа.

Ирээдүйн өв сангийн хуулийн 13.1-д Монгол Улсын сан нийт ард түмний өмч байна гэж байгаа юм. Ард түмний ... /минут дуусав/

Г.Занданшатар: 5 минутаар нэг л үг хэлж байгаа. Тэгэхдээ энэ чухал асуудал учраас, энэ Улсын Их Хурлын тогтоол хэрэгжихгүй байгаа учраас энэ Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг энэ Ирээдүй өв сан, Үндэсний баялгийн сангийн холбоотой ажлын хэсэг ярьж байгаад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга 91 Даваасамбуу

гуай энд тайлбар хийнэ гэсэн байна. Холбогдуулж. 91.

Д.Даваасамбуу: Эрхэм гишүүдийн амрыг эрье. Энд суусан нөхдийн бас амар мэндийг эрье.

Тэгэхээр би энэ дээр өөрийн л хувийн санал, дээрээс нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тавьж байгаа саналыг та бүгдэд танилцуулъя.

Эхлээд Ирээдүй өв сангийн 2024 оны төсвийн тухайд нэг зүйл хэлье. Энэ маань эндээс хүүхдийн мөнгө олгоно гэж байгаа. Тэгэхээр энэ хүүхдийн мөнгийг ямар хэлбэрээр олгох нь зүйтэй вэ гэсэн саналыг хэлэх гэсэн юм.

1 дүгээрт, халамжийн хуулийн дагуу нийгмийн эмзэг хэсгийн хүүхдүүдэд мөнгийг нь олгоод юу гэдэг юм 1,6 их наяд төгрөгөөс 200 тэрбумыг нь нийгмийн эмзэг хэсгийн хүүхдэд олгох юм гэж бодъё. Үлдсэнийг нь бүх хүүхдүүдэд, саяын тэр нийгмийн эмзэг хэсгийн хүүхдүүд мөн боломжтой айлын хүүхдүүд бүх хүүхдүүдэд тэр хуулийнхаа дагуу хадгаламж хэлбэрээр олгоё гэсэн. Энэ маань өөрөө бид бас төсөв маань нэлээн тэлэлттэй, инфляцыг хөөж магадгүй гэсэн байгаа учраас нийт эдийн засгийнхаа тогтвортой байдлыг хангахад илүү үр дүнтэй байх гэж ойлгож байгаа юм. Энэ чиглэлээр хуучин 2 жилийн өмнө ч билүү Сангийн яам маань бас үүнийг хүүхдүүдийн хадгаламж болгочихъё гэсэн байсан. Гэхдээ бас нийгмийн эмзэг хэсгийн хүүхдүүд хүнд байдалд орчих гээд байгаа учраас 100000-ыг нь өгдгөөрөө өгье, дээрээс нь нэмээд хадгаламж болгоод өгчихье. Ингээд 16-18 нас хүрэх үедээ бас ирээдүйдээ итгэлтэй, сургуульд цаашидаа суралцах боломжтой, мэргэжлийн баримжаа олгох ийм боломжтой болгоно гэсэн ийм ойлголт байгаа.

Баялгийн сангийн тухайд би юу хэлэх вэ, зүгээр ер нь манай 2019 онд оруулсан Үндсэн хуулийн өөрчлөлт дээр Баялгийн сантай байна л гэж байгаа.

Тэгээд газар түүний хэвлийн бүх баялаг бол төр, нийтийн өмч байна гэсэн. Тэгэхээр энэ маань юу гэсэн ойлголт байна вэ гэхэд би бодохдоо роялти буюу эзний өмч бол роялти байх нь. Одоо ашигт малтмалын нөөцийн төлбөр бол нэг үгээр хэлэхэд баялгийн сангийн гол эх үүсвэр байх нь. Тэгээд Үндсэн хуульд юу гэж заачихсан байна вэ гэхээр үүнийг дийлэнхийг ард түмэнд олгоно гэж. Тэгэхээр энэ дийлэнх нь ард түмэн гэдэг маань өөрөөр хэлэх юм бол улсын нэгдсэн төсөв болох төсвөөр дамжуулж ихэнхийг нь хуваарилна. Гэхдээ нэгэнт бид бас Ирээдүй өв сан хуримтлалын сангууд байгаа учраас энэ хуримтлалын сангуудаа бий болгоё, баялгийн сангаасаа дотроос нь. 1 дүгээрт, Ирээдүй өв сангийнхаа мөнгийг нэмэгдүүлэе. Дээрээс нь ноднин манай Улсын Их Хурлаас маш их зарчмын холыг харсан том шийдвэр гарсан. Тэр бол энэ оны 07 дугаар сарын 07-нд Нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлт оруулсан. Энэ хуулиар иргэд маань, иргэд маань нийгмийн даатгалынхаа шимтгэлийн 2 хувийг Ирээдүйн тэтгэврийн нөөц сан хэлбэрээр байлгая гэж. Үүнийгээ цаашидаа дэс дараатай нэмэгдүүлнэ ээ гэсэн хуулийн заалт байгаа. Энэнээс үүсэлтэй доторх мөнгөө баялгийнхаа ашиглалтын өсөлтөөр төрийн алдагдлаа нөхөөд явъя. Иргэддээ хадгаламжтай болгоё гэсэн. Энэ учраас Үндсэн хуулийн үндсэн зарчим шинэ Үндсэн хуульд орсон шинэ зарчим ёсоор ирээдүй ба өнөөгийн үеийнхэнд тэгш, хүртээмжтэй, шударга хуваарилна гэсэн байгаа.

Тэгэхээр ирээдүйд нэг хэсгийг нь үнэхээр идчихгүйн тулд нэг хэсгийг нь хүүхдийн хадгаламжаар, нөгөө хэсгийг нь 18-аас ажил эрхлэгчдийн тодорхой шимтгэлийг нь өөрт нь үлдээдэг дэлхийн жишиг. Ингэснээрээ Монгол Улс бол ирээдүйдээ жинхэнэ хуримтлалтай өөр орон болно. Үүний үндсэн дээр бид нарын өнөөдрийн яриад байгаа нөгөө 2030 буюу удаан хугацааны хөтөлбөр, сэргээн босголтын томоохон хөтөлбөрүүдийг ... /минут дуусав/

Г.Занданишатар: Баттөмөр гишүүн 1 минут гүйцээгээд санал хэлчихье. Сая 4 минутаар явсан уу, 5 минутаар явсан тийм үү. Дэгээр бололцоо байгаа юу, болох уу.

Баагаагийн Баттөмөр гишүүн 1 минут. 4 минутаар ярьсан.

Б.Баттөмөр: Ирээдүйн өв сангийн хөрөнгө 2024 оны эцэс гэхэд 4,3, 4,5 орчим их наяд төгрөг болох юм байна. Хуримтлал үүсгэж болно, хадгалж болно. Үнэ цэнийг нь яаж хамгаалах вэ, яаж үр өгөөжтэй нэг авч явах вэ гэдэг асуудал бол бодох ёстой асуудал болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр би юу гэж хэлэх юм гэхээр зэрэг 25 он гэдэг хугацаагаа дахиж хараач ээ. Энэ ам.доллартой ханиих Монгол төгрөгийн ханиийн уналтаар ингээд тооцохоор энэ чинь 250-аад сая доллар л байхгүй болчихоод байгаа байхгүй юу. Үүнийг Монгол төгрөгөөр харьцахаар 800-аад тэрбум төгрөг болно. Ийм үнэ цэнийн алдагдал бий болчихсон байна гэж. Ингээд энэ Ирээдүй өв сангийн менежментийг ингэж цаашаа авч явж болохгүй ээ. Засгийн газар энэ дээр санаачилга гаргаж Их Хуралд оруулж ирэх. Энэ янз бүрийн шалтаг, тэр ковид, Орос, Украины дайн ярих хэрэггүй. Орос, Украины дайн цахимаар явдаг энэ гадна, дотнын зах зээлд ажил энд ямар пад байна аа. Падгүй шүү дээ. Тийм учраас алдаагаа зас л гэж хэлье дээ.

Г.Занданишатар: Улсын Их Хурлын тогтоолоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2020 онд Засгийн газраас өргөн барьж батлах хуваарьтай байсан. Одоо хүртэл өргөн баригдаагүй байна. Үндэсний баялгийн сангийн тухай хууль анх батлагдахдаа 2075 онд 231 их наяд төгрөг хуримтлуулна, 2023 онд 40 их наяд төгрөг энэ санд хуримтлагдсан байна гэж тооцсон юм билээ. 2030 он хүртэл 100 их наяд төгрөг хуримтлуулна. Тэгээд 2030 оноос зарцуулж эхэлнэ гэсэн. Тэр хүртэл 1 ч төгрөг зарахгүй гэсэн. Гадаадын хувьцаа худалдаж авах юм дээр байршуулна гэж ингэж төлөвлөсөн ийм сан юм билээ. Энэ дараачийн хойчийн

үедээ тодорхой хувийг хүлээх ёстой гэж. Өөрөөр хэлбэл нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор энэ санг байгуулсан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ч гэсэн энэ агуулгыг оруулж, байгалийн баялгийн өгөөжийг одоо ба ирээдүй үеийнхэнд хүртээмжтэй, тэгш, хүртээмжтэй байх ийм агуулгатай сан байгуулна гэсэн ийм 2 агуулга байгаа.

Тэгэхээр энэ алдагдсан боломжийн өртөг гэж тооцож ярих юм бол энэ асар их тоо гарч байгаа байх. Тийм учраас бид энэ хуримтлалын сангийн үйл ажиллагаагаа үнэлгээ хийж, энэ бие даасан менежментийн зарчмаар явуулах, нэр дэвшүүлэх хороо байгуулах, бие даасан корпорац байгуулах, төлөөлөн удирдах зөвлөл сонгох журам, ингээд Сангийн сайд тэр 5 хүнтэй ТУЗ-тай 5 жилийн хугацаатай гэрээ байгуулж ажиллана энэ тэр гээд ийм нарийн, ийм ирээдүйн баялгийн сан маань ашигт малтмалын баялгийн сангийн маань хэлбэр маань ямар байдалтай болчихсон бэ гэдгийг хүмүүс та бүхэн ч сайн мэдэж байгаа.

Тийм учраас энэ Ирээдүй өв сан маань Ирээдүй өв сан байж чадаж байна уу, үгүй юү гэдэг дүгнэлт хийх цаг болчихсон. Нэг бол нэрийг нь өөрчлөх хэрэгтэй. Тэгээд Төсвийн байнгын хороо энэ талаар нарийвчилсан судалгаа хийчихсэн байгаа юм байна лээ. Хэзээ хэлэлцэх гэж байгаа билээ, Төсвийн байнгын хорооны дарга аа, Тэмүүлэн дарга аа. Та нар хэлэлцүүлнэ гээд л яваад байсан яасан. Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэн. Ганзоригийн Тэмүүлэн судалгаа, тайлан хийсэн. Ойрын хугацаанд оруулах юм байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан тавьсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо.

Зарлаж, мэдээлэх зүйлүүд юу байна. Зарлаж, мэдээлэх зүйлүүд байхгүй юу.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ